




---

# МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ТАЙЛАН

---

2015  
IX сар  
№5



---

**МОНГОЛ УЛСЫН  
САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ  
БАЙДЛЫН ТАЙЛАН**

---

Дугаар №5

Улаанбаатар хот  
2015 оны 9 дүгээр сар



*Энэхүү тайланг боловсруулахад хариуцсан чиглэлээр материал ирүүлэн,  
хамтран ажилласан Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хорооны  
холбогдох газрууд болон тайланг хянан тохиолдуулж, санал шүүмж өгсөн  
Монголбанкны Ерөнхийлөгчийн зөвлөх, Ерөнхий эдийн засагч С.Болдод  
талархал илэрхийлье.*

**НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:  
САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН  
ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА**

## АГУУЛГА

<b>ӨМНӨХ ҮГ</b>	<b>8</b>
<b>ТОЙМ</b>	<b>10</b>
<b>1. МАКРО-САНХҮҮГИЙН ОРЧИН</b>	<b>15</b>
<b>1.1 Дэлхийн эдийн засаг, санхүүгийн зах зээлийн тойм</b>	<b>15</b>
• Дэлхийн эдийн засаг	15
• Дэлхийн санхүүгийн зах зээл	18
<b>1.2 Монгол улсын макро эдийн засгийн тойм</b>	<b>23</b>
• Монгол улсын эдийн засгийн төлөв байдал	23
• Гадаад сектор	28
• Бодит сектор	35
• Мөнгө санхүүгийн сектор	38
• Улсын төсөв	41
<b>2. САНХҮҮГИЙН САЛБАР, ТҮҮНИЙ ДАРХЛАА</b>	<b>47</b>
<b>2.1 Банкны салбарын төлөв байдал</b>	<b>47</b>
• Банкны салбар	47
• Макро зохистой бодлого, түүний хэрэгжилт	56
<b>2.2 Банкны бус санхүүгийн салбарын төлөв байдал</b>	<b>60</b>
• Банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо	60
• Хөрөнгийн зах зээл	66
• Даатгалын байгууллага	70
• Зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэгч байгууллага	76
• Хөдөө аж ахуйн бирж ба түүхий эдийн арилжаа	77
<b>3. САНХҮҮГИЙН САЛБАРЫН ДЭД БҮТЭЦ, ТҮҮНИЙ ИНСТИТУЦИ</b>	<b>81</b>
<b>3.1 Хууль, эрх зүйн орчинд гарсан өөрчлөлт</b>	<b>81</b>
<b>3.2 Төлбөр тооцоо, хөрөнгийн бүртгэлийн систем</b>	<b>84</b>
<b>3.3 Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагаа</b>	<b>87</b>

**ШИГТГЭЭНҮҮД**

<b>Шигтгээ 1:</b>	Газрын тосны бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэл ба бодлого	33
<b>Шигтгээ 2:</b>	Хуримтлал ба эдийн засгийн өсөлт	36
<b>Шигтгээ 3:</b>	Мөчлөг сөрсөн өөрийн хөрөнгийн нөөц	58
<b>Шигтгээ 4:</b>	Санхүүгийн салбарын хөгжил	78

**ДҮРСЛЭЛҮҮД**

<b>Дүрслэл Т.1</b>	Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлын зураглал	13
<b>Дүрслэл 1.1</b>	Дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл	15
<b>Дүрслэл 1.2</b>	АНУ-ын зарим голлох үзүүлэлтүүд	16
<b>Дүрслэл 1.3</b>	Евро бүсийн ажилгүйдлийн түвшин	16
<b>Дүрслэл 1.4</b>	БНХАУ-ын нүүрсний импорт	17
<b>Дүрслэл 1.5</b>	Бүтээгдэхүүн, түүхий эдийн үнэ	18
<b>Дүрслэл 1.6</b>	Зарим Төв банкуудын мөнгөний бодлогын хүүний түвшин	19
<b>Дүрслэл 1.7</b>	Зарим хөгжингүй орнуудын Засгийн газрын 10 жилийн хугацаатай бондын өгөөж	19
<b>Дүрслэл 1.8</b>	Зарим хөрөнгийн захын индекс	19
<b>Дүрслэл 1.9</b>	Хятадын аж үйлдвэрлэлийн өсөлт ба Шанхайн хөрөнгийн биржийн индекс	20
<b>Дүрслэл 1.10</b>	Шанхайн хөрөнгийн биржийн индекс	20
<b>Дүрслэл 1.11</b>	Голлох валютуудын ам.доллартай харьцах ханш	21
<b>Дүрслэл 1.12</b>	Алт, зэсийн үнэ ба ам.долларын ханшийн индекс	21
<b>Дүрслэл 1.13</b>	Төлбөрийн тэнцлийн алдагдал	23
<b>Дүрслэл 1.14</b>	Гадаадын шууд хөрөнгө оруулалт	23
<b>Дүрслэл 1.15</b>	Импортын жилийн өсөлт	24
<b>Дүрслэл 1.16</b>	Монгол Улсын улирлын ДНБ-ий жилийн өсөлт	25
<b>Дүрслэл 1.17</b>	Гадаад, дотоод цэвэр актив ба М2 мөнгө	26
<b>Дүрслэл 1.18</b>	Засгийн газрын үнэт цаасны хүү	26
<b>Дүрслэл 1.19</b>	Төсөв болон мөнгөний бодлогын хүрээнд эдийн засагт хийгдсэн санхүүжилтийн бүтэц ба эдийн засгийн өсөлт	27
<b>Дүрслэл 1.20</b>	Инфляцийн задаргаа	27
<b>Дүрслэл 1.21</b>	Төлбөрийн тэнцлийн гүйцэтгэл	28
<b>Дүрслэл 1.22</b>	Урсгал тэнцлийн бүтэц	28
<b>Дүрслэл 1.23</b>	Урсгал тэнцлийн санхүүжилт	28
<b>Дүрслэл 1.24</b>	Хөрөнгө, санхүүгийн дансны бүтэц	29
<b>Дүрслэл 1.25</b>	Гадаад худалдааны нөхцөлийн индекс	29
<b>Дүрслэл 1.26</b>	Нийт экспорт	30
<b>Дүрслэл 1.27</b>	Нийт импорт	30
<b>Дүрслэл 1.28</b>	Гадаад валютын ханш	30
<b>Дүрслэл 1.29</b>	Гадаад валютын нөөц	31
<b>Дүрслэл 1.30</b>	Монгол Улсад хөрөнгө оруулсан гадаадын уул уурхайн компаниудын олон улсын бирж дэх хувьцааны үнэ	32
<b>Дүрслэл 1.31</b>	Гадаад зах зээлд гаргасан Монгол Улсын Засгийн газрын бондын үнэ	32
<b>Дүрслэл 1.32</b>	Шатахууны үнэ ба импортын тоо хэмжээ, үнийн дүн	34

Дүрслэл 1.33	Эдийн засгийн өсөлтийн задаргаа	35
Дүрслэл 1.34	M2 мөнгөний бүтэц	38
Дүрслэл 1.35	M2 мөнгөний жилийн өсөлтийн задаргаа	38
Дүрслэл 1.36	Мөнгөний үзүүлэлтүүдийн ерөнхий бүтэц ба хандлага	39
Дүрслэл 1.37	Мөнгөний нийлүүлэлт ба мөнгөний үржүүлэгч	39
Дүрслэл 1.38	Банкуудын хадгаламж болон зээлийн хүү	39
Дүрслэл 1.39	Банк хоорондын захын хүү	40
Дүрслэл 1.40	Банк хоорондын захын хүүний хэлбэлзэх интервал	40
Дүрслэл 1.41	Төсвийн тогтворжуулалтын сангийн үлдэгдэл	41
Дүрслэл 1.42	Нэгдсэн төсвийн орлого ба тусламжийн дүн	41
Дүрслэл 1.43	Уул уурхайн салбарт тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдээс төсөвт төвлөрүүлсэн орлого ба төсвийн бусад орлого	42
Дүрслэл 1.44	Нэгдсэн төсвийн зарлага ба Хөгжлийн банкны төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон зээл	43
Дүрслэл 1.45	Нэгдсэн төсвийн тэнцлийн гүйцэтгэл	44
Дүрслэл 1.46	Засгийн газрын бонд ба зээл	45
Дүрслэл 1.47	Засгийн газрын богино ба урт хугацаат бондын арилжаа	45
Дүрслэл 1.48	Банкуудын нэгдсэн тайлан дахь Засгийн газрын үнэт цаасны үлдэгдэл	46
Дүрслэл 2.1	Банкны салбарын активын бүтэц	47
Дүрслэл 2.2	Банкны салбарын пассивын бүтэц	47
Дүрслэл 2.3	Банкны салбарын эх үүсвэрийн жилийн өсөлт	48
Дүрслэл 2.4	Банкны салбарын актив, зээлийн жилийн өсөлт	48
Дүрслэл 2.5	Олгосон зээлийн жилийн өсөлт	48
Дүрслэл 2.6	Салбаруудын зээлийн төвлөрөл	49
Дүрслэл 2.7	Зээлийн чанарын үзүүлэлт, салбараар	49
Дүрслэл 2.8	Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн өсөлт	50
Дүрслэл 2.9	Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээл, валютын төрлөөр	50
Дүрслэл 2.10	Өрхийн бодит орлогын өсөлт	50
Дүрслэл 2.11	Өрхийн орлого, зарлагын харьцаа	51
Дүрслэл 2.12	Өрхийн өрийн дарамт	51
Дүрслэл 2.13	Өрхийн өр, орлогын харьцаа	51
Дүрслэл 2.14	Хувийн салбарын өрийн дарамт	52
Дүрслэл 2.15	Орон сууцны үнэ, ипотекийн зээлдэгчдийн тооны өсөлт	52
Дүрслэл 2.16	Өөрийн хөрөнгийн үзүүлэлтүүд	52
Дүрслэл 2.17	Банкны актив болон өөрийн хөрөнгийн өгөөж	53
Дүрслэл 2.18	Зээлийн эрсдэлийн сангийн өсөлт	53
Дүрслэл 2.19	Банкны салбарын актив, пассивт гарсан өөрчлөлт	54
Дүрслэл 2.20	Банкны салбарын төлбөр түргэн гүйцэтгэх чадвар	54
Дүрслэл 2.21	Хөрвөх чадварын үзүүлэлтүүд	54
Дүрслэл 2.22	Зээл, хадгаламжийн харьцаа	55
Дүрслэл 2.23	Мөчлөг сөрсөн өөрийн хөрөнгийн нөөц бүрдүүлэх зарчим	59
Дүрслэл 2.24	Бүртгэлтэй банк бус санхүүгийн байгууллагын тоо	60
Дүрслэл 2.25	Банк бус санхүүгийн байгууллагын нийт хөрөнгийн бүтэц	61
Дүрслэл 2.26	Банк бус санхүүгийн байгууллагын нийт зээл, зээлийн чанар	61
Дүрслэл 2.27	Банк ба ББСБ-ын зээлийн сарын дундаж хүү	62
Дүрслэл 2.28	Хадгаламж, зээлийн хоршоо болон гишүүдийн тоо	64

<b>Дүрслэл 2.29</b>	Хадгаламж, зээлийн хоршоодын нийт зээл, зээлийн чанар	64
<b>Дүрслэл 2.30</b>	Хадгаламж, зээлийн хоршоодын өр төлбөр ба өөрийн хөрөнгө	65
<b>Дүрслэл 2.31</b>	ТОП-20 индекс болон зах зээлийн үнэлгээ	66
<b>Дүрслэл 2.32</b>	Хөрвөх чадвар, хувьцааны арилжааны үнийн дүн	67
<b>Дүрслэл 2.33</b>	Хувьцаат компанийн төвлөрөл	68
<b>Дүрслэл 2.34</b>	Бүртгэлтэй хувьцаат компанийн тоо, тэдгээрийн хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилт	68
<b>Дүрслэл 2.35</b>	Арилжааны төлбөр тооцоо	69
<b>Дүрслэл 2.36</b>	Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ	70
<b>Дүрслэл 2.37</b>	Даатгалын компаниудын өр төлбөр, эзэмшигчдийн өмч	71
<b>Дүрслэл 2.38</b>	Даатгалын компаниудын хохирлын харьцаа ба ашигт ажиллагаа	73
<b>Дүрслэл 2.39</b>	Давхар даатгалын хураамж	73
<b>Дүрслэл 2.40</b>	Батлан даалт гаргасан байдал болон гаргуулсан ААН, иргэдийн үйл ажиллагааны чиглэл	76
<b>Дүрслэл 3.1</b>	Их дүнтэй төлбөр тооцооны системийн нэг өдрийн дундаж үзүүлэлт	85
<b>Дүрслэл 3.2</b>	Бага дүнтэй төлбөр тооцооны системийн нэг өдрийн дундаж үзүүлэлт	85



## ХҮСНЭГТҮҮД

<b>Хүснэгт Т.1</b>	Монгол Улсын макро эдийн засаг, санхүүгийн салбарын голлох үзүүлэлтүүд	12
<b>Хүснэгт 1.1</b>	Төсвийн орлогын тасралт	25
<b>Хүснэгт 1.2</b>	Урсгал тэнцлийн алдагдлын санхүүжилт	29
<b>Хүснэгт 1.3</b>	Монгол Улсын нийт гадаад өр	31
<b>Хүснэгт 1.4</b>	Монгол Улсын зээлжих зэрэглэлийн өөрчлөлт	32
<b>Хүснэгт 1.5</b>	Бодит салбарын үндсэн үзүүлэлтүүд	35
<b>Хүснэгт 1.6</b>	2015 оны I улирлын байдлаарх бодит ДНБ-ий өсөлт	35
<b>Хүснэгт 1.7</b>	Нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөө ба гүйцэтгэл	42
<b>Хүснэгт 1.8</b>	Нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл	42
<b>Хүснэгт 1.9</b>	Нэгдсэн төсвийн зарлагын төлөвлөгөө ба гүйцэтгэл	43
<b>Хүснэгт 1.10</b>	Нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр	44
<b>Хүснэгт 1.11</b>	Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн гүйцэтгэл	45
<b>Хүснэгт 2.1</b>	Банк бус санхүүгийн байгууллагын голлох статистик үзүүлэлтүүд	60
<b>Хүснэгт 2.2</b>	Банк бус санхүүгийн байгууллагын эрхэлж буй үйл ажиллагааны төрөл	61
<b>Хүснэгт 2.3</b>	Банк бус санхүүгийн байгууллагын санхүүгийн голлох үзүүлэлтүүд	62
<b>Хүснэгт 2.4</b>	Орлого, зарлага, ашигт ажиллагаа	62
<b>Хүснэгт 2.5</b>	ББСБ-уудын зохистой харьцааны үзүүлэлтүүд	63
<b>Хүснэгт 2.6</b>	Хадгаламж, зээлийн хоршоодын голлох статистик	64
<b>Хүснэгт 2.7</b>	ХЗХ-дын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд	65
<b>Хүснэгт 2.8</b>	ХЗХ-дын дагаж мөрдөх үзүүлэлтүүд	65
<b>Хүснэгт 2.9</b>	Хөрөнгө оруулагчдын арилжаанд эзлэх хувь	69
<b>Хүснэгт 2.10</b>	Даатгалын салбарын тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн тоо	70
<b>Хүснэгт 2.11</b>	Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ	71
<b>Хүснэгт 2.12</b>	Даатгалын компаниудын эргэлтийн хөрөнгө	71
<b>Хүснэгт 2.13</b>	Даатгалын хураамжийн орлого	72
<b>Хүснэгт 2.14</b>	Даатгалын нөхөн төлбөр	72
<b>Хүснэгт 2.15</b>	Давхар даатгалын хураамж	74
<b>Хүснэгт 2.16</b>	Жолоочийн даатгалын хураамж, нөхөн төлбөрийн хэмжээ	74
<b>Хүснэгт 2.17</b>	Компаниудын үйл ажиллагааны орлого	75
<b>Хүснэгт 2.18</b>	Компаниудын хохирол үнэлгээний орлого	75
<b>Хүснэгт 2.19</b>	Хөдөө аж ахуйн бирж дээрх түүхий эдийн үнийн дүн	77
<b>Хүснэгт 2.20</b>	Санхүүгийн салбарын хөгжлийг хэмжих 4x2 матриц	79
<b>Хүснэгт 2.21</b>	Монгол Улсын санхүүгийн салбарын хөгжлийн түвшин	80

## ӨМНӨХ ҮГ

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс хэлэлцэж шийдвэрлэсний дагуу “Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлын тайлан”-гийн эхний дөрвөн дугаарыг гаргаж, олон нийтийн хүртээл болгоод байгаа билээ. Энэ удаа “Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлын тайлан”-гийн тав дахь дугаарыг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс та бүхэнд өргөн барьж байна.

Хятадын эдийн засгийн өсөлтийн саарах хандлага, дэлхийн зах зээл дэх бүтээгдэхүүн, түүхий эдийн үнийн супер мөчлөг дуусгавар болж, үнэ буурч байгаа, АНУ-ын мөнгөний бодлого хатуурах төлөвтэй байгаа зэрэг гадаад хүчин зүйлс нь хөгжиж буй орнууд, тэр дундаа урсгал тэнцлийн алдагдал өндөртэй, гадаад секторын эмзэг байдал өндөртэй, макро эдийн засгийн бодлогын сонголт хязгаарлагдмал орнуудын эдийн засаг, санхүүгийн салбарт ихээхэн сорилтыг бий болгож байна. Манай улсад төлбөрийн тэнцлийн хүндрэлээс шалтгаалан бий болсон эдийн засгийн удаашрал үргэлжилсээр байгаа бөгөөд энэ нь эдийн засаг, мөнгө санхүүгийн үзүүлэлтүүдээс тод ажиглагдаж байна.

Мөнгө, санхүүгийн үзүүлэлтүүдийн өсөлт үргэлжлэн саарч байгаа хэдий ч, 2010-2012 оны их хэмжээний хөрөнгийн дотогшлох урсгалын дараа тохиолдсон төлбөрийн тэнцлийн хямралын нөлөөг макро эдийн засагт шаардлагатай тохиргоог алгуур хийгдэх нөхцөлийг бүрдүүлэх буюу эдийн засгийг огцом агшуулах бус, харин зөөлөн газардуулах бодлогын сонголт хийх замаар бууруулсан нь банк, санхүүгийн тогтвортой байдлыг сүүлийн 3 жилийн турш хангахад

чухал байж ирэв. Уул уурхайн эрдэс түүхий эдийн мөчлөгийг дагаж, жил бүр 3 тэрбум гаруй ам.долларын урсгал тэнцлийн алдагдалтай, тэр хэмжээгээрээ дотоодын илүүдэл эрэлттэй явж ирсэн 2011-2012 оны эдийн засагт шаардлагатай тохиргоо үргэлжлэн хийгдсээр, 2011-2013 оны эхний хагаст дунджаар 1369.1 сая ам.долларын алдагдалтай байсан урсгал тэнцэл 2015 оны эхний хагаст 334.4 сая ам.долларын алдагдалтай гарч алдагдлын хэмжээ 4.1 дахин буурчээ. Энэ хэмжээгээр гадаад секторын эмзэг байдал буурч, цаашид санхүүгийн болон макро эдийн засгийн, тогтвортой байдал, эдийн засгийн шинэ тэнцвэр (new normal equilibrium) хангагдах суурь орчин бүрдэж байгаа гэсэн үг юм.

Санхүүгийн салбар нь итгэлцэл дээр оршин тогтнох бөгөөд түүний тогтвортой байдал нь санхүүгийн зах зээлд оролцогчдын үнэн зөв мэдээлэлд үндэслэсэн бодитой хүлээлтээс ихээхэн хамааралтай байдаг. Энэ ч утгаараа Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл нь Монгол Улсын санхүүгийн тогтолцоо, түүний тогтвортой байдлыг хангах үндсэн чиг үүргийнхээ хүрээнд санхүү, эдийн засгийн бодлогын асуудлыг тогтмол авч хэлэлцэхийн зэрэгцээ, олон нийтэд хүргэж буй мэдээллийн чанарыг сайжруулах, санхүүгийн талаарх иргэдийн суурь мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор “Санхүүгийн тогтвортой байдлын тайлан”-г тогтмол боловсруулан нийтэлсээр байна.

Санхүүгийн тогтвортой байдал нь зөвхөн системийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн тусгайлсан арга хэмжээнээс гадна макро

эдийн засгийн бодлого, санхүүгийн салбарын хяналт шалгалт, зохицуулалт, институцийн оновчтой тогтолцоо зэргээс хамаардаг өргөн цар хүрээтэй ойлголт юм. Иймд дээр дурдсан зорилтын хүрээнд “Санхүүгийн тогтвортой байдлын тайлан”-г боловсруулахдаа олон нийтэд албан ёсны эх сурвалж, статистикт үндэслэсэн, макро эдийн засаг, санхүүгийн салбарын нөхцөл байдал, хандлагын талаар харилцан уялдаа бүхий бодитой мэдээлэл өгөх зарчмыг баримталж ирсэн болно.

Цаашид “Санхүүгийн тогтвортой байдлын тайлан”-гийн агуулгыг сайжруулахад уншигч таны оролцоо, хувь нэмэр ихээхэн үнэ цэнэтэй тул энэхүү тайлантай холбогдох саналаа Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн ажлын албанд хаяглан, [fsc@mongolbank.mn](mailto:fsc@mongolbank.mn) цахим шуудангаар ирүүлнэ үү. Таны саналыг хүлээж авахдаа бид үргэлж таатай байх болно.

## ТОЙМ

2014 онд хөгжингүй орнуудын эдийн засаг бага зэрэг сэргэсэн боловч тэдгээр орнуудын эдийн засгийн суурь асуудал шийдвэрлэгдээгүй хэвээр байна. Бүрэлдэж буй эдийн засагтай болон хөгжиж буй орнуудын өсөлт саарснаар дэлхийн эдийн засгийн өсөлт 3.4 хувьд хүрэв. ОУВС-гийн төсөөллөөр өсөлтийн жигд бус хандлага цаашид ч үргэлжлэх төлөвтэй байна.

АНУ-ын эдийн засаг 2015 оны эхний улиралд өвөлжилтийн нөхцөл байдал хүнд байсан, баруун эргийн усан боомтууд түр хугацаанд хаагдсан, газрын тосны салбарын хөрөнгө оруулалт огцом татарсан зэргээс шалтгаалан түр зуур саарсан боловч 2 дугаар улиралд хувийн хэрэглээний өсөлтийн нөлөөгөөр 3.7 хувийн гүйцэтгэлтэй гарав. Хувийн хэрэглээ, ажил эрхлэлтэд гарч буй эерэг өөрчлөлттэй уялдан Холбооны нөөцийн банк 2014 оны 10 дугаар сард уламжлалт бус мөнгөний бодлогын хүрээнд хэрэгжүүлж байсан актив худалдан авах хөтөлбөрөө эцэслэсэн бол мөнгөний бодлогын хүүг яаран нэмэгдүүлэхгүй гэсэн мэдэгдлийг хийсэн. Гэсэн хэдий ч эдийн засаг харьцангуй сэргэж, ажилгүйдлийн түвшин зорилтот түвшнээс доогуур байгаа тул бодлогын хүүг 2015 оны сүүлийн хагаст нэмэгдүүлж, мөнгөний бодлогыг чангаруулж магадгүй гэсэн хүлээлт зах зээлд үүсээд байгаа.

Евро бүсийн дотоод эрэлт сэргэсэн, инфляци өсч эхэлсэн зэрэгтэй холбоотойгоор энэ оны эхний улиралд эдийн засгийн өсөлт нь 0.4 хувьтай гарсан хэдий ч, 2 дугаар улиралд бага зэрэг удааширч 0.3 хувьд хүрсэн. Ажилгүйдлийн түвшин 2015 оны 2 дугаар

улирлын байдлаар Герман, Англи улсад харгалзан 6.4, 5.6 хувь байгаа бол Грек, Испанид харгалзан 25.9, 22.5 хувь, Евро бүст дунджаар 11.1 хувь байна.

2015 оны 2 дугаар улиралд Хятадын эдийн засаг 7.0 хувиар өссөн нь хүлээлтээс өндөр байв. Гэсэн хэдий ч Хятадын эдийн засгийн удаашрал үргэлжилж, 2015 онд 6.8, 2016 онд 6.3 хувийн өсөлттэй байхаар тус тус төсөөлөгджээ. Энэ оны 7 дугаар сарын байдлаар барааны экспорт 8.3 хувь, импорт 8.1 хувиар тус тус агшсан, аж үйлдвэрийн салбарын үйл ажиллагааны төлвийг илэрхийлэх PMI индекс 7, 8 дугаар саруудад буурч 49.7<sup>1</sup> хувьд хүрээд байгаа нь эрдэс бүтээгдэхүүн экспортлогч орнуудын гадаад эрэлтийг бууруулах хүчин зүйл болж байна.

2015 ны 2 дугаар улиралд нийлүүлэлтийн хэмжээ өсч, эрэлт саарсантай холбоотойгоор ихэнх түүхий эд, түүний дотор аж үйлдвэрлэлийн түүхий эдийн үнэ унав. Дэлхийн Банкны төсөөллөөр түүхий эдийн үнийн бууралтын хандлага 2015 оны туршид үргэлжилж, 2016 онд ялимгүй сэргэж магадгүй байна. Хятадын сайн чанарын коксжих нүүрсний импортын эрэлт буурч, нийлүүлэлт илүүдсэний улмаас үнэ 2015 оны 2 дугаар улиралд 88\$/тн-д хүрч сүүлийн 10 жилийн хамгийн бага түвшинд хүрчээ.

Дэлхийн зах зээл дээрх бүтээгдэхүүн, түүхий эдийн үнийн огцом бууралтаас улбаатай эдийн засгийн өсөлтийн сааралт, дефляци, ханшийн асуудлаас шалтгаалан хөгжингүй болон бүрэлдэж буй эдийн засагтай зарим

<sup>1</sup> Уг үзүүлэлт 50-аас бага утга авах нь аж үйлдвэрийн салбарын үйл ажиллагаа суларч буйг илэрхийлнэ.

орнууд мөнгөний зөөлөн бодлого хэрэгжүүлсэн нь 2014 оны эцсээс 2015 оны эхний хагас жил хүртэлх хугацаанд дэлхийн санхүүгийн зах зээл дэх онцлох үйл явдал болов. Тухайлбал 2015 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр Европын төв банк үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор мөнгөний уламжлалт бус тэлэх бодлогын хүрээнд худалдан авч буй активын хэмжээгээ нэмэгдүүлэн 1.1 их наяд еврод хүргэх болсноо зарлаж, сар бүрийн 60 тэрбум еврогийн актив худалдан авалтаа 2015 оны 3 дугаар сарын 9-ний өдөр эхлүүлсэн юм.

Хятад улсын иргэд хувьцаанд ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт хийсний улмаас “Шанхайн хөрөнгийн биржийн нэгдсэн индекс” 2014 оны 6 дугаар сараас 2015 оны 6 дугаар сар хүртэлх нэг жил орчмын хугацаанд 150 хувиар огцом өсч, 2015 оны 6 дугаар сарын 12-ны өдөр 5166.3 нэгжид буюу хамгийн өндөр түвшиндээ хүрсэн. Үүнээс хойш хувьцааны үнийн хөөс хагарч эхлэн 2015 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн байдлаар Шанхайн хөрөнгийн биржийн нэгдсэн индекс 30 хувиар унасан байна. Хятадын Ардын банк хувьцааны ханшийн уналтын эсрэг зарим бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлснээр хувьцааны үнэ тогтворжих хандлага ажиглагдсан хэдий ч, бодлогын эерэг нөлөөлөл харьцангуй богино хугацаанд үргэлжилж, 2015 оны 7 дугаар сарын 27-ны өдөр Шанхайн хөрөнгийн биржийн нэгдсэн индекс 8.5 хувиар буурсан нь 2007 оноос хойш хамгийн том бууралт болсон юм.

Монгол Улсын эдийн засгийн бодит өсөлт 2012 оны 12.3 хувиас 2013 онд 11.6 хувь, 2014 онд 7.8 хувь, 2015 оны эхний хагаст 3.0 хувь болж саарав. Гадаад активын огцом бууралтын сөрөг нөлөөг зөөлрүүлэх зорилгоор 2013-2014 онд мөнгөний

уламжлалт бус бодлогын хүрээнд хийсэн мөнгөний нийлүүлэлт нь дотоод активыг тогтворжуулж, эдийн засгийг богино хугацаанд (2013 онд) огцом агшихаас сэргийлсэн.

Монгол Улсын төлбөрийн тэнцэл 2015 оны эхний 7 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 82.3 сая ам.долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 1017.5 сая ам.доллараар сайжирлаа. Урсгал дансны алдагдал 69.0 хувиар буурч, хөрөнгө санхүүгийн дансны ашиг өнгөрсөн оны гүйцэтгэлээс 58.0 хувиар өссөн нь нийт тэнцэлд эергээр нөлөөлөв.

Төлбөрийн тэнцлийн урсгал данс 2015 оны эхний 7 сард 410.2 сая ам.долларын алдагдалтай гарч, алдагдлын хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 69.0 хувиар буюу 912.3 сая ам.доллараар буурсан. Урсгал тэнцлийн алдагдал буурахад өнгөрсөн оны мөн үед 69.0 сая ам.доллар байсан барааны гадаад худалдааны ашиг энэ онд 12 дахин өсч 817.9 сая ам.долларт хүрсэн нь голлох нөлөөг үзүүлсэн.

Хөрөнгө, санхүүгийн данс 2015 оны эхний 7 сарын байдлаар 661.0 сая ам.долларын ашигтай гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 58.0 хувиар буюу 242.6 сая ам.доллараар өссөн үзүүлэлт юм. Хөрөнгө, санхүүгийн дансны ашиг ийнхүү нэмэгдэхэд багцын хөрөнгө оруулалт болон бэлэн мөнгө, харилцах өмнөх оны мөн үеэс харгалзан 57.6, 71.3 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ. Харин гадаадын шууд хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 3 дахин буурч, ДНБ-ий 1 хувьтай тэнцүү байна.

M2 мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт 2014 оны 2 дугаар улирлаас эхлэн саарсаар 2015 оны 3 дугаар сард -0.5 хувьд хүрч 2009 оны 8 дугаар сараас хойш анх удаа сөрөг утгатай гарсан бол 2015 оны 7 дугаар сард

-2.1 хувь байна. Үүнд бараг мөнгө өмнөх оны мөн үеэс 172.1 тэрбум төгрөгөөр буюу 2.1 хувиар, М1 мөнгө 44.2 тэрбум төгрөгөөр буюу 2.6 хувиар тус тус буурсан нь нөлөөлжээ. Мөнгөний агрегатууд ийнхүү буурахад нэг талаас гадаад активыг нэмэгдүүлэх нөлөөтэй гадаад валютын орох урсгал, түүний дотор ГШХО сэргээгүй байгаа нь, нөгөө талаас макро бодлогын нэгдсэн өөрчлөлтөөр эдийн засгийн тэнцвэрийг хангахыг зорьж байгаа нь тус тус нөлөөлж байна.

### Хүснэгт Т.1

#### Монгол Улсын макро эдийн засаг, санхүүгийн салбарын голлох үзүүлэлтүүд

	Үзүүлэлт	2014.07	2014	2015.07	
Болит сектор	Нэрлэсэн ДНБ /тэрбум төгрөг/	9918.8	21975.5	10690.0	***
	Бодит ДНБ-ий өсөлт	8.2%	7.8%	3.0%	***
	Нэрлэсэн ДНБ-ий өсөлт	15.5%	14.6%	7.8%	***
	Инфляци (жилийн)	14.9%	11.0%	6.9%	****
	Ажилгүйдлийн түвшин	8.4%	7.7%	7.8%	****
Төсвийн сектор	Төсвийн тэнцвэржүүлсэн орлого /тэрбум төгрөг/	3305.2	6223.4	3145.2	*
	Төсвийн зарлага /тэрбум төгрөг/	3466.1	7031.4	3780.7	*
	Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-160.9	-808.0	-637.8	*
	Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл/ДНБ	-2.4%	-3.7%	-5.0%	***
	Засгийн газрын галаад өр/сая ам.доллар/	3672.0	3609.6	3741.5	***
	Урсгал тэнцэл (өсөлт)	-30.4%	-56.0%	-70.1%	***
Гадаад сектор	Урсгал тэнцэл/ДНБ	-19.9%	-11.6%	-4.3%	***
	Хөрөнгө санхүүгийн тэнцэл (өсөлт)	-81.6%	-26.2%	133.8%	***
	Хөрөнгө санхүүгийн тэнцэл/ДНБ	3.0%	8.8%	5.0%	***
	Төлбөрийн тэнцэл (өсөлт)	-6.9%	-74.8%	-109.1%	***
	Төлбөрийн тэнцэл/ДНБ	-16.3%	-3.9%	1.1%	***
	Гадаадын шууд хөрөнгө оруулалт (өсөлт)	-70.8%	-86.8%	-87.8%	***
	Гадаадын шууд хөрөнгө оруулалт/ДНБ	6.5%	2.3%	0.6%	***
	Экспорт (өсөлт)	22.6%	35.2%	-4.5%	***
	Экспорт/ДНБ	44.2%	47.8%	30.3%	***
	Импорт (өсөлт)	-14.1%	-17.6%	-30.3%	***
	Импорт/ДНБ	47.0%	43.4%	23.5%	***
	Гадаад худалдааны нийт эргэлт (өсөлт)	0.5%	3.6%	-17.8%	***
	Гадаад худалдааны нийт эргэлт/ДНБ	91.1%	91.2%	53.7%	***
	Гадаад валютын улсын ноён /сая ам.доллар/	1349.3	1649.9	1707.2	****
	Гадаад валютын улсын ноён (өсөлт)	-55.2%	-26.6%	26.5%	****
	Ам.долларын ханц (өсөлт)	25.1%	12.4%	7.3%	**
	Нэрлэсэн үйлчилж буй ханц (NEER)-ийн өсөлт	-18.7%	2.3%	6.3%	****
Бодит үйлчилж буй ханц (REER)-ийн өсөлт	-9.7%	11.0%	13.3%	****	
Мөнгө, санхүүгийн сектор	Мөнгө (M2) /тэрбум төгрөг/	10078.2	10635.8	9862.0	**
	Мөнгөний (M2) өсөлт	24.6%	12.5%	-2.1%	**
	Гадаад цэвэр актив /тэрбум төгрөг/	-1055.5	-1701.9	-3245.0	**
	Гадаад цэвэр актив (өсөлт)	-144%	-282%	207%	**
	Дотоод цэвэр зээл /тэрбум төгрөг/	12782.7	14100.1	14467.9	**
	Дотоод цэвэр зээл (өсөлт)	94.4%	42.1%	13.2%	**
	Банкны актив /тэрбум төгрөг/	20969.2	22882.4	21459.2	**
	Банкны актив (өсөлт)	30.3%	8.1%	2.3%	**
	Дотоод зээл /тэрбум төгрөг/	12352.6	12617.1	12161.3	**
	Дотоод зээл (өсөлт)	34.6%	16.4%	-1.5%	**
	Чанаргүй зээл/нийт зээл	4.9%	5.0%	6.9%	**
	Банк дахь харилцах /тэрбум төгрөг/	2463.2	2692.1	2144.5	**
	Банк дахь харилцах (өсөлт)	10.8%	11.7%	-12.9%	**
	Банк дахь хадгаламж /тэрбум төгрөг/	5287.3	5811.7	5933.5	**
	Банк дахь хадгаламж (өсөлт)	17.7%	14.0%	12.2%	**
	Банкуудын эзэмшиж буй төвбанкны үнэт цаас /тэрбум төгрөг/	557.3	853.0	459.4	**
	Засгийн газрын үнэт цаасны хүү (12 долоо хоногийн хугацаатай)	11.2%	14.7%	14.3%	**
Банкуудын эзэмшиж буй төвбанкны үнэт цаас (өсөлт)	-27.8%	-47.6%	-17.6%	**	
Бодлогын хүү	10.5%	12.0%	13.0%	**	

Эх сурвалж: Монголбанк, Сангийн яам, УСХ.

Тэмдэглэл: \*Жил бүрийн эхний 7 сарын гүйцэтгэл

\*\*Жил бүрийн 7 дугаар сарын эцсийн байдлаар

\*\*\*Жил бүрийн эхний 6 сарын гүйцэтгэл

\*\*\*\*Жил бүрийн эхний 6 сарын эцсийн байдлаарх

гүйцэтгэлийн мэдээллийг ашиглан тооцсон

үзүүлэлтүүд болно.

2015 оны эхний 7 сарын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр нэгдсэн төсвийн

тэнцвэржүүлсэн нийт орлого 85.4 хувийн гүйцэтгэлтэй буюу 3142.9 тэрбум төгрөг, зарлага 75.2 хувийн гүйцэтгэлтэй буюу 3780.7 тэрбум төгрөг, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 637.8 тэрбум төгрөгийн алдагдалтай гарчээ. Хэрэв нэгдсэн төсвийн нийт зарлагын дутуу гүйцэтгэл нь орлогын тасралт болон алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн хангалтгүй гүйцэтгэлээс бүрэн шалтгаалсан гэж үзвэл зарлагын дутуу гүйцэтгэлийн 43.8 хувь нь нэгдсэн төсвийн орлогын тасалдлаас, 48.6 хувь нь Засгийн газрын харилцах, хадгаламжийн дансны өөрчлөлтөөс, 40.1 хувь нь Засгийн газрын зээлийн санхүүжилтийн дутуу гүйцэтгэлээс, үлдсэн -32.5 хувь нь Засгийн газрын бонд ба урьдчилгаа төлбөрийн гүйцэтгэлээс тус тус шалтгаалсан байна. Цаашид 2016 оноос эхлэн нэгдсэн төсвийн тэнцлийг алдагдалгүй болгох нь макро бодлогын хамгийн чухал зорилт болж байна. Учир нь төсөв алдагдалтай байхын хэрээр эдийн засгийн тэнцвэр бүрэн хангагдахгүй бөгөөд макро бодлогын орон зай хязгаарлагдах, улсын гадаад өр нэмэгдэх, хувийн хэвшилд зээл болж очих эх үүсвэр хумигдах, эх үүсвэрийн өртөг нэмэгдэх, хувийн сектор агших зэрэг сөрөг үр дагаврууд үүсэхээр байна.

2015 оны 7 дугаар сарын байдлаар банкны салбарт нийт 14 банк, 1475 салбар, нэгж үйл ажиллагаа явуулж байна. Нийт хадгаламж эзэмшигчдийн тоо 2.7 саяд, зээлдэгчдийн тоо 842.2 мянгад хүрлээ. 2015 оны 7 дугаар сарын байдлаар банкны салбарын нийт актив 21.5 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 2.3 хувиар өсөв. Нийт активын бүтцийг авч үзвэл 55.6 хувь нь зээл, 12.2 хувь нь банкны нөөц, 10.5 хувь нь Засгийн газрын үнэт цаас, 2.1 хувь нь Төв банкны үнэт цаас, үлдэх 19.6 хувь нь бусад хөрөнгө байна. Монголбанкнаас Засгийн газартай хамтран

хэрэгжүүлж байсан хөтөлбөрүүдийн санхүүжилт болон харилцах хадгаламжийн тогтвортой өсөлттэй холбоотойгоор эх үүсвэрийн хэмжээ өсч байсан хэдий ч, 2014 оноос хойш өсөлтийн хурд эргэн буурч байна.

Эдийн засгийн нийт эрэлтийг хумьсантай холбоотойгоор санхүүгийн салбарын нийт зээлийн багцын<sup>2</sup> 96 хувийг бүрдүүлж буй банкны зээлийн өсөлт 2015 он гарсаар үргэлжлэн саарсаар 7 дугаар сард -2.0 хувьд хүрээд байна. Нийт чанаргүй зээлийн хэмжээ энэ оны 7 дугаар сарын байдлаар 822.7 тэрбум төгрөгт хүрч (нийт зээлийн 6.9 хувь), өмнөх оны мөн үеэс 224.6 тэрбум төгрөгөөр буюу 37.6 хувиар өссөн<sup>3</sup> бол хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 714.3 тэрбум төгрөгт хүрч (нийт зээлийн 6.0 хувь), 166.0 тэрбум төгрөгөөр буюу 30.3 хувиар нэмэгджээ. Чанаргүй зээлийн өсөлт нь зээлийн эрсдэлийн сангийн зардлыг өсгөснөөр банкны салбарын өөрийн хөрөнгийн болон ашигт ажиллагааны үзүүлэлтүүдэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.

2015 оны 2 дугаар улирлын эцсийн байдлаар 423 Банк бус санхүүгийн байгууллага, 242 Хадгаламж зээлийн хоршоо, 66 Брокер 61, диллерийн 59 байгууллага, 16 Даатгалын компани, 303 Хувьцаат компани үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдгээрийн тоо жил ирэх тусам нэмэгдэж байна. Гэсэн хэдий ч нийт санхүүгийн салбарт бага хувь эзэлсэн хэвээр байна.


Сүүлийн хагас жилийн хугацаанд Монгол Улсын банк, санхүүгийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах, санхүүгийн тогтвортой

байдлыг хангах чиглэлээр холбогдох хууль тогтоомжид хэд хэдэн өөрчлөлт гарлаа. Тухайлбал “Банкны тухай хууль”, “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай” хуульд нэмэлт өөрчлөлт оруулсны зэрэгцээ гадаадын үнэт цаасыг Монголын үнэт цаасны зах зээлд арилжаалах нөхцөлийг бүрдүүлэх зорилтын хүрээнд “Үнэт цаасны бүртгэлийн журам”-д, даатгалын компанийн засаглалыг сайжруулах чиглэлээр “Даатгагчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам”-д тус тус нэмэлт өөрчлөлт орлоо.

Санхүүгийн салбарын үндсэн дэд бүтэц болох төлбөр тооцооны системийн хэвийн үйл ажиллагаа хангагдаж байгаа бөгөөд төлбөр тооцооны системийн нэг өдрийн дундаж үзүүлэлт жил бүр өсөн нэмэгдэж байна.

### Дүрслэл Т.1

#### Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлын зураглал\*



Эх сурвалж: Монголбанк, Сангийн яам, УСХ.

Тэмдэглэл: Графикн төвд ойр байх тусам эрсдэл, эмзэг байдал бага, нөхцөл байдал тааламжтай байгааг илтгэнэ.

\* Аргачлалтай Монгол Улсын Санхүүгийн тогтвортой байдлын тайлангийн 4 дэх дугаарын 17-р хуудаснаас танилцна уу.

Санхүүгийн тогтвортой байдлыг үнэлэх “Cobweb” аргачлалын дагуу тооцсон Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлын зураглал, түүний гол үзүүлэлтүүдийн гүйцэтгэлээс харвал:

<sup>2</sup> Арилжааны банк, ББСБ, ХЗХ-ны зээлийн өрийн үлдэгдлийн статистикт үндэслэн тооцов.

<sup>3</sup> Татан буугдсан Анод, Зоос, Хадгаламж банкуудыг хасч тооцвол чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 63.3 хувиар өсч 584.3 тэрбум төгрөгт байгаа бөгөөд нийт зээлийн 5.0 хувьтай тэнцэж байна.

- ◆ 2012 оноос эхтэй төлбөрийн тэнцлийн хүндрэлтэй нөхцөл байдал 2013 онд хямралын шинжтэй болсны улмаас гадаад секторын эрсдэлийг илэрхийлэх үзүүлэлтийн утга 2014 оны 3 дугаар улиралд дэлхийн санхүү, эдийн засгийн хямрал нүүрлэсэн 2009 оны үеийн түвшинд буюу 8 нэгжид хүрээд байв. Харин барааны гадаад худалдааны тэнцэл 2014 оны 10 дугаар сараас эхлэн ашигтай гарч, урсгал тэнцлийн алдагдал 2011-2013 онд ДНБ-ийн -26 хувьтай тэнцэх түвшнээс 2015 оны эхний хагаст -6 хувь болж буурснаар гадаад валютын улсын нөөц дэх дарамт буурсан. Ингэснээр 2015 оны 2 дугаар улиралд гадаад секторын эрсдэлийг илэрхийлэх үзүүлэлтийн утга 6 нэгж болж өөрчлөгдөөд байна.
  - ◆ Төлбөрийн тэнцлийн хүндрэлт нөхцөл байдал бодит секторт сөргөөр нөлөөлж 2015 оны эхний хагас жилд ДНБ-ий бодит өсөлт 3.0 хувь болж саарсны зэрэгцээ төсөвтэй адилтгах зарцуулалтыг оруулж тооцсон төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь хэмжээ түүхэн хугацааны дунджаасаа харьцангуй өндөр, улсын төсөв алдагдалтай хэвээр байгаа нь макро эдийн засгийн нөхцөл байдлыг илэрхийлэх үзүүлэлтийн утга 8 нэгж гарахад голлон нөлөөлөв.
  - ◆ Банкны салбарын төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааг 2012 онд 18 хувиас 25 хувь болгон нэмэгдүүлсэн, банкууд хөрвөх чадвар сайтай эрсдэлгүй санхүүгийн хэрэгсэлд хийх хөрөнгө оруулалтын хэмжээгээ нэмэгдүүлсэнтэй уялдан төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг илэрхийлэх үзүүлэлтийн утга 2012 оны эцсээс тогтвортой буурч (сайжирч) 2014 оны 1 дүгээр улиралд 4 нэгжид хүрсэн юм. 2015 оны 1 дүгээр улиралд 6 нэгж болж өссөн бөгөөд үүнд нэг талаас банкны салбарын үндсэн эх үүсвэр болох харилцах, хадгаламжийн өсөлт саарсан, нөгөө талаас банкууд харьцангуй өндөр хүүтэй Засгийн газрын дунд болон урт хугацаатай үнэт цаасанд 1.3 их наяд төгрөг буюу нийт активын 6.4 хувийг байршуулсан зэрэг нь нөлөөлсөн. Харин 2015 оны 2 дугаар улиралд хөрвөх чадварыг илэрхийлэх үзүүлэлтийн утга 5 нэгж болж сайжирсан ба энэ нь банкуудын тайлан тэнцэл дэх Засгийн газрын богино хугацаат үнэт цаасны үлдэгдэл өссөнөөр голлон тайлбарлагдаж байна.
  - ◆ 2015 оны 2 дугаар улиралд банкны салбарын ашиг өмнөх улирлаас 42.0 хувиар өсч, 105.1 тэрбум төгрөгт хүрэв. Ийнхүү банкны ашигт ажиллагаа сайжирсан нь банкны ашигт ажиллагаа, өөрийн хөрөнгийн хүрэлцээ, активын чанарыг илэрхийлэх үзүүлэлтийн утга өмнөх улирлаас 1 нэгжээр буурч (сайжирч) 5 нэгж гарахад нөлөөлжээ.
  - ◆ Эдийн засгийн идэвхжил саарсан нь өрхийн нэрлэсэн ба бодит орлогыг бууруулж, өрхийн өрийн дарамтыг нэмэгдүүлэв. 2015 оны 2 дугаар улиралд өрхийн төсөв санхүүгийн байдлыг илэрхийлэх үзүүлэлтийн утга 8 нэгж гарлаа.
- Банкны салбарын активын чанарыг илэрхийлэх чанаргүй зээл, хугацаа хэтэрсэн зээл зэрэг үзүүлэлтүүд өсч, зээлийн эргэн төлөлт буурч буй шинж тэмдгийг дагаад банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлтүүд сулрах эрсдэлтэй байна. Иймд, банк, санхүүгийн салбарт эрсдэл хуримтлагдахаас сэргийлэх, болзошгүй эрсдэлийг бууруулах, тогтвортой байдлыг хадгалахын тулд макро эдийн засгийн тэнцвэрийг бүрэн хангаж, улсын төсвийг алдагдалгүй болгон, гадаад валютын орох урсгалыг нэмэгдүүлэх нь чухал хэвээр байна.



# 1

## МАКРО-САНХҮҮГИЙН ОРЧИН

### 1.1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

#### ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ


2015 оны 1 дүгээр улиралд АНУ-ын эдийн засгийн өсөлт 0.6 хувьд хүрч саарсан, бүрэлдэж буй эдийн засагтай орнууд болон хөгжиж буй орнуудын эдийн засгийн гүйцэтгэл хүлээлтээс доогуур гарсан, 2015 оны 2 дугаар улиралд газрын тосны үнэ хүлээгдэж байснаас илүү өссөн, үүнтэй холбоотойгоор хөгжингүй орнуудад үнийн түвшин өсч эхэлсэн зэргээс шалтгаалан энэ оны 7 дугаар сард ОУВС дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөллөө бууруулж, 2015 онд 3.3 хувь, 2016 онд 3.8 хувьтай байхаар тус тус таамаглажээ.

өвөлжилтийн нөхцөл байдал хүнд байсан, баруун эргийн усан боомтууд түр хугацаанд хаагдсан, газрын тосны салбарын хөрөнгө оруулалт огцом татарсан зэргээс шалтгаалан түр зуур саарсан боловч 2 дугаар улиралд хувийн хэрэглээний өсөлтийн нөлөөгөөр 3.7 хувийн гүйцэтгэлтэй гарав. 2015 оны эхэнд -0.1 хувьтай байсан инфляцийн түвшин энэ оны эхний хагас хүртэл аажмаар сэргэсэн газрын тосны үнийн өсөлтийн нөлөөгөөр 7 дугаар сард 0.2 хувьд хүрч өслөө. Инфляцийн түвшин нам байгаагийн зэрэгцээ ажлын байр нэмэгдэж, 2 дугаар улиралд ажилгүйдлийн түвшин 5.3 хувьд хүрсэн нь өрхийн бодит орлогыг нэмэгдүүлж ДНБ-ийн 70 хувийг бүрдүүлэгч хувийн хэрэглээ 2 дугаар улиралд 3.3 хувиар өсөх нөхцөлийг бүрдүүлсэн. Ингэснээр хувийн хэрэглээ 2015 оны 2 дугаар улирлын эдийн засгийн өсөлтөд хамгийн их эерэг нөлөөг үзүүлсэн байна.

Хувийн хэрэглээ, ажил эрхлэлтэд гарч буй эерэг өөрчлөлттэй уялдан Холбооны нөөцийн банк 2014 оны 10 дугаар сард уламжлалт бус мөнгөний бодлогын хүрээнд хэрэгжүүлж байсан актив худалдан авах хөтөлбөрөө дуусгавар болгосон бол мөнгөний бодлогын хүүг яаран нэмэгдүүлэхгүй гэсэн мэдэгдлийг хийсэн. Гэсэн хэдий ч эдийн засаг сэргэж, ажилгүйдлийн түвшин зорилтот түвшнээс доогуур байгаа тул бодлогын хүүг 2015 оны сүүлийн хагаст нэмэгдүүлж, мөнгөний

#### Дүрслэл 1.1

Дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл




Эх сурвалж: ОУВС-гийн төсөөлөл, “Дэлхийн эдийн засгийн хандлага (World economic outlook update)” тайлан, 2015 оны 7 дугаар сар.

АНУ-ын эдийн засаг 2015 оны эхний улиралд

бодлогыг чангаруулж магадгүй гэсэн хүлээлт зах зээлд үүсээд байгаа. Холбооны нөөцийн банкны Мөнгөний бодлогын хороо 2015 оны 7 дугаар сарын 29-ний өдөр хуралдаж, хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдал үргэлжилэн сайжирч байгаа ч, инфляцийн түвшин урт хугацааны зорилтот 2 хувиас доогуур байгааг онцлоод, мөнгөний бодлогын хүүг өөрчлөлгүй хэвээр үлдээсэн. Цаашид хөдөлмөрийн зах зээлийн таатай нөхцөл байдал үргэлжлэн, газрын тосны үнийн бууралтын инфляцид үзүүлэх нөлөө сулрахын хэрээр инфляцийн түвшин нэмэгдэж зорилтот 2 хувь руу дөхөх үед мөнгөний бодлогын хүүг өсгөж магадгүй гэж шинжээчид үзэж байна.

### Дүрслэл 1.2

АНУ-ын зарим голлох үзүүлэлтүүд




Эх сурвалж: Блүмберг.

Евро бүсийн дотоод эрэлт сэргэсэн, инфляци өсч эхэлсэн зэрэгтэй холбоотойгоор энэ оны эхний улиралд эдийн засгийн өсөлт нь 0.4 хувьтай гарсан хэдий ч, 2 дугаар улиралд бага зэрэг удааширч 0.3 хувьд хүрсэн. Үүнд Францын эдийн засаг зогсонги байдалд орсон, Герман, Итали, Голланд улсуудын өсөлт хүлээлтээс доогуур гарсан нь нөлөөлжээ. Гэсэн хэдий ч 8 дугаар сарын байдлаар зах зээлийн хүлээлтийг илэрхийлэх зарим индексийн утга өссөнөөс үзэхэд 2 дугаар улирлын удаашрал түр зуурын

шинжтэй байсан байх магадлалтай байна. Тухайлбал, энэ оны 8 дугаар сарын байдлаар PMI индекс өмнөх сараас 0.4 нэгж хувиар өссөн, ESI индекс сүүлийн 4 жилийн оргилдоо хүрч өсчээ. 2015 оны 2 дугаар улиралд Грекийн өрийн асуудал хүндэрч, зээлийн эргэн төлөлтөө хийх чадваргүй болсон. Ингээд Европын холбооноос дэмжлэг үзүүлэх эсвэл Грекийг тус холбооноос гаргах талаар хүчтэй маргаан өрнөж тодорхой бус байдлыг нэмэгдүүлсэн.

### Дүрслэл 1.3

Евро бүсийн ажилгүйдлийн түвшин




Эх сурвалж: Блүмберг.

Харин 7 дугаар сард Европын холбооны эрх баригчид Грект 86 тэрбум еврогийн дэмжлэг үзүүлэх шийдвэр гаргаснаар дээрх тодорхой бус байдал арилсан юм. Ажилгүйдлийн түвшин 2015 оны 2 дугаар улирлын байдлаар Герман, Англи улсад харгалзан 6.4, 5.6 хувьтай байгаа бол Грек, Испанид харгалзан 25.9, 22.5 хувьтай, Евро бүст дунджаар 11.1 хувь байна. Евро бүсийн санхүүгийн зах зээлийг хөрөнгөжүүлэх, улмаар засгийн газруудад хямд үнээр бонд гаргах боломж олгох зорилготой Европын төв банкны бонд худалдан авах хөтөлбөрийн хэмжээг 2015 оны 3 дугаар сараас нэмэгдүүлж сар бүр 60 тэрбум евро болгосон. Европын төв банкны ерөнхийлөгчийн мэдэгдсэнээр энэхүү

бодлого нь инфляци зорилтот 2 хувьд хүрэх хүртэл үргэлжлэхээр байна. Энэхүү арга хэмжээ нь еврогийн ханшийг сулруулж, Евро бүсийн өрсөлдөх чадварыг дэмжихэд эерэг нөлөөтэй гэж судлаачид үзэж байна. Нөгөө талаас Евро бүсийн эдийн засгийн суурь асуудал шийдвэрлэгдэхгүй, Евро бүсийн эдийн засагт өөр сонголтгүй гэж үзэж байна.

**Дүрслэл 1.4**

**БНХАУ-ын нүүрсний импорт (сая тонн)**



Эх сурвалж: Блүмберг.

2015 оны 2 дугаар улиралд Хятадын эдийн засаг 7.0 хувиар өссөн нь хүлээлтээс өндөр байв. Гэсэн хэдий ч эдийн засгийн удаашрал үргэлжилж, 2015 онд 6.8, 2016 онд 6.3 хувийн өсөлттэй байхаар тус тус төсөөлөгджээ. Энэ оны 7 дугаар сарын байдлаар барааны экспорт 8.3 хувь, импорт 8.1 хувиар тус тус агшсан, аж үйлдвэрийн салбарын үйл ажиллагааны төлвийг илэрхийлэх PMI индекс 7, 8 дугаар саруудад буурч 49.7<sup>4</sup> хувьд хүрээд байгаа нь эрдэс бүтээгдэхүүн экспортлогч орнуудын гадаад эрэлтийг бууруулах, эдийн засгийн эрсдэлийг нэмэгдүүлэх хүчин зүйл болж байна. 2015 онд эдийн засгийн өсөлт төсөөлсөн түвшинд хүрэхгүй байх эрсдэлтэй байгаа тул 8 дугаар сарын 25-нд Хятадын төв банк хадгаламж, зээлийн жишиг хүүгээ 0.25 хувиар, том банкуудад тавигддаг нөөцийн

<sup>4</sup> Уг үзүүлэлт 50-аас бага утга авах нь аж үйлдвэрийн сарлбарын үйл ажиллагаа суларч буйг илэрхийлнэ.

шаардлагыг 0.5 хувиар тус тус бууруулаад байна. Түүнчлэн 8 дугаар сард төрийн өмчийн банкууд 1 их наяд юанийн бонд гаргаж, дэд бүтцийн салбарт дэмжлэг үзүүлэхээр болсон.

2015 оны 2 дугаар улиралд нийлүүлэлтийн хэмжээ өсч, эрэлт саарсантай холбоотойгоор ихэнх түүхий эд, түүний дотор аж үйлдвэрлэлийн түүхий эдийн үнэ унасан. Харин газрын тосны үнэ 2 дугаар улирлын эхэнд эрэлтийн нөлөөгөөр бага зэрэг сэргэсэн боловч үүнийг даган нийлүүлэлтийн хэмжээ өссөн нь газрын тосны үнийг дахин буурахад хүргэжээ. Дэлхийн Банкны төсөөллөөр түүхий эдийн үнийн бууралтын хандлага 2015 оны туршид үргэлжилж, 2016 онд ялимгүй сэргэхээр байна.

Улирлын чанартай эрэлт нэмэгдсэн, нөөц буурсан, Чилид үер гарсан зэрэг зарим нэг нийлүүлэлтийн саатлын улмаас зэсийн үнэ 2015 оны 5 дугаар сард 4 хувиар өссөн боловч Хятадын эдийн засгийн удаашрал, хөрөнгийн захын хэлбэлзэл, түүхий эдийн зах зээлд хөрөнгө оруулагчдын сонирхол, итгэл муудсан, зарим уурхайн хүчин чадал нэмэгдсэн зэрэгтэй холбоотойгоор эргэн буурчээ. Нэг жилийн өмнө 7001\$ байсан нэг тонн зэсийн үнэ 2015 оны 8 дугаар сард 5127\$ болж буураад байна.


ЕIУ-ийн тооцоолсноор 2004-2013 онд нүүрсний дэлхийн хэрэглээ жилд дунджаар 4 хувиар өсч байсан бол 2014 онд 0.2 хувиар буурсан нь 1999 оноос хойшхи анхны уналтад тооцогдож байна. Харин 2009-2013 онд дунджаар 3.1 хувиар өсч байсан нүүрсний нийлүүлэлт 2014 онд дөнгөж 1 хувиар өсчээ. Нүүрсний эрэлт ийнхүү буурснаар дэлхийн зах зээл дэх эрчим хүчний нүүрсний үнэ 2014 оны 1 сараас хойш унасаар 2015 оны 8 дугаар сард 62\$-т хүрэв.

Хятадын сайн чанарын коксжих нүүрсний импортын эрэлт буурч, нийлүүлэлт илүүдсэний улмаас үнэ 2015 оны 2 дугаар улиралд 88\$/тн-д хүрч сүүлийн 10 жилийн хамгийн бага түвшинд хүрчээ. Үнэ хямдарсан орчинд нүүрс олборлох нь ашиг багатай байгаа тул дэлхийн хэмжээнд жилийн 20 сая тоннын хүчин чадал бүхий уурхайнууд зогсонги байдалд оржээ.

2015 оны 2 дугаар улиралд Энэтхэгт баяр наадмын зориулалттай алт, үнэт эдлэлийн эрэлт өссөнтэй холбоотойгоор алтны үнэ бага зэрэг сэргэсэн боловч АНУ-ын эдийн засаг харьцангуй сэргэж, ам.долларын ханш чангарч, Холбооны нөөцийн банк мөнгөний бодлогыг чангалах сургаар алтанд хөрөнгө оруулах сонирхол буурсан. Ингээд нэг унц алтны үнэ 2015 оны 8 дугаар сард дунджаар 1119\$ болж буурав.

### Дүрслэл 1.5

Бүтээгдэхүүн, түүхий эдийн үнэ



Эх сурвалж: ОУВС.

Тэмдэглэл: \*ОУВС-гийн төсөөлөл.

\*\*WTI, Brent, Dubai газрын тосны үнийн дундаж.

Зах зээлд эзлэх байр сууриа хадгалах зорилгоор 2014 онд газрын тосны нийлүүлэлтийг бууруулахгүй байх ОПЕК-ийн шийдвэр нь үнэд нөлөөлж, улмаар 2014 оны эхэнд 102\$ байсан газрын тосны үнэ 2015 оны 1 дүгээр сард 47\$ болж буурсан. Энэ оны 2 дугаар сард боловсруулсан газрын тосны эрэлт өсч, нийлүүлэлтэд түр зуурын саатал гарсны улмаас үнэ 5 дугаар сар хүртэл өссөөр 63\$-т хүрэв. Гэсэн хэдий ч оны дундуур ОПЕК-ийн орнууд газрын тосны үйлдвэрлэлээ нэмэгдүүлсэнтэй уялдан үнэ нь дахин буурсаар 8 дугаар сард 46\$-т хүрлээ.


## ДЭЛХИЙН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Дэлхийн зах зээл дэх бүтээгдэхүүн, түүхий эдийн үнийн огцом бууралтаас улбаатай эдийн засгийн өсөлтийн сааралт, дефляци, ханшийн асуудлаас шалтгаалсан мөнгөний

зөөлөн бодлого хэрэгжүүлэх зарим шийдвэрүүд нь бондын зах зээлд ихээхэн нөлөөлөв.

**Дүрслэл 1.6**

**Зарим Төв банкуудын мөнгөний бодлогын хүүний түвшин**




Эх сурвалж: Блүмберг.  
Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2015 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн статистик болно.

Тухайлбал Европын төв банкны мөнгөний уламжлалт бус тэлэх бодлогын хүрээнд актив худалдан авах хөтөлбөрийн хэмжээг 1.1 их наяд евро болгон нэмэгдүүлсэн мэдэгдэл нь зах зээлд оролцогчдын хүлээлтээс өндөр байснаас шалтгаалан тус мэдэгдлийг хийсэн өдөр Евро бүсийн голлох эдийн засагтай орнуудын хувьцааны үнэ 1.3-2.4 хувиар өсч, засгийн газрын бондын өгөөж буурч, зарим нь сөрөг утгатай болсон.

**Дүрслэл 1.7**

**Зарим хөгжингүй орнуудын Засгийн газрын 10 жилийн хугацаатай бондын өгөөж**




Эх сурвалж: Блүмберг.  
Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2015 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн статистик болно.

Ийнхүү Евро бүсийн орнуудын Засгийн газрын бондын өгөөж буурсан нь хөрөнгө оруулагчдын өгөөж хайх, илүү эрсдэлтэй, өндөр өгөөж бүхий хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх явдлыг өдөөж өгөөж өндөртэй Европын компанийн бондын эрэлтийг нэмэгдүүлэв.

Мөн өгөөж хайх байдал АНУ-ын бондын зах зээлд нөлөөлж, Европын төв банк мэдэгдэл хийсний дараах 28 хоногийн хугацаанд АНУ-ын бондын зах зээл 40 тэрбум ам.долларын санхүүгийн хөрөнгийн орох урсгалтай<sup>5</sup> байсны 15 тэрбум нь Евро бүсийн болон АНУ-ын компанийн бондын өгөөжийн зөрүүнээс шалтгаалан хийсэн хөрөнгө оруулалт байсан юм.

**Дүрслэл 1.8**

**Зарим хөрөнгийн захын индекс**



Эх сурвалж: Блүмберг.  
Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2015 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн статистик болно, 2014.12.31=100.


2014 оны эцэс үеэс 2015 оны эхний хагас жил хүртэлх хугацаанд зарим орны хөрөнгийн биржийн хувьцааны ханшийн индекс эдийн засгийн өсөлтийн сайнгүй хандлагаас нь үл хамааран өсч байв. Эдгээрийн нэг нь Хятадын “Шанхайн хөрөнгийн биржийн

<sup>5</sup> Энэ нь 2014 онд буюу Европын төв банк мэдэгдэл хийхээс өмнөх хугацаанд 28 хоногт АНУ-д орж ирж байсан санхүүгийн хөрөнгийн урсгалын дундаж хэмжээнээс ойролцоогоор 3 дахин их байв.

нэгдсэн индекс” юм. Хятад улсын иргэд хувьцаанд ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт хийсний<sup>6</sup> улмаас тус индекс 2014 оны 6 дугаар сараас 2015 оны 6 дугаар сар хүртэлх нэг жил орчмын хугацаанд 150 хувиар огцом өсч, 2015 оны 6 дугаар сарын 12-ны өдөр 5166.3 нэгжид буюу хамгийн өндөр түвшиндээ хүрсэн юм. Үүнээс хойш хувьцааны үнийн хөөс хагарч эхлэн 2015 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн байдлаар Шанхайн хөрөнгийн биржийн нэгдсэн индекс 30 хувиар унасан байна.

### Дүрслэл 1.9

Хятадын аж үйлдвэрлэлийн өсөлт ба Шанхайн хөрөнгийн биржийн индекс



Эх сурвалж: Блүмберг.

Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2015 оны 7 дугаар сарын статистик болно.

Хятадын засгийн газар хөрөнгийн зах зээлийн уналтын эсрэг хувьцааны анхдагч зах зээлийн арилжааг зогсоох, брокерийн байгууллагуудад хувьцаа худалдан авахад нь дэмжлэг болгож бэлэн мөнгө өгөх, гол хувьцаа эзэмшигдийн хувьд 6 сарын хугацаанд хувьцаагаа арилжаалахыг хориглох зэрэг шат дараалсан арга хэмжээг авч

<sup>6</sup> 2015 оны эхний 6 сард А-хувьцааны зах зээлд 33 сая орчим данс шинээр нээгдсэн бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеийнхээс 13.2 дахин өндөр үзүүлэлт болсон. А-хувьцаа нь Шанхай болон Шензений хөрөнгийн биржид арилжаалагддаг, зөвхөн их газрын Хятад иргэд худалдан авах боломжтой хувьцаа юм.

хэрэгжүүлсний үр дүнд хувьцааны индекс 4000 нэгжид хүрч өссөн. Гэвч тус арга хэмжээнүүдийн эерэг нөлөөлөл харьцангуй богино хугацаанд үргэлжилж, 2015 оны 7 дугаар сарын 27-ны өдөр Шанхайн хөрөнгийн биржийн нэгдсэн индекс 8.5 хувиар буурсан нь 2007 оноос хойш хамгийн том бууралт болсон юм. Мөн 2015 оны 8 дугаар сарын 21-ний өдөр Хятадын PMI индекс 49.7 болж, Хятадын аж үйлдвэрлэл 2009 оноос хойш хамгийн өндөр хурдаар агшиж буй нь тодорхой болсны дараа 2015 оны 8 дугаар сарын 24, 25-ны өдрүүдэд Шанхайн хөрөнгийн биржийн нэгдсэн индекс дахин 8.5 ба 7.6 хувиар тус тус унасан.

### Дүрслэл 1.10

Шанхайн хөрөнгийн биржийн индекс



Эх сурвалж: Блүмберг.

Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2015 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн статистик болно.


Хятадын хөрөнгийн зах зээлийн уналт нь Азийн бусад голлох хөрөнгийн бирж төдийгүй дэлхийн бусад томоохон биржүүдэд нөлөөлж эхлэв. 2015 оны 8 дугаар сарын 18-25 хооронд Хятадын хувьцааны индекс 21 хувиар унахад дэлхийн гол хувьцааны индексүүд 10 орчим хувиар унасан байна. Мөн Японы хөрөнгийн биржийн Никкей индекс 2015 оны 8 дугаар сарын 19-25 хооронд 13 хувиар унаж, сүүлийн 6 сарын хамгийн доод түвшиндээ хүрэв.

Газрын тосны үнийн бууралттай зэрэгцэн ам.долларын ханшийн чангаралт үргэлжлэв. Тухайлбал, газрын тосны үнэ буурч эхэлсэн 2014 оны 6 дугаар сараас 2015 оны 7 дугаар сар хүртэлх хугацаанд ам.долларын нэрлэсэн үйлчилсэн буй ханш 14.7 хувиар чангарчээ.

Ам.долларын ханш (DXY) ялангуяа бүтээгдэхүүн түүхий эд экспортлогч, хэрэглэгч бүрэлдэж буй эдийн засагтай олон орны үндэсний валютын эсрэг болон еврогийн эсрэг чангарав. Ам.долларын евротой харьцах ханш чангарахад АНУ-ын эдийн засгийн сэргэлт болон Холбооны нөөцийн банк, Европын төв банкууд мөнгөний бодлогын төлөвөө харилцан адилгүй байдлаар өөрчилнө гэсэн зах зээл дэх хүлээлт нэмэгдсэн нь голлох нөлөө үзүүлсэн байна.

### Дүрслэл 1.11

Голлох валютуудын ам.доллартай харьцах ханш



Эх сурвалж: Блүмберг.


Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2015 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн статистик болно, 2014.12.31=100.

Ам.доллар чангарч евро суларсан нь евротой ханшаа уясан зарим оронд ханшийн дарамтыг учруулсан юм. 2015 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр Швейцарийн төв банк ам.долларын чангаралт болон Евро бүсийн голлох валюттай орнуудын мөнгөний бодлогын харилцан адилгүй төлөв байдлаас шалтгаалан Швейцарь франкийн евротой харьцах

ханшийн хязгаарыг (евро/франк $\geq$ 1.2) хэрэгсэхгүй болсноо мэдэгдсэн. Тус мэдэгдлийг хийсний дараа өдөр нь еврогийн Швейцарь франктай харьцах ханш 0.98 болж франк өмнөх өдрөөс 23.0 хувиар чангарсан бол Швейцарийн төв банкны интервенцийн үр дүнд тогтворжиж, 2015 оны 9 дугаар сарын 11-ний өдрийн байдлаар 1 евро 1.1 франктай тэнцэж байна.

### Дүрслэл 1.12

Алт, зэсийн үнэ ба ам.долларын ханшийн индекс, Евро/Швейцарь франк



Эх сурвалж: Блүмберг.

Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2015 оны 9 дүгээр сарын 9-ний өдрийн статистик болно.

АНУ-ын мөнгөний бодлогын төлөв чангарна гэсэн хүлээлттэй уялдан Азийн бүсийн олон орны үндэсний валютын ханш ам.долларын эсрэг суларч байсан бол 2014 оны эхэн үеэс Хятадын юанийн ам.доллартай харьцах ханш харьцангуй тогтвортой буюу 6.10-6.15 (USD/RNB) хооронд хэлбэлзэж байв. Харин 2015 оны 8 дугаар сарын 11-ний өдөр Хятадын Ардын банк юанийн ам.доллартай харьцах ханшийг өмнөх өдрөөс 1.9 хувиар огцом сулруулсан. Энэ нь зах зээлд хүлээгдээгүй гэнэтийн шийдвэр болсон бөгөөд үүнийг ихэнх шинжээчид сүүлийн хэдэн сарууд дахь Хятадын эдийн засгийн зарим үзүүлэлтүүдийн тааруу гүйцэтгэлтэй уялдан Хятадын Ардын банкнаас авч байгаа

зайлшгүй арга хэмжээтэй холбон тайлбарлаж байна.<sup>7</sup> Тус шийдвэр нь Хятадын Ардын банк 2010 оны 6 дугаар сараас эхлэн хэрэгжүүлж ирсэн crawling peg ханшийн дэглэмийг баримтлахаас илүүтэй юанийн ханшийг эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцүүлэх, хөрөнгийн зах зээлийн уналт, эдийн засгийн өсөлтийн удаашралыг сөрөх, бодит секторын идэвхжилийг дэмжих, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, экспортыг урамшуулан дэмжих зорилго бүхий арга хэмжээ байв.<sup>8</sup>

Гэвч юанийн ханшийн энэхүү сулралт нь бусад бүрэлдэж буй эдийн засагтай орнуудын үндэсний валютын ханшийн ам.долларын эсрэг сүүлийн 2 жилийн хугацаанд суларсан дүнтэй харьцуулахад бага байгаа бөгөөд юанийн ханш цаашид ч сулрах хүлээлттэй байгаа юм.

---

<sup>7</sup> Тухайлбал 2015 оны эхний 7 сарын байдлаар барааны экспорт өмнөх оны мөн үеэс 8.3 хувиар буурсан бөгөөд тус статистик 2015 оны 8 дугаар сарын 10-ны өдөр гарсан юм.

<sup>8</sup> Мөн энэ нь ОУВС-гийн SDR нөөцийн валютын сагсанд ордог валютын ханш зах зээлийн зарчимд суурилсан байдлаар тодорхойлогддог байх гэсэн шаардлагатай уялдан, юанийг дэлхийн нөөцийн валют болгох бодлоготой холбоотой гэж үзэж байна.




1.2 МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Дэлхийн болон БНХАУ-ын эдийн засгийн өсөлт удааширч байгаагаас шалтгаалан голлох эрдэс бүтээгдэхүүний эрэлт буурч, улмаар үнийн төлөв сайнгүй, хөрөнгийн урсгал хөгжиж буй орнуудад бус хөгжингүй орнуудыг чиглэж байгаа нь уул уурхайн олборлолтод суурилсан хөгжиж буй орнуудад томоохон сорилт хэвээр үлдэж байна.

Дүрслэл 1.13

Төлбөрийн тэнцэлийн алдагдал




Эх сурвалж: Монголбанк.  
Тэмдэглэл: \*Урьдчилсан гүйцэтгэл  
\*\*Чингис бонд, Самурай бонд, Хөгжлийн банкны гадаад зээл зэргийг хасч тооцсон болно.

2015 оны эхний 7 сарын урьдчилсан гүйцэтгэлээр төлбөрийн нийт тэнцэл 82.3 сая ам.долларын ашигтай гарсан бөгөөд энэ нь урсгал дансны бараа, үйлчилгээний алдагдал буурч, багцын хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр тайлбарлагдана.

Дүрслэл 1.14

Гадаадын шууд хөрөнгө оруулалт (цэвэр дүнгээр)



Эх сурвалж: Монголбанк.  
Тэмдэглэл: \*Төлбөрийн тэнцлийн 2015 оны эхний 7 сарын урьдчилсан гүйцэтгэл.

Нэг талаас гадаад, дотоод эдийн засгийн тааламжгүй нөхцөл байдлаас шалтгаалан Монгол Улсад орох гадаадын хөрөнгө оруулалт 2013 оноос хойш огцом буурсан, нөгөө талаас манай улсад үйл ажиллагаа явуулж буй гадны хөрөнгө оруулалттай компаниуд толгой компанидаа өр төлж<sup>9</sup> байгаатай уялдан хөрөнгө оруулалтын гарах урсгал нэмэгдсэн нь гадаадын шууд хөрөнгө оруулалт 2015 оны эхний 7 сард цэвэр дүнгээр 143.8 сая ам.долларт хүрч буурахад нөлөөлжээ.

Засгийн газар 2015 оны 6 дугаар сард 1 тэрбум юанийн Dim-Sum бондыг, Худалдаа хөгжлийн банк 2015 оны 5 дугаар сард олон улсын санхүүгийн зах зээлд 500 сая ам.долларын бондыг тус тус арилжиж,


<sup>9</sup> Төлбөрийн тэнцлийн олон улсын стандартын дагуу толгой болон охин компани хоорондын зээллэгийг гадаадын шууд хөрөнгө оруулалт дансанд бүртгэдэг бөгөөд уг зээл төлөгдөх үед тэр хэмжээгээр гадаадын шууд хөрөнгө оруулалтын данснаас хасагдаж, гадаад зээл буурдаг.

багцын хөрөнгө оруулалт тайлант оны эхний 7 сарын байдлаар 623.4 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 63 хувиар өслөө. Энэ нь хөрөнгө, санхүүгийн данс ашигтай гарахад шууд нөлөөлсөн байна.

2008 оноос хойш өндөр алдагдалтай явж ирсэн төлбөрийн урсгал тэнцлийн алдагдал эдийн засаг зөөлөн газардсантай уялдан 2015 оны эхний 7 сарын урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх оны мөн үеэс 12 дахин буурч, гадаад санхүүжилтийн хэрэгцээ шаардлага харьцангуй багаслаа. Урсгал тэнцлийн алдагдал эрс буурсан нь гадаад худалдаа тэнцвэржиж буйтай холбоотой бөгөөд ингэснээр гадаад валютын улсын нөөцөд ирэх дарамт, ачаалал буурч байна.

### Дүрслэл 1.15

Импортын жилийн өсөлт (жил бүрийн эхний 8 сарын байдлаар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар.

Гаалийн статистик мэдээгээр өмнөх оны эхний 8 сард -23 сая ам.долларын алдагдалтай гарч байсан гадаад худалдааны тэнцэл 2015 оны эхний 8 сард 705 сая ам.долларын ашигтай гарав. 2015 оны эхний 8 сард хүнд даацын машин, механизм, тоног төхөөрөмжийн импорт 36.5 хувиар, авто машин, түүний сэлбэг хэрэгслийн импорт 39.1 хувиар, барилгын материалын импорт 36.1 хувиар, нефтийн бүтээгдэхүүний импорт 36.0 хувиар буурсан нь нийт импортын 29

хувийн агшилтын 74 хувийг тайлбарлаж байна.

Нийт экспорт 2015 оны эхний 8 сарын байдлаар 9.1 хувиар буюу 325 сая ам.доллараар буурав. Оюу толгой компанийн зэсийн баяжмалын экспортын 201.6<sup>10</sup> сая ам.долларын өсөлтийг үл тооцвол зэс, цайр, алт, молибденээс бусад барааны экспорт өмнөх оноос багасчээ. Оюу толгойн зэсийн баяжмалын экспортын нөлөөг хасч тооцвол экспорт 29.4 хувиар буурахаар, гадаад худалдааны алдагдал 631.4 сая ам.доллартай тэнцэх байсан тооцоотой байна.


Хэдийгээр гадаад худалдаа тэнцвэржиж байгаа ч гадаад худалдааны нийт эргэлт өмнөх оны мөн үеэс 19.2 хувиар агшсан нь төсвийн орлого бүрдэлт, цаашлаад эдийн засгийн идэвхжилд сөрөг нөлөө үзүүлж байна.

2013 онд 11.6 хувь, 2014 онд 7.8 хувийн өсөлттэй байсан манай улсын эдийн засаг 2015 оны эхний хагасын урьдчилсан гүйцэтгэлээр 3.0 хувь болж өсөлт саараад байна. Тайлант улирлын байдлаар нийт салбаруудын хувьд өсөлт удаашрахын зэрэгцээ бөөний болон жижиглэн худалдаа, тээвэр ба агуулах, бүтээгдэхүүний цэвэр татвар гэсэн салбаруудад үйлдвэрлэл буурсан үзүүлэлт гарчээ. Хэдийгээр 2015 оны эхний хагаст эдийн засгийн өсөлт 3.0 хувьтай гарсан ч, үүний 3.2 хувь нь уул уурхай, олборлолтын салбарт бий болжээ.

<sup>10</sup> Оюу толгойн зэсийн олборлолт нэмэгдсэнтэй холбоотойгоор 2014 оны 3 дугаар сараас эхлэн зэсийн экспортын тоо хэмжээ өссөн. 2010 оны 1 дүгээр сараас 2014 оны 2 дугаар сард зэсийн экспортын тоо хэмжээ дунджаар сард 49.8 мянган тонн байв. 2015 оны 1-8 дугаар сарын экспортын тоо хэмжээнээс өмнөх хугацааны дунжыг (49.8 мянган тонн) хасч, хилийн үнэ (Оюу толгойн нэгж тонн баяжмалын үнэлгээ алт, цэвэр зэсийн агууламжаас шалтгаалан Эрдэнэтийн зэсийн баяжмалаас нэгжийн үнэ 70-75 хувиар өндөр байдаг)-ээр үржүүлэх замаар Оюу толгойн зэсийн экспортын орлогыг ойролцоогоор тооцсон болно.

**Дүрслэл 1.16**

**Улирлын ДНБ-ий жилийн өсөлт, 2010 оны үнээр**



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.  
Тэмдэглэл: \*Урьдчилсан гүйцэтгэл.

Төлбөрийн тэнцлийн хүндрэлээс үүдсэн эдийн засгийн хүндрэл, удаашралын сөрөг нөлөөгөөр худалдааны салбар, нийт импорт агшиж, татварын суурь хумигдаж байгаатай холбоотойгоор бүтээгдэхүүний цэвэр татварын эдийн засгийн өсөлтөд оруулж буй хувь нэмэр улам бүр багасаж, улмаар сүүлийн 7 улирал дараалан сөрөг утгатай гараад байна. Үүнээс үзэхэд улсын төсвийн уул уурхайн салбараас хамаарах хамаарлыг багасгах зайлшгүй тохиргоо шаардлагатай байна.

2015 оны эхний 7 сард Монгол Улсын нэгдсэн төсөвт 3145 тэрбум төгрөг төвлөрч, орлогын төлөвлөгөө 15 хувиар буюу 547 тэрбум төгрөгөөр тасарсны 53.7 хувь нь импортоос шууд хамааралтай татварын орлогын тасралт байлаа.

Харин төсвийн зарлагын хувьд эхний 7 сард 75 хувийн гүйцэтгэлтэй буюу 3781 тэрбум төгрөг, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 638 тэрбум төгрөгийн алдагдалтай гарав. Төсвийн зарлагын гүйцэтгэл төлөвлөсөн хэмжээнээс 1248 тэрбум төгрөгөөр дутуу биелэлттэй гарахад орлогын тасралт төдийгүй алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэрүүд тэр дундаа

Засгийн газрын Монголбанк болон арилжааны банкин дахь харилцах, хадгаламжийн данснаас олгох санхүүжилт, Засгийн газрын зээлийн санхүүжилтийн дутуу гүйцэтгэлүүд голлон нөлөөлөв.

**Хүснэгт 1.1**

**Төсвийн орлогын тасралт (2015 оны эхний 7 сарын байдлаар)**


Татварын төрөл	Хэмжээ (тэрбум)	Хувь
<b>Төсвийн орлогын тасралт</b>	<b>547</b>	
<b>Татварын орлогын тасралт</b>	<b>238</b>	<b>100%</b>
Үүнээс:		
ААНОАТ	44	19%
Хувь хүний орлогын албан татвар	18	8%
Суудлын автомашины онцгой албан татвар	30	12%
Импортын гаалийн албан татвар	44	18%
Импортын барааны НӨАТ	212	89%
<b>Татварын бус орлогын тасралт</b>	<b>297</b>	<b>100%</b>
Үүнээс:		
Газрын тосны орлого	56	19%
Өмч хувьчлалын орлого	140	47%
Хандив тусламж/гадаад/	26	9%

Эх сурвалж: Сангийн яам.

2015 он гарсаар мөнгөний үзүүлэлтүүдийн өсөлт үргэлжлэн саарч байна. Тухайлбал, 2015 оны 7 дугаар сарын байдлаар М2 мөнгөний өсөлт -2.1 хувь, М1 мөнгөний өсөлт -2.6 хувь, банкны зээлийн өсөлт -2.3 хувь, харилцах, хадгаламжийн өсөлт -2.3 хувь байна. Үүнд: (i) төлбөрийн тэнцлийн хүндрэлээс шалтгаалсан гадаад цэвэр активын бууралт, (ii) хөтөлбөрийн зээл хуваарийн дагуу төлөгдөж буйтай холбоотойгоор төв банкнаас банкуудад байршуулсан эх үүсвэр, олгосон зээлийн бууралт, (iii) санхүүгийн зах зээлийн нөхцөл чангарсан, эдийн засгийн идэвхжил удааширнаас банкууд шинээр зээл олгох нь эрсдэлтэй гэж үзэн зээлээ хумьсан, (iv) макро бодлогын нэгдсэн өөрчлөлтөөр эдийн засгийн тэнцвэрийг хангахыг зорьж байгаа зэрэг нь нөлөөлж байна.

**Дүрслэл 1.17**

Гадаад, дотоод цэвэр актив ба M2 мөнгө



Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2015 оны 7 дугаар сарын статистик болно.


Төсвийн алдагдал өсч, мөнгөний нийлүүлэлт хумигдаж буй нөхцөлд эдийн засагт өсч буй эрсдэлийн түвшинг дагаад мөнгөний захын хүү өсөх бөгөөд энэ нь цаашлаад санхүүгийн систем болон түүний оролцогчдын хөрвөх чадварыг бууруулж, улмаар санхүүгийн болон санхүүгийн бус активуудын үнийг бууруулдаг. Ийнхүү активын үнэ үргэлжлэн буурах нь санхүүгийн зах зээлд оролцогчдын хувьд төлбөрийн чадварын эрсдэлийг нэмэгдүүлж, санхүүгийн салбарт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй юм.

Иймд, өнөөгийн эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдалд санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах зорилгоор зах зээл дэх хөрвөх чадварыг хадгалах, болзошгүй эрсдэлийг бууруулах нь чухал юм. Гэхдээ мөнгөний бодлогоор зах зээлийн хөрвөх чадварыг хадгалах боломж хомс байгаа өнөөгийн нөхцөлд гадаад валютын тогтвортой орох урсгалыг нэмэгдүүлэх замаар төлбөрийн тэнцлийг ашигтай байлгах арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлэх шаардлагатай хэвээр байна. Төлбөрийн тэнцлийг сайжруулахын тулд валютын төлбөртэй экспортыг нэмэгдүүлэх, гадаадын шууд хөрөнгө оруулалт болон багцын

хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх шаардлагатай юм.

**Дүрслэл 1.18**

Засгийн газрын үнэт цаасны хүү





Эх сурвалж: Сангийн яам, Монголбанк.

Төсөв, мөнгөний бодлого нь эдийн засагт бий болсон сөрөг шокын нөлөөллийг сулруулж, эдийн засгийг тогтворжуулах, улмаар эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийн суурь нөхцөлийг хангах үндсэн зорилготой. Энэ хүрээнд эдийн засагт шаардлагатай хуримтлал, хамгаалалт (buffer)-ыг бүрдүүлэх шаардлагатай. Тэрхүү хуримтлал, хамгаалалт нь нэг талаас төсвийн тогтворжуулалтын сан, баялгийн сан, институциональ хөрөнгө оруулалтын сан хэлбэрээр ажиллах, дахин хөрөнгөжүүлсэн нийгмийн даатгалын сан зэрэг тусгай зориулалтын нөөц сангуудын хуримтлал, нөгөө талаас гадаад цэвэр актив, гадаад валютын улсын нөөцийн түвшин зэргээр хэмжигдэнэ. Эдийн засгийн өрнөлийн үед мөчлөг сөрсөн бодлого хэрэгжүүлж, хуримтлал бий болгосноор уналтын үед харьцангуй бага зардалтайгаар хүндрэлээс гарах нөхцөл бүрдэнэ. Үүний тулд хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, ялангуяа дүрэмд суурилсан, сахилга сайтай төсвийн бодлого хэрэгжүүлэх нь чухал ач холбогдолтой. Тогтворжуулах зорилгоор хэрэгжүүлж буй богино хугацааны макро эдийн засгийн бодлогоор урт хугацааны

эдийн засгийн хөгжлийг зорилт болгох нь хангалттай бус юм. Харин макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах бодлогын зэрэгцээ эдийн засгийн бүтцийг сайжруулахад чиглэсэн урт хугацааны бодлого шаардлагатай юм.

**Дүрслэл 1.19**

**Төсөв болон мөнгөний бодлогын хүрээнд эдийн засагт хийгдсэн санхүүжилтийн бүтэц ба эдийн засгийн өсөлт**




**Эх сурвалж:** Монголбанк, Сангийн яам, Хөгжлийн банк.  
**Тэмдэглэл:** Өмнөх жилүүдэд төсөв болон мөнгөний бодлогын хүрээнд эдийн засагт нийлүүлэгдсэн нийт санхүүжилт, түүний бодит эдийн засгийн өсөлтийн хамаарлын талаарх дэлгэрэнгүй тайлбартай уг тайлангийн 3 дахь дугаараас танилцана уу (19-20 дахь тал).

Инфляцийн түвшин 2014 оны 8 дугаар сараас эхлэн үргэлжлэн буурч байгаа нь нэг талаас нийлүүлэлтийн гаралтай инфляцийг бууруулсан үнэ тогтворжуулах хөтөлбөрийн

ээрэг нөлөө, нөгөө талаас нийт эрэлтийг хумьж, мөнгөний бодлогоор макро эдийн засгийн гадаад тэнцвэрийг дэмжсэн болон төлбөрийн тэнцэл 2015 оны эхнээс алдагдалгүй байхын хэрээр валютын зах тогтворжиж, төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн инфляци дахь сөрөг нөлөө саармагжсантай холбоотой.

**Дүрслэл 1.20**

**Инфляцийн задаргаа**



**Эх сурвалж:** Үндэсний статистикийн хороо, Монголбанк.  
**Тэмдэглэл:** Хамгийн сүүлийн утга нь 2015 оны 7 дугаар сарын статистик болно.

2015 оны 7 дугаар сард улсын хэрэглээний үнийн индекс жилийн **6.9** хувиар, Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индекс жилийн **6.6** хувиар тус тус өссөн. 7 дугаар сарын Улаанбаатар хотын жилийн инфляцийг бүтцээр нь задлан авч үзвэл 5.1 хувийг (0.3 нэгж хувь) мах, 15.3 хувийг (1.0 нэгж хувь) махнаас бусад хүнсний бүтээгдэхүүн, 12.0 хувийг (0.8 нэгж хувь) хувцас, 30.3 хувийг (2.0 нэгж хувь) орон сууц, ус, түлш, цахилгааны үнийн өсөлт тайлбарласан бол үлдсэн 37.2 хувийг (2.5 нэгж хувь) бусад бараа, үйлчилгээний үнийн өсөлт бий болгосон байна.


ГАДААД СЕКТОР

**Нийт төлбөрийн тэнцэл**

Монгол Улсын төлбөрийн тэнцэл 2015 оны эхний 7 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 82.3 сая ам.долларын ашигтай гарч, төлбөрийн тэнцэл өмнөх оны мөн үеэс 109 хувиар буюу 1017.5 сая ам.доллараар сайжирчээ. Урсгал дансны алдагдал 69.0 хувиар буурч, хөрөнгө санхүүгийн дансны ашиг өнгөрсөн оны гүйцэтгэлээс 58.0 хувиар өссөн нь нийт тэнцэлд эергээр нөлөөлөв.

**Дүрслэл 1.21**

Төлбөрийн тэнцлийн гүйцэтгэл (сая ам.доллар)



Эх сурвалж: Монголбанк.  
Тэмдэглэл: \*Урьдчилсан гүйцэтгэл.


**Урсгал данс**

Төлбөрийн тэнцлийн урсгал данс 2015 оны эхний 7 сард 410.2 сая ам.долларын алдагдалтай гарч, алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 69.0 хувиар буюу 912.3 сая ам.доллараар буурсан. Урсгал тэнцлийн алдагдал буурахад өнгөрсөн онд 69.0 сая ам.доллар байсан барааны гадаад худалдааны ашиг энэ онд 12 дахин өсч 817.9 сая ам.долларт хүрсэн нь голлох нөлөөг үзүүлсэн. Түүнчлэн үйлчилгээний худалдааны алдагдал өнгөрсөн оноос 42.6 хувиар буюу 415.6 сая ам.доллараар буурчээ. Энэ нь гадаад

худалдааны эргэлт, тэр дундаа импортын бууралттай шууд холбоотой байна.

**Дүрслэл 1.22**

Урсгал тэнцлийн бүтэц




Эх сурвалж: Монголбанк.  
Тэмдэглэл: \*Урьдчилсан гүйцэтгэл.

Урсгал тэнцлийн алдагдал 2015 оны эхний хагаст ДНБ-ий -6.1 хувь болж буурсан.

**Дүрслэл 1.23**

Урсгал тэнцлийн санхүүжилт



Эх сурвалж: Монголбанк.  
Тэмдэглэл: \*Урьдчилсан гүйцэтгэл.

Урсгал дансны алдагдлыг хөрөнгө оруулалтын орох урсгал өндөр байсан 2010-2012 онд гадаадын шууд хөрөнгө оруулалт, зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлж байсан

бол 2013-2014 онд гадаад зээл<sup>11</sup> болон гадаад валютын улсын нөөцөөр санхүүжүүлжээ. Харин 2015 оны 2 дугаар улиралд Засгийн газар 1 тэрбум юанийн бондын санхүүжилт, Худалдаа хөгжлийн банк олон улсын зах зээлээс 500 сая ам.долларын бондын санхүүжилт татсан нь урсгал тэнцлийн алдагдлыг нөхөхөд голлон нөлөөлсөн.

### Хүснэгт 1.2

Урсгал тэнцлийн алдагдлын санхүүжилт

Огноо	Зээлийн санхүүжилт	Зээлийн бус санхүүжилт	Гадаад валютын нооц
2009	73%	189%	-163%
2010	20%	179%	-98%
2011	2%	99%	-1%
2012	16%	134%	-51%
2013	23%	18%	58%
2014	41%	26%	34%
2015.1-7	-31%	151%	-20%


Эх сурвалж: Монголбанк.

### Хөрөнгө, санхүүгийн данс

Хөрөнгө, санхүүгийн данс 2015 оны эхний 7 сарын байдлаар 661.0 сая ам.долларын ашигтай гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 58.0 хувиар буюу 242.6 сая ам.доллараар өссөн үзүүлэлт юм.

### Дүрслэл 1.24

Хөрөнгө, санхүүгийн дансны бүтэц (сая ам.доллар)



Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: \*Урьдчилсан гүйцэтгэл.

<sup>11</sup> Зээлийн санхүүжилт нь төлбөрийн тэнцлийн тайлангийн бусад хөрөнгө оруулалт хэсгийн худалдааны зээл болон зээлийн дүнгийн нийлбэртэй тэнцүү.

Хөрөнгө, санхүүгийн дансны ашиг ийнхүү нэмэгдэхэд багцын хөрөнгө оруулалт болон бэлэн мөнгө, харилцах өмнөх оны мөн үеэс харгалзан 57.6, 71.3 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ. Харин гадаадын шууд хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 3 дахин буураад байна.

### Гадаад худалдаа

2015 оны 8 дугаар сард экспортын үнийн индекс 26 хувиар буурч, импортын үнийн индекс 8 хувиар буурснаар Монгол Улсын гадаад худалдааны нөхцөлийн индекс (2012 оны 12 сарын суурьтай) 1.313-д хүрч, өнгөрсөн оноос 19 хувиар муудлаа.

### Дүрслэл 1.25

Гадаад худалдааны нөхцөлийн индекс




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар, Монголбанк.

Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2015 оны 8 дугаар сарын статистик болно.

2015 оны эхний 8 сарын байдлаар экспорт өнгөрсөн оны мөн үеэс 9.1 хувиар буурсан бөгөөд гол нэрийн бүтээгдэхүүний ангиллаар авч үзвэл зэсийн баяжмал 8.1 хувиар (3.3 нэгж хувь) өссөн бол боловсруулаагүй нефть 40.6 хувиар (-5.0 нэгж хувь), чулуун нүүрс 31.3 хувиар (-5.1 нэгж хувь), төмрийн хүдэр ба баяжмал 48.0 хувиар (-3.9 нэгж хувь) тус тус буурчээ.

**Дүрслэл 1.26**

**Нийт экспорт (жил бүрийн эхний 8 сарын байдлаар)**




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар.  
Тэмдэглэл: \*Оюу толгойн зэсийн баяжмалын экспортыг хассан тооцоо.

Экспортын өсөлт нь үндсэндээ Оюу толгойн зэсийн баяжмалын экспортоор бий болсон бөгөөд Оюу толгойг хасч тооцвол манай улс энэ оны эхний 8 сард 1.9 тэрбум долларын экспортыг хийжээ.

**Дүрслэл 1.27**

**Нийт импорт (жил бүрийн эхний 4 сарын байдлаар)**



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар.

Импорт өнгөрсөн оны мөн үеэс 29.3 хувиар буурсан бөгөөд гол нэрийн бүтээгдэхүүний ангиллаар авч үзвэл хэрэглээний


бүтээгдэхүүн 21.0 хувиар (-5.4 нэгж хувь), аж үйлдвэрийн орц 12.1 хувиар (-1.3 нэгж хувь), хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн 36.3 хувиар (-15.2 нэгж хувь), нефтийн бүтээгдэхүүн 36.0 хувиар (-7.6 нэгж хувь) тус тус буурсан байна.

**Гадаад валютын ханш**

Төгрөгийн ам.доллартай харьцах Монголбанкнаас зарласан ханш 2015 оны 8 дугаар сард 1990.5 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 6.9 хувиар суларсан бол нэрлэсэн үйлчилж буй ханш (NEER) 2015 оны 8 дугаар сарын байдлаар 9.9 хувиар, бодит үйлчилж буй ханш (REER) 2015 оны 7 дугаар сарын байдлаар 10.9 хувиар тус тус чангарсан байна. Нэрлэсэн үйлчилж буй ханшийн чангаралт нь ОХУ-ын рубль ам.долларын эсрэг огцом суларсантай холбоотойгоор дотоодын валютын зах дээр рублийн эсрэг төгрөгийн ханш чангарсантай холбоотой юм.<sup>12</sup>

**Дүрслэл 1.28**

**Гадаад валютын ханш (жилийн өсөлтийн хувь)**



Эх сурвалж: Монголбанк.

**Гадаад өр**

Монгол Улсын нийт гадаад өр (улсын болон хувийн сектор) 2015 оны эхний хагаст өмнөх

<sup>12</sup> Нэрлэсэн болон бодит үйлчилж буй ханшийг гадаад худалдааны түнш орнуудтай хийсэн худалдааны жингээр жигнэж тооцдог болно.



оноос 9 хувиар буюу 1786.6 сая ам.доллараар нэмэгдэж, 21.7 тэрбум ам.долларт хүрээд байна. Гадаад өрийн бүтцийн хувьд Төв банкны гадаад өглөг 811.0 сая ам.доллараар, хувийн хэвшлийн гадаад өр 906.1 сая ам.доллараар тус тус нэмэгдэж, харин Засгийн газрын гадаад өр<sup>13</sup> 69.4 сая ам.доллараар өсч, 3.7 тэрбум ам.долларт буюу ДНБ-ий 30.9 хувьд<sup>14</sup> хүрсэн үзүүлэлттэй байна.

### Хүснэгт 1.3

#### Монгол Улсын нийт гадаад өр (сая ам.доллар)

Үзүүлэлт	2012	2013	2014	2015HI	Өөрчлөлт	
					Дүн	Хувь
<b>Нийт гадаад өр</b>	<b>15 386</b>	<b>19 022</b>	<b>20 942</b>	<b>21 673</b>	<b>1 787</b>	<b>9%</b>
<b>I. Засгийн газар</b>	<b>3 684</b>	<b>3 684</b>	<b>3 610</b>	<b>3 741</b>	<b>69</b>	<b>2%</b>
II. Төвбанк*	415	1 065	1 568	1 851	811	78%
III. Банк	1 074	1 298	1 629	2 100	641	44%
Богино хугацаат	58	200	315	277	62	29%
Урт хугацаат	1 016	1 098	1 314	1 823	579	47%
<b>IV. Бусад сектор</b>	<b>1 856</b>	<b>2 633</b>	<b>3 522</b>	<b>3 458</b>	<b>418</b>	<b>14%</b>
Богино хугацаат	508	406	562	351	-106	-23%
Урт хугацаат	1 348	2 228	2 960	3 107	524	20%
<b>V. Шууд хөрөнгө оруулалт</b>	<b>8 357</b>	<b>10 341</b>	<b>10 615</b>	<b>10 522</b>	<b>-153</b>	<b>-1%</b>

Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: \*БНХАУ-ын Ардын банкттай хийсэн своп хэлцлийн ашигласан дүнг оруулж тооцдог болно.

### Гадаад валютын улсын нөөц

2015 оны 7 дугаар сарын байдлаар ГВУН өмнөх оноос 36.5 хувиар буюу 456.5 сая ам.доллараар өсч 1707.2 сая ам.долларт хүрлээ. Гадаад валютын улсын нөөцөөр импортын хэрэгцээг хангах түвшин<sup>15</sup> 4.9 сард хүрч өмнөх оны үзүүлэлтээс сайжирлаа.


<sup>13</sup> Засгийн газрын баталгаа бүхий гадаад зээлийг оруулаагүй.

<sup>14</sup> 2014 оны нэрлэсэн ДНБ-ий гүйцэтгэлийг 2014 оны дундаж ханшаар хөрвүүлэв.

<sup>15</sup> ГВУН-ийг валютын төлбөртэй импортын сүүлийн 3 сарын дундаж үзүүлэлтэд харьцуулж тооцсон.

### Дүрслэл 1.29

#### Гадаад валютын улсын нөөц



Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2015 оны 7 дугаар сарын статистик болно.

### Хөрөнгө оруулалтын орчин

Олон улсын зэрэглэл тогтоогч Фитч, Стандарт энд пүүрс, Мүүдиз агентлагуудаас тогтоож буй Монгол Улсын зээлжих зэрэглэлийн өөрчлөлтөөс үзэхэд сүүлийн жилүүдэд манай улсын зэрэглэл<sup>16</sup> болон төлөв<sup>17</sup> буурснаар хөрөнгө оруулалтын хувьд өндөр эрсдэлтэй орны ангилалд хамрагдах болсон.


Стандарт энд пүүрс агентлаг хамгийн сүүлд буюу 2015 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр Монгол Улсын зээлжих зэрэглэлийн төлөвийг тогтвортойгоос сөрөг төлөвт шилжүүлсэн бөгөөд зээлжих зэрэглэлийг В+ хэвээр үлдээсэн.

<sup>16</sup> Тухайн улсын Засгийн газрын зээлийн чадварыг илэрхийлдэг ба худалдааны нөхцөлтэй авсан өр төлбөрөө хугацаанд нь, бүтнээр эргэн төлөх чадвартай эсэх мөн тус үүргээ биелүүлэх бэлэн байдлыг харуулдаг.

<sup>17</sup> Зээлжих зэрэглэлийн хандлагыг илтгэх бөгөөд “эерэг” төлөв нь зэрэглэл дээшлэх боломжийг, “сөрөг” төлөв нь зэрэглэл буурч болох эрсдэл байгааг илэрхийлнэ.

### Дүрслэл 1.30

Монгол Улсад хөрөнгө оруулсан гадаадын уул уурхайн компаниудын олон улсын бирж дэх хувьцааны үнэ



Эх сурвалж: Блүмберг, Монголбанк.  
Тэмдэглэл: 2011 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн үнийг 1 байхаар тус бүр индексжүүлсэн.

Үүнд төсвийн болон урсгал тэнцлийн алдагдал, гадаад орчны таагүй нөхцөл байдал, өсөн нэмэгдэж буй гадаад өрийн дарамт зэрэг хүчин зүйлс голлон нөлөөлсөн болохыг дурджээ.

### Хүснэгт 1.4

Монгол Улсын зээлжих зэрэглэлийн өөрчлөлт

Огноо	Moody's		Fitch		Standard and Poors'	
	Үнэлгээ	Төлөв	Үнэлгээ	Төлөв	Үнэлгээ	Төлөв
2005	VII/18		B+	**	-	
	X/4	B1	**	-		
	XI/1				B	**
	XII/29			B	*	↗
2006	XII/26				B+	▲
2007	XII/13				BB-	▲
	IX/20		B+	*	↗	
2008	VI/2		B+	**	-	
	XII/9		B+	***	↘	
	XII/19				BB-	***
2009	I/18		B	▼	***	↘
	VI/10	B1	***	↘		
	X/30	B1	**	-		
	X/11		B	**	-	
	XI/20				BB-	**
2010	XI/23		B+	▲	**	-
2011	XII/19				BB-	*
2012	X/29				BB-	**
	IV/16				BB-	***
2013	XII/13		B+	***	↘	
2014	IV/29				B+	▼
	V/26	B1	***	↘		**
	VII/17	B2	▼	***	-	
	XII/11		B+	***	-	
2015	IV/29				B+	***

Зэрэглэлийн өөрчлөлт ▲, ▼; төлвийн өөрчлөлт ↗, ↘


\*-ээрэг, \*\*-тогтвортой, \*\*\*-сөрөг

Эх сурвалж: Moody's, Fitch, S&P's, Монголбанк.

2015 он гарсаар Монгол Улсын Засгийн газрын олон улсад гаргасан бондын үнэ өсч эхэлсэн боловч дэлхийн зах зээл дэх түүхий эдийн үнэ буурч, дотоодын улс төрийн орчны нөхцөл байдлаас болж 6 дугаар сараас эхлэн бондын үнэ хурдтай буурсан гэж шинжээчид үзэж байна.

### Дүрслэл 1.31

Гадаад зах зээлд гаргасан Монгол Улсын Засгийн газрын бондын үнэ (ам.доллар)



Эх сурвалж: Блүмберг.

Тэмдэглэл: \*Хамгийн сүүлийн утга нь 2015 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн статистик болно. Бондын үнэ болон өгөөж (хүү) нь урвуу хамааралтай бөгөөд үнэ өсөх нь тухайн бондын эрсдэл буурч байгааг илтгэнэ.

### Шигтгээ 1: Газрын тосны бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэл ба бодлого

Нэг талаас дэлхийн эдийн засгийн таагүй нөхцөл байдал, түүнээс улбаалсан хүлээлт, геополитикийн болон улс төрийн шалтгаантай хоригууд нь дэлхийн зах зээл дээрх бүтээгдэхүүн, түүхий эдийн эрэлт, тэр дотроо газрын тосны эрэлт хүлээгдэж байснаас бага түвшинд байх нөхцөлийг бүрдүүлсэн, нөгөө талаас газрын тосны бүтээгдэхүүний гол ханган нийлүүлэгч болох ОПЕК-ийн гишүүн орнууд газрын тосны нийлүүлэлтийн хэмжээгээ бууруулахгүй байгаа зэрэг нь дэлхийн зах зээл дэх газрын тосны үнэ буурах суурь хүчин зүйл болж байна. Тухайлбал, 2014 оны 6 сард дэлхийн зах зээл дээр \$108/баррель байсан газрын тосны үнэ тасралтгүй унасаар 2015 оны 3 сард \$53/баррель болоод байгаа юм. Үнийн энэхүү огцом уналтаас шалтгаалан газрын тос нийлүүлэгч орнуудын экспортын орлого буурч, улмаар төсвийн алдагдал өсөх, эдийн засгийн өсөлт нь саарах, үндэсний валютынх нь ханш сулрах зэрэг нийтлэг хүндрэл ажиглагдаж байгаа бол газрын тос импортлогч орнуудын хувьд энэ нь эсрэгээрээ гадаад орчны харьцангуй таатай нөхцөлийг бий болгоод байгаа юм.

Эрчим хүчний татаасыг улсын төсвөөс олгох замаар дотооддоо шатахууны үнэд зохицуулалт хийдэг явдал олон улсад түгээмэл билээ. Нэг жишээ дурдахад, Индонез улс 1949 онд тусгаар тогтнолоо олсныхоо дараа засгийн газраас нь зарим улсын үйлдвэрүүдэд их хэмжээний татаас олгосон. Тухайлбал, бага, дунд орлоготой өрхийн бодит орлогыг хамгаалахын тулд шатахуун болон будаанд улсын төсвөөс татаас олгож эхэлсэн. 1960-аад онд шинэ засгийн газар сонгогдож, татаасын бодлогыг зогсоож, үнийг зах зээлийн механизмд шилжүүлэх оролдлого хийсэн боловч улс төр, олон нийтийн хүчтэй эсэргүүцэлтэй тулгарсан бөгөөд өнөөг хүртэл шатахууны үнэнд татаас өгөх бодлогоо үргэлжлүүлсээр байна. Газрын тосны үнэ өсөхийн хэрээр төсөвт ачаалал нэмэгдсээр ирсэн бөгөөд сүүлийн 10 жилийн дунджаар шатахууны татаас төсвийн зардлын 10 хувьтай тэнцэж байна.<sup>18</sup> Харин шинжээчдийн зүгээс сүүлийн саруудад газрын тосны үнэ огцом буурсан энэ үеийг дэлхий нийтээрээ эрчим хүчний татаасаа бууруулах, үнийг зах зээлийн механизмд шилжүүлэх цонх үе буюу алтан боломж хэмээн онцлоод байгаа юм. Гэхдээ үнэ эргээд өсөх үед түүний инфляци дахь сөрөг нөлөөллийг бууруулах зах зээлийн зарчимд суурилсан механизм бүрдүүлэх нь чухал байна.

Дэлхийн зах зээл дээр газрын тосны үнэ буурч буйтай холбоотойгоор манай улсын импортолж буй шатахууны хилийн үнэ дагаад буурсан бөгөөд энэ хэрээр шатахууны импорт буурсан байна. Тодруулбал, 2015 оны эхний 3 сард шатахууны импортын биет хэмжээ өмнөх оны мөн үеэс 20 хувиар өссөн байхад үнийн дүн нь 32 хувиар буурсан. 2014 оны үнээр тооцвол энэ оны эхний 3 сард үнийн бууралтын нөлөөгөөр шатахууны импортоос 114 сая ам.долларын хэмнэлт бий болжээ.

Засгийн газраас гадаад худалдааны бодлогоор дамжуулан дотоодын шатахууны үнэд тодорхой зохицуулалтыг хийсээр ирсэн билээ. Хилээр орж ирж буй шатахууны үнэ өндөр үед онцгой албан татвар болон гаалийн татварыг бууруулж, эсрэг тохиолдолд татварыг сэргээх замаар дотоодын жижиглэнгийн үнийн тогтвортой байдлыг хангахад тодорхой хэмжээний үүрэг гүйцэтгэдэг. 2012 оноос хойш шатахууны импортын татварыг 3 удаа өсгөж, 3 удаа бууруулжээ. Хамгийн сүүлд буюу 2015 оны 1, 2 дугаар сард газрын тосны үнэ буурч буйтай уялдуулан шатахууны импортын татварыг нэмэгдүүлэх зохицуулалтыг хийсэн. Одоогийн байдлаар тонн тутамд АИ-80 шатахуун


<sup>18</sup> Magnus Jul Røsjø (2014), “The adverse effect of fossil-fuel subsidies in Indonesia”, University of Oslo, Norway.

хувьд 252 мянган төгрөг, АИ-92 бинзений хувь 259 мянган төгрөг, дизелийн түлшний хувьд 265 мянган төгрөгийн онцгой албан татвар, 5 хувийн гаалийн албан татвар тус тус мөрдөгдөж байна. Энэхүү зохицуулалт хийгдэхээс нэг жилийн өмнөх хугацаанд нэг тонн АИ-80 шатахуун болон дизелийн түлшинд 30 мянган төгрөгийн онцгой, бүх төрлийн шатахуунд 1 хувийн гаалийн албан татвар тус тус ногдож байв. Харин АИ-92 шатахууны импортыг онцгой албан татвараас чөлөөлөх зохицуулалттай байсан.

Үүний зэрэгцээ 2012 оны 10 дугаар сараас Монголбанк Засгийн газартай хамтран валютын ханшийн өөрчлөлтөөс хамаарах эрсдэлийг бууруулах, шатахуун, эргэлтийн хөрөнгийн зээлийг банкуудаас олгох замаар шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтвортой байлгах зорилго бүхий “Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн. Аливаа барааны үнэ бүрдэхэд суурь хүчин зүйл, өдөөгч болдог шатахууны үнэ тогтвортой байснаар тээврийн зардлын өсөлт буурч, улмаар инфляци нам түвшинд, тогтворжиход чухал ач холбогдолтой юм.

**Дүрслэл 1.32**

**Шатахууны үнэ ба импортын тоо хэмжээ, үнийн дүн**



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар, Монголбанк, Үндэсний статистикийн хороо, Сангийн яам.  
Тэмдэглэл: 4 дүгээр дүрслэлд жижиглэнгийн үнэ болон хилийн үнийг 2006.0 =100 байхаар индексжүүлэв.

Хөтөлбөр хэрэгжихээс өмнө шатахууны жижиглэнгийн үнэ хилийн үнэтэй маш ойролцоо түвшинд, хэлбэлзэл өндөртэй явж ирсэн. 2012 оноос хойш жижиглэнгийн үнэ маш тогтвортой

болсон төдийгүй хилийн үнээс нэлээд доогуур тогтож байгаа нь дэд хөтөлбөр нефть импортлогч компаниудын гол эрсдэлүүдийн нэг болсон ханшийн эрсдэлийг бууруулж чадсаныг харуулж байна. Ингэснээр инфляци буурах, иргэдийн бодит орлогод ирж буй ачааллыг зөөллөх, үнийн огцом өсөлт бий болох эрсдэлийг арилгахад уг хөтөлбөр чухал үүрэг гүйцэтгэжээ.

## БОДИТ СЕКТОР

Эдийн засгийн өсөлт саарч, 2015 оны эхний 2 улирлын урьдчилсан гүйцэтгэлээр 3.0 хувьд хүрлээ. Энэхүү өсөлтийн 3.2 нэгж хувийг уул уурхайн салбар дангаараа бүрдүүлжээ.

### Хүснэгт 1.5

**Бодит салбарын үндсэн үзүүлэлтүүд, 2010 оны зэрэгцүүлэх үнээр**

	2014					2015*		
	I	II	III	IV	I-IV	I	II	I-II
<b>Бодит ДНБ, тэрбум төгрөг</b>	<b>2 729</b>	<b>4 113</b>	<b>4 431</b>	<b>4 202</b>	<b>15 474</b>	<b>2 846</b>	<b>4 201</b>	<b>7 048</b>
Уул уурхайн	618	696	1 044	1 103	3 461	705	827	1 531
Уул уурхайн бус	2 111	3 417	3 387	3 099	12 014	2 142	3 375	5 516
<b>Бодит ДНБ-ий өсөлт</b>	<b>7.2%</b>	<b>8.9%</b>	<b>9.9%</b>	<b>5.1%</b>	<b>7.8%</b>	<b>4.3%</b>	<b>2.1%</b>	<b>3.0%</b>
Уул уурхайн	19.4%	5.0%	35.3%	15.6%	19.1%	14.0%	18.8%	16.5%
Уул уурхайн бус	4.1%	9.7%	3.9%	1.9%	5.0%	1.5%	-1.2%	-0.2%


Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

Тэмдэглэл: \*Урьдчилсан гүйцэтгэл.

2015 оны эхний 2 улиралд уул уурхай, боловсруулах үйлдвэрлэл, хөдөө аж ахуй болон зарим үйлчилгээний салбарууд өндөр өсөлттэй байсан бол худалдаа, бүтээгдэхүүний цэвэр татвар буурч, эдийн засгийн өсөлтийг нийтдээ 2.9 нэгж хувиар сааруулах нөлөөг үзүүлжээ.

### Дүрслэл 1.33

**Эдийн засгийн өсөлтийн задаргаа**



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

Тэмдэглэл: \*Урьдчилсан гүйцэтгэл.

Харин цахилгаан, дулаан, уур, ус хангамж, мэдээлэл, холбоо болон барилгын салбарууд өсөлтийг бага хувиар буюу нийтдээ 0.2 орчим нэгж хувиар нэмэгдүүлэх нөлөө үзүүлжээ.

Импорт буурч, өрхийн хэрэглээний өсөлт саарснаас худалдааны салбар тайлант хугацаанд 7.6 хувиар буурсан бол нэмэгдсэн өртгийн албан татвар, импортын бараанд ногдуулдаг гаалийн албан татварын бууралтаас шалтгаалж бүтээгдэхүүний цэвэр татвар 14.3 хувиар хумигдсан байна.

### Хүснэгт 1.6

**ДНБ-ий бодит өсөлт (салбаруудаар)**

Бодит ДНБ	2014		2015Q1-Q2	
	7.8%	100%	3.0%	100%
1 Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	1.6%	20.2%	1.3%	43.5%
2 Уул уурхай, олборлолт	3.9%	49.8%	3.2%	105.6%
3 Боловсруулах үйлдвэрлэл	0.3%	3.5%	0.3%	9.3%
4 Цахилгаан, хий, уур, агааржуулалт	0.1%	1.0%	0.1%	2.6%
5 Барилга	0.0%	0.6%	0.0%	1.3%
6 Бөөн/жиж худалдаа; машин, мотоцикл засвар үйлчилгээ	0.1%	1.1%	-0.9%	-29.4%
7 Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	0.8%	10.5%	-0.2%	-8.3%
8 Мэдээлэл, холбоо	0.2%	2.4%	0.0%	1.5%
9 Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	2.0%	25.9%	1.2%	41.0%
10 Бүтээгдэхүүний цэвэр татвар	-1.1%	-14.1%	-2.0%	-67.1%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа, худалдаа, барилга, уул уурхай болон боловсруулах салбаруудад олгосон зээл нь банкуудын зээлийн өрийн үлдэгдлийн дийлэнх хувийг эзэлдэг бөгөөд 2015 оны эхний 2 улиралд эдгээр салбаруудаас боловсруулах үйлдвэрлэлээс бусад салбарын өсөлт саарч, тэр дундаа худалдааны салбарын өсөлт ийнхүү сөрөг гараад байна.

**Шигтгээ 2: Хуримтлал ба эдийн засгийн өсөлт**

1960-аад оны үед нэг хүнд ногдох ДНБ нь ойролцоо түвшинд байсан Зүүн Азийн болон Латин Америкийн орнуудад сүүлийн 50 гаруй жилийн хугацаанд эдийн засгийн өсөлтийн ихээхэн ялгаатай байдал ажиглагдав. Тус хугацаанд эдгээр бүс нутгуудад өмчийн эрхийн хамгаалалт болон санхүүгийн салбарын хөгжил харилцан адилгүй байсны зэрэгцээ анхаарал татахуйц нэг зүйл нь дотоод хуримтлалын түвшин нь нэлээд зөрүүтэй байв<sup>19</sup>. Зүүн Азийн орнуудын эдийн засгийн огцом өсөлтийг дотоод хуримтлал, хөрөнгө оруулалтын өндөр түвшинтэй холбон тайлбарлах хандлага түгээмэл бөгөөд энэ нь ч цөөнгүй эмпирик судалгааны үр дүнгээс харагддаг<sup>20</sup>. Ингээд эдийн засгийн өсөлтийн энгийн загваруудад хуримтлал ба өсөлтийн харилцан хамаарлыг хэрхэн тодорхойлдгийг авч үзье.

**Солоугийн загвар:** Шинэ сонгодог өсөлтийн загвар болох Солоугийн загварын тавил нь дараах байдалтай байна:

- Үйлдвэрлэлийн функц нь капитал, хөдөлмөр ба технологийн түвшнээс хамаарна.

$$Y = K^\alpha (AL)^{1-\alpha} \Rightarrow \frac{Y}{AL} = \left( \frac{K}{AL} \right)^\alpha \Rightarrow \tilde{y} = \tilde{k}^\alpha$$

- $\frac{\dot{A}}{A} = g \Leftrightarrow A = A_0 e^{gt}$ ,  $\frac{\dot{L}}{L} = n \Leftrightarrow L = L_0 e^{nt}$  буюу хөдөлмөр ба технологи тогтмол хурдаар өсдөг.
- Үйлдвэрлэлийн тогтмол  $s$  хувийг хадгалах бөгөөд бүх хуримтлал хөрөнгө оруулалтад зарцуулагдаж капиталыг нэмэгдүүлнэ.

$$\dot{K} = sY - \delta K \Rightarrow \frac{\dot{K}}{K} = s \frac{Y}{K} - \delta$$

- Нэгж бүтээмжит хөдөлмөрт ногдох капиталын өөрчлөлт нь

$$\frac{\dot{\tilde{k}}}{\tilde{k}} = s \frac{Y}{K} - \delta - g - n \Rightarrow \frac{\dot{\tilde{k}}}{\tilde{k}} = s \frac{\tilde{y}}{\tilde{k}} - (n + g + \delta) \Rightarrow \dot{\tilde{k}} = s\tilde{y} - (n + g + \delta)\tilde{k}$$

- Дээрх тэгшитгэлээс тогтвортой төлөвийн нэгж бүтээмжит хөдөлмөрт ногдох капитал ба

$$\text{үйлдвэрлэлийн хэмжээг тооцоход харгалзан } \tilde{k}^* = \left( \frac{s}{n + g + \delta} \right)^{\frac{1}{1-\alpha}}, \quad \tilde{y}^* = \left( \frac{s}{n + g + \delta} \right)^{\frac{\alpha}{1-\alpha}} \text{ гарах}$$

бөгөөд  $s \uparrow \rightarrow \tilde{k}^* \uparrow$ ,  $\tilde{y}^* \uparrow$  болох нь илэрхий байна.

**АК загвар:** Эндоген өсөлтийн загварын хамгийн энгийн хувилбар болох АК загварын тавил дараах байдалтай байна.

- Үйлдвэрлэлийн функц нь  $Y = AK$  хэлбэртэй буюу Кобб-Дугласын үйлдвэрлэлийн функцын  $\alpha = 1$  байх тухайн тохиолдол байна.
- Капиталын хэмжээ нь хөрөнгө оруулалтын түвшнээр өсч, элэгдлээс шалтгаалан буурна.

<sup>19</sup> Дотоод хуримтлалын түвшин 1960-2000 хугацаанд Зүүн Азийн орнуудад дунджаар 25 хувь, Латин Америкийн орнуудад 14 хувь тус тус байв.

<sup>20</sup> Тухайлбал Kim-Jong, Lawrence J.Lau (1994) нарын "The Sources of Economic Growth of the East Asian Newly Industrialized Countries" сэдэвт судалгааны ажил.

$$\Delta K = sY - \delta K \Rightarrow \frac{\Delta K}{K} = \frac{sY}{K} - \delta$$

- Үйлдвэрлэлийн өсөлтийг тооцоход  $g_Y = \frac{\Delta Y}{Y} = sA - \delta$  гарна. Иймд  $s \uparrow \rightarrow g_Y \uparrow$  байна.

Дээрх загваруудад хуримтлал нь эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөөтэй гарсан боловч энэ нь хаалттай эдийн засагтай буюу бүх хадгаламж хөрөнгө оруулалтад зарцуулагдаж капиталыг нэмэгдүүлдэг гэсэн нөхцөл тавьсан үр дүнгүүд гэдгийг анхаарах хэрэгтэй юм. Харин улс хооронд капитал төгс шилждэг гэсэн нөхцөлөөр загварыг өргөтгөхөд хэрэв хуримтлалыг эдийн засагт оновчтой удирдах, тогтвортой байлгах таатай, эерэг нөхцөл үгүй бол дотоод хуримтлалын эдийн засгийн өсөлт дэх нөлөөлөл сулардаг. Учир нь капиталын төгс шилжилттэй үед дотоод хуримтлал хөрөнгө оруулалтын илүү өндөр өгөөжтэй өөр бусад орон руу дайжих, эсрэгээрээ дотоодод хөрөнгө оруулалтын өгөөж өндөр бол гадны хуримтлалыг ашиглан капиталыг нэмэгдүүлэх боломжтой байдаг. Гэвч бодит амьдрал дээр капитал төгс шилждэг эсэх нь эргэлзээтэй бөгөөд цөөнгүй судалгаагаар улс хооронд капитал төгс шилждэггүй болохыг нотолсон байдаг. Бодит байдалд капиталын шилжилт нь төгс шилждэг болон огт шилждэггүй гэсэн 2 туйлын дунд байдаг нь тодорхой юм. Тухайлбал Feldstein, Horioka (1980) нар хэрэв капитал төгс шилждэг бол дотоод хуримтлал болон хөрөнгө оруулалтын хооронд сул хамаарал ажиглагдах ёстой гэж үзээд ЭЗХАХБ-ын гишүүн 16 орны 1960-1974 оны хоорондох 15 жилийн тоон мэдээлэл ашиглан  $\left(\frac{I}{Y}\right)_i = \alpha + \beta \left(\frac{S}{Y}\right)_i + e_i$  тэгшитгэлийг ХБКА-аар үнэлэхэд  $\beta=0.89$  (t-stat=11.9) гарсан бөгөөд энэ нь “Feldstein-Horioka парадокс” хэмээн нэрлэгддэг<sup>21</sup>. Иймд бодит байдал дээр хуримтлалын тодорхой хэсэг дотоодын хөрөнгө оруулалтад зарцуулагдаж, капитал хуримтлалыг нэмэгдүүлснээр эдийн засгийн өсөлтөд эерэгээр нөлөөлдөг байна.


<sup>21</sup> Мөн Roger H.Gordon, A.Lans Bovenberg (1994) нар “Why is capital so immobile internationally?: Possible explanations and implications for capital income taxation” сэдэвт судалгаагаар улс хооронд капитал төгс шилждэггүй бөгөөд үүнд хөрөнгө оруулагчдын хоорондох мэдээллийн тэгш бус байдал хамгийн их нөлөөлдөг гэсэн үр дүн гаргасан байдаг.

## МӨНГӨ САНХҮҮГИЙН СЕКТОР

M2 мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлт 2014 оны 2 дугаар улирлаас эхлэн саарсаар 2015 оны 3 дугаар сард -0.5 хувьд хүрч 2009 оны 8 дугаар сараас хойш анх удаа сөрөг утгатай гарсан бол 2015 оны 7 дугаар сард -2.1 хувьд хүрэв. Үүнд бараг мөнгө өмнөх оны мөн үеэс 172.1 тэрбум төгрөгөөр буюу 2.1 хувиар, M1 мөнгө 44.2 тэрбум төгрөгөөр буюу 2.6 хувиар тус тус буурсан нь нөлөөлжээ.

## Дүрслэл 1.34

## M2 мөнгөний бүтэц (жилийн өсөлтийн хувь)



Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2015 оны 7 дугаар сарын статистик болно.


2015 оны 7 дугаар сард банкнаас гадуурх мөнгө өмнөх оны мөн үеэс 1.4 тэрбум төгрөгөөр, төгрөгийн харилцах 42.8 тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь M1 мөнгөний жилийн бууралтын харгалзан -0.1 ба -2.5 нэгж хувийг тайлбарлаж байна. Харин бараг мөнгөний жилийн өөрчлөлтийн -4.8 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, 5.7 нэгж хувийг валютын хадгаламж, -3.0 нэгж хувийг валютын харилцах тус тус бүрдүүлэв.

Мөнгөний үзүүлэлтүүдийн өсөлт 2009 оны эцсээс тасралтгүй өссөөр 2011 оны 2 дугаар улиралд оргилдоо хүрсэн бөгөөд түүнээс хойш төлбөрийн тэнцлийн хүндрэлээс үүдсэн гадаад активын бууралтаас шалтгаалан саарч

эхэлсэн. Монголбанкнаас 2012 оны 4 дүгээр улирлаас эхлэн хэрэгжүүлсэн эдийн засгийг тогтворжуулах, зөөлөн газардуулах арга хэмжээний нөлөөгөөр мөнгөний үзүүлэлтүүдийн өсөлт тогтворжиж, улмаар сэргэж байсан хэдий ч, гадаад цэвэр активын бууралтаас шалтгаалан мөнгөний үзүүлэлтүүд 2014 оны 4 дүгээр сараас эхлэн буурч, энэ хандлага үргэлжилсээр байна.

## Дүрслэл 1.35

## M2 мөнгөний жилийн өсөлтийн задаргаа



Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2015 оны 2 дугаар улирлын статистик болно.


M2 мөнгийг байршуулалт талаас нь харвал дотоод цэвэр актив өсөлттэй хэвээр байна. Тухайлбал, 2015 оны 7 дугаар сард дотоод цэвэр зээл жилийн 13.2 хувиар өслөө. Үүний 6.6 нэгж хувийг Засгийн газрын зээл, 5.7 нэгж хувийг бусад санхүүгийн байгууллагуудын зээл, 0.8 нэгж хувийг хувийн байгууллагуудын зээлийн өсөлт тус тус бүрдүүлж байна.

Төлбөрийн тэнцлийн хүндрэлээс шалтгаалан Монгол улсын гадаад цэвэр актив (ГЦА) 2013 оноос хойш буурсаар 2015 оны 7 дугаар сард -3245.0 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 207.4 хувиар буурав.



**Дүрслэл 1.36**

**Мөнгөний үзүүлэлтүүдийн ерөнхий бүтэц ба хандлага (тэрбум төгрөг)**




Эх сурвалж: Монголбанк.

Энэ нь M2 мөнгөний -32.9 хувьтай тэнцэж байна. Харин гадаад валютын харилцах, хадгаламжийн M2 мөнгөнд эзлэх хувь харьцангуй тогтвортой байгаа бөгөөд 2015 оны 7 дугаар сарын байдлаар 31.0 хувьтай байв.

**Дүрслэл 1.37**

**Мөнгөний нийлүүлэлт ба мөнгөний үржүүлэгч**



Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2015 оны 7 дугаар сарын статистик болно.


Мөнгөний үржүүлэгч<sup>22</sup> 2011 оны 2 дугаар сард 5.7 нэгж болж 2000 оноос хойшхи хамгийн өндөр түвшиндээ хүрч байсан бол 2015 оны 7 дугаар сарын байдлаар 3.3 нэгж байна.

<sup>22</sup> Нөөц мөнгөний нэгж өсөлт нь хэдий хэмжээний нийт мөнгө (M2)-ний өсөлт бий болгосныг харуулах бөгөөд M2 мөнгө ба нөөц мөнгөний харьцаагаар тодорхойлогдоно.

Эдийн засагт орж ирэх гадаад валютын урсгал сэргээгүй, гадаадын шууд хөрөнгө оруулалт 3 дахь жилдээ дараалан буурч бараг ГШХО-гүй байгаа нөхцөлд нийт эрэлт, урсгал тэнцлийн алдагдлыг бууруулах, инфляцийг нам, тогтвортой түвшинд байлгах, санхүүгийн болон макро эдийн засгийн тогтвортой байдлыг дэмжих зорилгоор Монголбанкны мөнгөний бодлогын зөвлөл 2015 оны 1 дүгээр сарын хуралдаанаараа мөнгөний бодлогын хүүг 1.0 нэгж хувиар нэмэгдүүлэн, 13.0 хувь болгох, 2015 оны 4, 7-р сард энэ түвшинд хэвээр хадгалах шийдвэр тус тус гаргасан.

**Дүрслэл 1.38**

**Банкуудын хадгаламж болон зээлийн хүү**



Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: \*Ипотекийн зээлийн хүүг оруулж тооцсон. Хамгийн сүүлийн утга нь 2015 оны 7 дугаар сарын статистик болно.


Санхүүжилтийн нөхцөл чангарсантай холбоотойгоор банкуудын төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү<sup>23</sup> 2015 оны 7 дугаар сарын байдлаар өнгөрсөн оны мөн үеэс 0.9 нэгж хувиар өсч жилийн 18.4 хувьд хүрэв. Хадгаламжийн жинлэсэн дундаж хүү 2015 оны 7 дугаар сард өмнөх оны мөн үеэс 0.7

<sup>23</sup> Банкуудын зээлийн жигнэсэн дундаж хүү нь Монголбанкны хөтөлбөрийн (ҮТХ) зээлийг оруулан тооцсон хүү болно. Харин хөтөлбөрийн зээлийг хасч тооцвол төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү тайлант сард 19.4 хувь байна.

нэгж хувиар өсч жилийн 12.9 хувьд хүрснээр хүүний зөрүү 5.5 хувь байна.

### Дүрслэл 1.39

#### Банк хоорондын захын хүү




Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2015 оны 7 дугаар сарын статистик болно.

“Хүүний коридор” нэвтрүүлснээс хойш буюу 2013 оны 2 сараас хойшхи хугацаанд богино хугацаат хэлцлийн хүүнүүд бодлогын хүүнээс +/-2 хувийн дотор хэлбэлзэж байна.

### Дүрслэл 1.40

#### Банк хоорондын захын хүүний хэлбэлзэх интервал\*\*



Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: \*Эхний 7 сарын байдлаар.

\*\*Банк хоорондын захын хүүнүүдийн жил бүр хэлбэлзэх интервалыг тухайн жилийн хамгийн их утгаас хамгийн бага утгыг хасч тооцов.

Тухайлбал, 2015 оны 7 дугаар сарын эцэст Монголбанкны бодлогын хүү 13 хувь байхад овернайт хүү 13.4 хувь, репо хүү 13.2 хувь болсон байна.


УЛСЫН ТӨСӨВ

Нэгдсэн төсвийн орлогын урьдчилсан гүйцэтгэл

Монгол Улсын эдийн засагт нөлөөлөх гадаад болон дотоод хүчин зүйлсийн сөрөг нөлөөллөөс үүдэн 2014 онд Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлогын бүрдүүлэлт 6145.1 тэрбум төгрөг буюу 86.4 хувийн, нийт зарлага 7031.4 тэрбум төгрөг буюу 92.4 хувийн гүйцэтгэлтэй, төсвийн нийт тэнцэл 808.0 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 3.7 хувьтай тэнцэх хэмжээний алдагдалтай гарав. Нийт орлогын 88.4 хувийг бүрдүүлэхээр төлөвлөгдсөн татварын орлого 82.8 хувийн, 11.1 хувийг бүрдүүлэхээр төлөвлөгдсөн татварын бус орлого 113.2 хувийн гүйцэтгэлтэй байлаа.

Дүрслэл 1.41

Төсвийн тогтворжуулалтын сангийн үлдэгдэл (тэрбум төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам.


2014 оны төсвийн жилд төсвийн тооцоололд ашигласан тэнцвэржүүлсэн нүүрсний үнэ бодит үнээс өндөр<sup>24</sup> байснаас шалтгаалан “Засгийн газрын тусгай сангийн тухай”

<sup>24</sup> Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуулийн төслийн танилцуулгад дурдснаар нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг чанараас нь хамааруулсан тонн тутамд 81.6 ам.доллар байхаар тусгасан бол 1 тонн нүүрсний /Австрали/ дэлхийн зах зээл дээрх үнэ 2014 онд дунджаар 75.1 (WEO) ам.доллар байв.

хуулийн 9.3.3<sup>1</sup>-т заасны дагуу нүүрснээс төсвийн тогтворжуулалтын санд өмнө хуримтлагдсан хөрөнгөөс зөвхөн тэнцвэржүүлсэн үнэ болон зах зээлийн үнийн зөрүүгээс үүссэн төсвийн орлогын тасалдлыг нөхөхөд зориулж 118.2 тэрбум төгрөгийг улсын төсөвт шилжүүлсэн байна.

Дүрслэл 1.42

Нэгдсэн төсвийн орлого ба тусламжийн дүн (бүтцээр)




Эх сурвалж: Сангийн яам.

Тэмдэглэл: Төл-төлөвлөгөө, тод-тодотгол, гүйц-гүйцэтгэл.

2015 онд эдийн засгийн байдал өмнөх оноос сайжрах төлөв байдал ажиглагдахгүй, дэлхийн зах зээл дээрх эрдэс бүтээгдэхүүний үнэ болон экспортын биет хэмжээ буурах төлөвтэй байгаагаас шалтгаалан 2015 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр УИХ-аас 2015 оны батлагдсан төсвийн орлогыг бодитойгоор дахин төлөвлөх, урсгал болон хөрөнгийн зардлыг орлоготой уялдуулан дахин тооцох, Засгийн газрын бүтцэд гарсан өөрчлөлтийг төсөвт тусгах зорилгоор төсөвт тодотгол хийсэн. Уг тодотголоор нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөө 6662.5 тэрбум төгрөг болж өмнөх оны гүйцэтгэлээс 8.4 хувиар өссөн дүнтэй батлагдсан.

### Дүрслэл 1.43

Уул уурхайн салбарт тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдээс төсөвт төвлөрүүлсэн орлого ба төсвийн бусад орлого



Эх сурвалж: Татварын ерөнхий газар, Сангийн яам.  
Тэмдэглэл:

2015 оны эхний 7 сарын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 85.4 хувийн гүйцэтгэлтэй буюу 3142.9 тэрбум төгрөг, зарлага 75.2 хувийн гүйцэтгэлтэй буюу 3780.7 тэрбум төгрөг, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 637.8 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

### Хүснэгт 1.7

Нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөө ба гүйцэтгэл (тэрбум төгрөг)

Нэгдсэн төсвийн орлого	Жилийн төлөвлөгөө	2015 оны эхний 7 сар		
		*	**	***
Нийт орлого ба тусламжийн дүн	6 663	3 693	3 145	85%
Тогтворжуулалтын сан	30	14	2	17%
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	6 633	3 679	3 143	85%
<b>A. Урсгал орлого</b>	<b>6 633</b>	<b>3 679</b>	<b>3 143</b>	<b>85%</b>
<i>I. Татварын орлого</i>	5 400	2 985	2 747	92%
1. Орлогын албан татвар	1 151	639	575	90%
1.1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	652	364	320	88%
1.2. Хүн амын орлогын албан татвар	541	306	288	94%
2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	1 236	575	598	104%
3. Өмчийн татвар	83	57	54	95%
4. Нэмэгдсэн өртгийн албан татвар	1 254	711	594	84%
5. Онцгой албан татвар	621	359	324	90%
6. Гадаад үйл ажиллагааны орлого	377	223	179	80%
7. Бусад татвар	667	414	416	100%
<i>II. Татварын бус орлого</i>	1 233	693	396	57%
<b>B. Хөрөнгийн орлого</b>	<b>183</b>	<b>149</b>	<b>9</b>	<b>6%</b>
<b>B. Тусламжийн орлого</b>	<b>63</b>	<b>37</b>	<b>11</b>	<b>30%</b>

Эх сурвалж: Сангийн яам.

Тэмдэглэл: \*Төлөвлөгөө,  
\*\*Урьдчилсан гүйцэтгэл.

Нэгдсэн төсвийн орлогын тасралтад татварын орлогын бүрэлдэхүүнд багтах ААН-ийн орлогын албан татвар 44.4 тэрбум төгрөг,

импортын барааны НӨАТ 211.8 тэрбум төгрөг, импортын гаалийн албан татвар 43.6 тэрбум төгрөг, татварын бус орлогын бүрэлдэхүүнд багтах газрын тосны орлого 55.5 тэрбум төгрөг, хүүгийн орлого 56.8 тэрбум төгрөг, өмч хувьчлалын орлого 140.2 тэрбум төгрөгөөр тус тус тасарсан нь голлон тайлбарлаж байна.

### Хүснэгт 1.8

2015 оны эхний 7 сарын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл, үндсэн бүрэлдэхүүнээр (тэрбум төгрөг)

Төсвийн орлого	УТ*	ОНТ*	ХХС*	НДС*
Нийт орлого ба тусламжийн дүн	1 987	1 176	192	775
Тогтворжуулалтын сан	2	0	0	0
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	1 985	1 176	192	775
<i>I. Татварын орлого</i>	1 559	398	192	696
1. Орлогын албан татвар	320	256	0	0
1.1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	320	0	0	0
1.2. Хүн амын орлогын албан татвар	0	288	0	0
1.3. Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн татвар	0	0	0	0
2. Нийгмийн даатгалын шимтгэл хураамж	0	0	0	696
3. Өмчийн татвар	0	54	0	0
4. Нэмэгдсэн өртгийн албан татвар	594	0	0	0
5. Онцгой албан татвар	324	0	0	0
5. Гадаад худалдааны орлого	179	0	0	0
6. Бусад татвар	136	87	192	0
<i>II. Татварын бус орлого</i>	425	778	0	79

Эх сурвалж: Сангийн яам.

Тэмдэглэл: \*УТ- Улсын төсөв, ОНТ- Орон нутгийн төсөв, ХХС- Хүний хөгжил сан, НДС- Нийгмийн даатгалын сан.

### Хүний хөгжил сангийн орлого

Хүний хөгжил сан нь 2009 онд байгуулагдсан бөгөөд тус санд 2010-2014 хугацаанд нийт дүнгээр 1733.8 тэрбум төгрөг төвлөрүүлжээ. 2015 оны эхний 7 сарын байдлаар 192.4 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн нь төлөвлөгөөнөөс 8.7 хувиар буюу 15.3 тэрбум төгрөгөөр илүү төвлөрсөн байна. Энэ нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлого давж биелсэнтэй холбоотой юм.

### Нийгмийн даатгалын сангийн орлого


Нийгмийн даатгалын санд 774.7 тэрбум төгрөг төвлөрсөн нь төлөвлөгөөнөөс 6.5 хувиар буюу 53.5 тэрбум төгрөгөөр дутуу биелэлттэй байна. Тус санд 2015 оны эхний 7 сард улсын төсвөөс 78.6 тэрбум төгрөгийн татаас олгоод байна.

**Төсвийн зарлагын гүйцэтгэл**

Сүүлийн 2 жилийн хугацаанд төсвийн гадуур хэрэгжиж байсан төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр Хөгжлийн банк болон бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх төслийг 2015 оны төсвийн тодотголоор нэгдсэн төсөвт тусгасан нь төсвийн нэгдсэн байдал хангагдах чухал алхам болов. Уг төсвийн тодотголоор Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага ба зээлийн дүн өмнөх оны гүйцэтгэлээс 4.7 хувиар өссөн дүнтэй батлагдсан хэдий ч, 2014 онд Хөгжлийн банкны төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр олгосон санхүүжилтийг нэмж тооцсон төсвийн зарлагаас -7.3 хувиар буурсан байна.

**Дүрслэл 1.44**

**Нэгдсэн төсвийн зарлага ба Хөгжлийн банкны төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон зээл**



Эх сурвалж: Сангийн яам.  
Тэмдэглэл: \*Хөгжлийн банкны улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон/олгох зээл, \*\*Хөгжлийн банкнаас бусад эх үүсвэрээс улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй хийх хөрөнгө оруулалт.

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага 2015 оны эхний 7 сарын байдлаар 5028.9 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 3780.7 тэрбум төгрөг буюу 75.2 хувийн гүйцэтгэлтэй гарлаа.

Үүнээс урсгал зардал 387.5 тэрбум төгрөг, хөрөнгийн зардал 865.0 тэрбум төгрөгөөр тус тус дутуу гүйцэтгэлтэй гарчээ. Урсгал

зардлын бүрэлдэхүүнд багтах цалин хөлс 33.1 тэрбум төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 121.0 тэрбум төгрөг, бараа, үйлчилгээний бусад зардал 44.3 тэрбум төгрөг, дотоод зээлийн үйлчилгээний төлбөр 91.7 тэрбум төгрөг, хөрөнгийн зардлын бүрэлдэхүүнд багтах дотоод эх үүсвэрээрх хөрөнгө оруулалт 790.7 тэрбум төгрөгөөр тус тус дутуу биелэлттэй байлаа.

**Хүснэгт 1.9**

**Нэгдсэн төсвийн зарлагын төлөвлөгөө ба гүйцэтгэл (тэрбум төгрөг)**

Нэгдсэн төсвийн зарлага	Жилийн төлөвлөгөө	2015 оны эхний 7 сар		
		*	**	***
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	7 838	5 029	3 781	75%
Урсгал зардал	5 823	3 563	3 176	89%
1. Бараа, үйлчилгээний зардал	2 900	1 824	1 560	86%
1.1. Цалин хөлс	1 805	1 031	998	97%
1.2. Нийгмийн даатгал	170	97	91	95%
1.3. Бараа, үйлчилгээний бусад зардал	925	697	471	68%
2. Зээлийн үйлчилгээний төлбөр	697	382	285	75%
3. Татаас ба шилжүүлэг	2 228	1 357	1 331	98%
Хөрөнгийн зардал	2 015	1 447	581	40%
1. Дотоод эх үүсвэрээр:	1 786	1 313	522	40%
Эргэж төлөгдөх цэвэр зээл	0	20	24	122%
Тэнцвэржүүлэн нийт тэнцэл	-1 205	-1 351	-638	47%

Эх сурвалж: Сангийн яам.  
Тэмдэглэл: \*Төлөвлөгөө, \*\*Урьдчилсан гүйцэтгэл.

**Хүний хөгжил сангийн зарлага**

Хүний хөгжил сангийн тухай хуулийн 1 дүгээр зүйлд зааснаар тус санг “... ашигт малтмал, уул уурхайн салбарын орлогоос хуримтлал үүсгэж, тогтвортой өсөн нэмэгдэх байнгын нөөц бүрдүүлэн иргэддээ тэгш хүртээх зорилгоор...” байгуулсан боловч өнгөрсөн хугацаанд тус сангийн орлогыг хуримтлуулахгүй бүхэлд нь иргэдэд хишиг, хувь хэлбэрээр зохисгүй тарааж ирсэн. Хүний хөгжил сангаас 2010-2014 хугацаанд иргэдэд бэлэн мөнгө, ЭМД-ын шимтгэл, оюутны сургалтын төлбөр зэрэг хэлбэрүүдээр 2542.4 тэрбум төгрөг зарцуулсан бөгөөд зарлагын дийлэнх хэсгийг стратегийн орд ашиглахтай холбоотой Оюутолгой ХХК, Эрдэнэс МГЛ ХХК-иас авсан урьдчилгаа төлбөр, Засгийн газрын


бондоор санхүүжүүлсэн байна. 2015 оны эхний 7 сарын байдлаар Хүний хөгжил сангийн зарлага 166.2 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгдсөн нийт зардал 90.8 хувийн гүйцэтгэлтэй байна. Тус сангаас хүүхдэд олгож байгаа бэлэн мөнгөний санхүүжилтээр 142.8 тэрбум төгрөгийг олгожээ.

### Төсвийн тэнцэл

2015 оны эхний 7 сард Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 637.8 тэрбум, улсын төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 623.6 тэрбум төгрөгийн тус тус алдагдалтай гарлаа.

#### Дүрслэл 1.45

Нэгдсэн төсвийн тэнцлийн гүйцэтгэл (жил бүрийн эхний 7 сарын байдлаар, тэрбум төгрөг)



Эх сурвалж: Сангийн яам, Үндэсний статистикийн хороо.  
Тэмдэглэл: \*Жил бүрийн эхний 7 сарын орлого, зарлагын гүйцэтгэлийн нийт жилийн гүйцэтгэлд эзлэх хувийг тооцов. 2011 оноос хойш нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг ашигласан болно. 2015 оны хувьд орлого, зарлагын жилийн төлөвлөгөөг ашиглав.

Төлөвлөгөө ёсоор 2015 оны эхний 7 сард нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1350.5 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч үүний дийлэнх хэсгийг буюу 658.0 тэрбум төгрөгийг Засгийн газрын харилцах, хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлтөөр, 667.1 тэрбум төгрөгийг засгийн газрын зээлийн эх үүсвэрээр тус тус санхүүжүүлэхээр төлөвлөсөн боловч эдгээр алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэрүүдийн

### Нийгмийн даатгалын сангийн зарлага

Нийгмийн даатгалын сангийн төлөвлөгдсөн зардал 104.2 хувийн буюу 895.7 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Тус сангаас улсын эмнэлгүүдэд 78.3 тэрбум төгрөгийн татаас олгов.

бодит гүйцэтгэл тайлант хугацаанд харгалзан 52.5 тэрбум төгрөг, 166.9 тэрбум төгрөг байв. Эдгээр алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэрүүдийн гүйцэтгэл хангалтгүй байсан нь 2015 оны эхний 7 сард нэгдсэн төсвийн нийт зарлага төлөвлөсөн хэмжээнээс дутуу биелэлттэй гарахад нөлөөлж байна. Хэрэв нэгдсэн төсвийн нийт зарлагын дутуу гүйцэтгэл нь орлогын тасралт болон алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг хангалтгүй гүйцэтгэлээс бүрэн шалтгаалсан гэж үзвэл зарлагын дутуу гүйцэтгэлийн 43.8 хувь нь нэгдсэн төсвийн орлогын тасралтаас, 48.6 хувь нь Засгийн газрын харилцах, хадгаламжийн дансны өөрчлөлтөөс, 40.1 хувь нь засгийн газрын зээлийн санхүүжилтийн дутуу гүйцэтгэлээс, үлдсэн -32.5 хувь нь засгийн газрын бонд ба урьдчилгаа төлбөрийн гүйцэтгэлээс тус тус шалтгаалсан байна.

### Хүснэгт 1.10

Нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн төлөвлөгөө, гүйцэтгэл (тэрбум төгрөг)

Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр	Жилийн төлөвлөгөө	2015 оны эхний 7 сар		
		*	**	**/*
<b>A. Харилцах, хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт</b>	<b>132</b>	<b>658</b>	<b>52</b>	<b>8%</b>
<b>B. Засгийн газрын бонд</b>	<b>299</b>	<b>70</b>	<b>442</b>	<b>632%</b>
<i>1. Урт хугацаат</i>	<i>299</i>	<i>-207</i>	<i>189</i>	<i>-91%</i>
1.1. Дотоод	299	-207	-126	61%
1.1.1 Шинээр гаргах	1796	606	265	44%
1.1.1 Үндсэн төлбөр	-1497	-813	-391	48%
1.2. Гадаад	0	0	314	-
1.2.1 Шинээр гаргах	0	0	314	-
<i>2. Богино хугацаат</i>	<i>0</i>	<i>277</i>	<i>253</i>	<i>91%</i>
2.1. Дотоод	0	277	253	91%
2.1.1 Шинээр гаргах	635	575	995	173%
2.1.1 Үндсэн төлбөр	-635	-298	-741	
<b>C. Засгийн газрын зээл</b>	<b>852</b>	<b>667</b>	<b>167</b>	<b>25%</b>
<i>3. Дотоод</i>	<i>700</i>	<i>555</i>	<i>155</i>	<i>28%</i>
<i>4. Гадаад</i>	<i>152</i>	<i>112</i>	<i>12</i>	<i>11%</i>

Эх сурвалж: Сангийн яам.  
Тэмдэглэл: \*Төлөвлөгөө, \*\*Урьдчилсан гүйцэтгэл.

2015 оны 7 дугаар сарын эцсийн байдлаар Монголбанкн дахь төрийн сангийн нэгдсэн дансанд<sup>25</sup> 434.1 тэрбум төгрөг, арилжааны банкуудад хугацаатай болон хугацаагүй хадгаламж хэлбэрээр 19.4 тэрбум төгрөг, НДС-гийн чөлөөт үлдэгдэл 647.0 тэрбум төгрөг байршиж байна. Хэдийгээр Засгийн газрын нийт харилцах, хадгаламжийн дансны болон НДС-гийн чөлөөт үлдэгдлийн нийлбэр нь төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор тайлант хугацаанд гаргахаар төлөвлөсөн мөнгөн дүнгээс илүү байгаа боловч НДС-гийн хөрөнгийг сан хооронд шилжүүлэн зарцуулах, байршуулахыг хуулиар хориглосон байдаг.

**Хүснэгт 1.11**

**Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн гүйцэтгэл(тэрбум төгрөг)**

Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр	УТ		ОНТ		НДС		ХХС	
	*	**	*	**	*	**	*	**
<b>A. Харилцах, хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт</b>	355	-11	245	-81	32	121	25	23
<b>B. Засгийн газрын бонд</b>	45	467	0	0	0	0	25	-26
1. Урт хугацаат	-232	214	0	0	0	0	25	-26
1.1. Дотоод	-232	-100	0	0	0	0	25	-26
1.1.1 Шинээр гаргах	525	235	0	0	0	0	81	30
1.1.1 Үндсэн төлбөр	-757	-336	0	0	0	0	-56	-56
2. Богино хугацаат	277	253	0	0	0	0	0	0
2.1. Дотоод	277	253	0	0	0	0	0	0
2.1.1 Шинээр гаргах	575	995	0	0	0	0	0	0
2.1.1 Үндсэн төлбөр	-298	-741	0	0	0	0	0	0
<b>C. Засгийн газрын зээл</b>	655	167	12	0	0	0	0	0
3. Дотоод	555	155	0	0	0	0	0	0
4. Гадаад	100	12	12	0	0	0	0	0


Эх сурвалж: Сангийн яам.  
Тэмдэглэл: \*Төлөвлөгөө, \*\*Урьдчилсан гүйцэтгэл.

Шинээр гаргасан Засгийн газрын бонд, зээлийн багагүй хэсгийг үндсэн төлбөрт төлж байгаа нь Засгийн газар шинэ өр үүсгэх замаар хуучин өр төлбөрөө төлж буйг харуулж байна. Тухайлбал 2015 оны тодотгогдсон төсөвт дурдснаар шинээр гаргах засгийн газрын бондын 83.3 хувийг бондын үндсэн төлбөрт, шинээр авах зээлийн 50.0 хувийг зээлийн үндсэн төлбөрт тус тус зарцуулахаар тусгагдсан.

<sup>25</sup> “Төсвийн тухай” хуулинд дурдснаар “Төрийн сангийн нэгдсэн данс гэж Засгийн газрын нэгдсэн зохицуулалт бүхий төсвийн ерөнхий данс болон Монгол Улсын нэгдсэн төсөвт хамаарах бүх төсвийн захирагчийн Монголбанкнд байрших мөнгөн хөрөнгийн харилцах дансыг” хэлнэ.

**Дүрслэл 1.46**

**Засгийн газрын бонд ба зээл (шинээр гаргах, үндсэн төлбөр)**




Эх сурвалж: Сангийн яам.  
Тэмдэглэл: \*Төлөвлөгөө

Засгийн газрын урт хугацаат бондын арилжаа 2014 оны 7 дугаар сараас хойш эрс саарч, 2015 оны эхний 7 сард 605.7 тэрбум төгрөгийн бонд шинээр гаргахаас 265.5 тэрбум төгрөгийн бонд арилжаалаад байна. Харин 2015 оны эхний 7 сард 575.0 тэрбум төгрөгийн засгийн газрын богино хугацаат үнэт цаас арилжаалахаар төлөвлөснөөс 994.7 тэрбум төгрөгийн үнэт цаас арилжаалсан нь төлөвлөсөн дүнгээс 419.7 тэрбум төгрөгөөр илүү байв.

**Дүрслэл 1.47**

**Банкуудын нэгдсэн тайлан тэнцэл дэх Засгийн газрын богино ба урт хугацаат үнэт цаасны үлдэгдэл**




Эх сурвалж: Монголбанк.  
Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2015 оны 7 дугаар сарын статистик болно.

2015 оны 7 дугаар сарын эцэст банкуудын тайлан тэнцэл дэх засгийн газрын дунд болон урт хугацаат бондын үлдэгдэл 1523.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 1.1 хувиар, богино хугацаат үнэт цаасны үлдэгдэл 729.7 тэрбум төгрөгт хүрч 6.2 хувиар, засгийн газрын үнэт цаасны нийт үлдэгдэл 2253.4 тэрбум төгрөгт хүрч 2.7 хувиар тус тус өсөөд байна. Ийнхүү төсвийн алдагдалтай уялдан ЗГҮЦ-ны үлдэгдэл өсч байгаа нь бодит секторт гарах бололцоотой зээлийн эх үүсвэрийг бууруулж, эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлж байгаа юм.

### Дүрслэл 1.48

#### Засгийн газрын богино ба урт хугацаат бондын арилжаа



Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: Улаан цэгүүдээр Засгийн газрын бондыг арилжаалахаар зарласан боловч худалдан авах санал ирээгүй өдрүүдийг тэмдэглэв.



# 2

## САНХҮҮГИЙН САЛБАР, ТҮҮНИЙ ДАРХЛАА

### 2.1 БАНКНЫ САЛБАРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ


#### БАНКНЫ САЛБАР

##### Ерөнхий төлөв байдал

Банкны салбарт 2015 оны 7 дугаар сарын байдлаар нийт 14 банк, 1475 салбар нэгжтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Нийт хадгаламж эзэмшигчдийн тоо 2.7 саяд, зээлдэгчдийн тоо 842.2 мянгад хүрлээ.

##### Дүрслэл 2.1

Банкны салбарын активын бүтэц



Эх сурвалж: Монголбанк.

Банкны салбарын нийт активын хэмжээ 2015 оны 7 дугаар сард 21.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 2.3 хувиар буюу 490.0 тэрбум төгрөгөөр өссөн бөгөөд дотоодын нийт бүтээгдэхүүний 97.7<sup>26</sup> хувьтай тэнцэж байна. Нийт активын бүтцийг авч үзвэл 55.6 хувь нь зээл, 12.2 хувь нь банкны нөөц, 10.5 хувь нь Засгийн газрын үнэт цаас, 2.1 хувь нь


<sup>26</sup> ДНБ-ий 2014 оны гүйцэтгэлийг ашиглав.

Төв банкны үнэт цаас, үлдэх 19.6 хувь нь бусад хөрөнгө байна.

Банкны салбарын нийт эх үүсвэрийн хэмжээ 2015 оны 7 дугаар сард 19.1 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 1.1 тэрбум төгрөгөөр өслөө. Нийт эх үүсвэрийн 11.6 хувийг харилцах, 37.4 хувийг хадгаламж, 19.8 хувийг гадаад пассив, 6.8 хувийг Засгийн газрын хадгаламж, үлдэх 24.5 хувийг бусад эх үүсвэр бүрдүүлж байна.

##### Дүрслэл 2.2

Банкны салбарын пассивын бүтэц



Эх сурвалж: Монголбанк.

##### Эх үүсвэр


Банкны салбарын нийт харилцах, хадгаламжийн 68.0 хувийг төгрөгийн, 32.0 хувийг валютын харилцах, хадгаламж бүрдүүлж байна. Гадаад валютын харилцах, хадгаламжийн нийт харилцах, хадгаламжид

эзлэх хувийн жин өмнөх оны эцсээс 1.7 нэгж хувиар буурсан нь иргэд, аж ахуй нэгжүүдийн гадаад валютаар харилцах хадгаламжаа байршуулах сонирхол харьцангуй буурсныг харуулж байна.

**Банкуудын эх үүсвэрийн өсөлтийн хурд буурч байна.** Монголбанкнаас мөнгөний уламжлалт бус бодлогын хүрээнд хэрэгжүүлсэн хөтөлбөрүүдийн санхүүжилт болон харилцах хадгаламжийн тогтвортой өсөлттэй холбоотойгоор эх үүсвэрийн хэмжээ 2013 онд өсч байсан хэдий ч 2014 оноос хойш өсөлтийн хурд эргэн буурч байна.

**Дүрслэл 2.3**

**Банкны салбарын эх үүсвэрийн жилийн өсөлт**



Эх сурвалж: Монголбанк.


2015 оны 7 дугаар сарын байдлаар нийт пассивын жилийн өсөлт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 26.9 нэгж хувиар буурсан бол нийт харилцах, хадгаламжийн жилийн өсөлт -2.3 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 30.5 нэгж хувиар буурчээ. Эх үүсвэрийн өсөлт цаашид үргэлжлэн буурвал банкууд эх үүсвэрийн дутагдалд орох, зээлийн тасалдал үүсэх эрсдэл нэмэгдэхээр байна.

**Зээл**

**Зээлийн өсөлт саарлаа.** Санхүүгийн салбарын нийт зээлийн багцын<sup>27</sup> 96 хувийг бүрдүүлж буй банкны зээлийн өсөлт 2015 он гарсаар үргэлжлэн саарсаар 7 дугаар сард -2.0 хувьд хүрээд байна.

**Дүрслэл 2.4**

**Банкны салбарын актив, зээлийн жилийн өсөлт**




Эх сурвалж: Монголбанк.

2015 оны эхний хагасын байдлаар эдийн засгийн салбаруудад олгосон зээл өмнөх оны мөн үеэс буурав. Нэг талаас банкны салбарын эх үүсвэрийн өсөлт саарсан, нөгөө талаас банкууд эрсдэлээс болгоомжлон зээл олголтоо багасгасан нь нөлөөлжээ.

**Дүрслэл 2.5**

**Олгосон зээлийн жилийн өсөлт (салбараар)**




Эх сурвалж: Монголбанк.

<sup>27</sup> Арилжааны банк, ББСБ, ХЗХ-ны зээлийн өрийн үлдэгдлийн ститистикт үндэслэн тооцов.

**Зээлийн төвлөрлийн хэмжээ өндөр хэвээр байна.** 2015 оны эхний хагасын байдлаар банкны салбарын нийт зээлийн өрийн үлдэгдлийн 62 хувь уул уурхай, боловсруулах үйлдвэрлэл, барилга, үл хөдлөх хөрөнгө, худалдаа зэрэг 5 салбарт төвлөрч байна. Иймд эдгээр салбаруудад хүндрэл үүсэхэд банкны салбарын зээлийн чанарт үзүүлэх сөрөг нөлөө нь өндөр юм.

**Дүрслэл 2.6**

**Салбаруудын зээлийн төвлөрөл**



Голлох салбарууд	Зээлийн өрийн үлдэгдэл (2015Q2)	Өмнөх оны мөн үеэс гарсан өөрчлөлт
Бөөний болон жижиглэн худалдаа	14.1%	-1.8%
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	15.4%	-3.4%
Барилга	12.5%	-1.5%
Уул уурхай, олборлолт	9.1%	-2.4%
Боловсруулах үйлдвэрлэл	11.2%	2.7%
Бусад	37.7%	6.5%

Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: \*Зээлийн багцад хамгийн өндөр жин эзэлж буй 4 салбарын зээлийн нийт дүнд эзлэх хувь.


Мөн банкуудын 40 том зээл нийт зээлийн 37.9 хувийг бүрдүүлж байгаа нь банкуудын нийт зээлийн чанар том зээлүүдийн чанараас ихээхэн хамааралтай болохыг илтгэнэ. Төв банкнаас банкны нэг зээлдэгч болон түүнд холбогдох этгээдэд олгох зээл, түүнтэй адилтгах актив, банкны холбогдох этгээдэд олгох зээлийн хязгаарлалтыг тогтоосон байдаг боловч зарим банкууд энэхүү шаардлагыг ханган ажиллахгүй байгаа нь зээлийн төвлөрлийн эрсдэлийг нэмэгдүүлж байна.

**Банкны салбарын зээлийн чанар муудаж байна.** Нийт чанаргүй зээлийн хэмжээ энэ

оны 7 дугаар сарын байдлаар 822.7 тэрбум төгрөгт хүрч (нийт зээлийн 6.9 хувь), өмнөх оны мөн үеэс 224.6 тэрбум төгрөгөөр буюу 37.6 хувиар өссөн<sup>28</sup> бол хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 714.3 тэрбум төгрөгт хүрч (нийт зээлийн 6.0 хувь), 166.0 тэрбум төгрөгөөр буюу 30.3 хувиар нэмэгдлээ. Чанаргүй зээлийн өсөлт нь зээлийн эрсдэлийн сангийн зардлыг өсгөснөөр банкны салбарын өөрийн хөрөнгийн болон ашигт ажиллагааны үзүүлэлтүүдэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.

**Дүрслэл 2.7**

**Зээлийн чанарын үзүүлэлт, салбараар**



Эх сурвалж: Монголбанк.

Уул уурхай болон худалдааны салбарын чанаргүй зээлийн хувь бусад салбаруудтай харьцуулахад өндөр буюу харгалзан 24.2, 10.3 хувьтай байна. Үл хөдлөх хөрөнгийн салбарын чанаргүй зээлийн харьцаа харьцангуй бага байна.


Банкны салбарын хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн 75 хувь нь уул уурхай, бөөний болон жижиглэн худалдаа, боловсруулах үйлдвэрлэл, барилгын салбаруудад төвлөрсөн бөгөөд нийт зээлийн

<sup>28</sup> Татан буугдсан Анод, Зоос, Хадгаламж банкуудыг хасч тооцвол чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 63.3 хувиар өсч 584.3 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт зээлийн 5.0 хувьтай тэнцэж байна.

өрийн үлдэгдлийн 47 хувийг дээрх 4 салбарт олгосон зээл бүрдүүлж байна.

**Дүрслэл 2.8**

**Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн өсөлт**




Голлох салбарууд	Нийт дүнд эзлэх хувь
Уул уурхай, олборлолт	32.4%
Бөөний болон жижиглэн худалдаа	16.4%
Боловсруулах үйлдвэрлэл	13.9%
Барилга	12.4%
Бусад	24.9%

Эх сурвалж: Монголбанк.

Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн өсөлт нь эдгээр салбаруудын эдийн засгийн идэвхжил суларч байгаатай холбоотой.

**Дүрслэл 2.9**

**Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээл (валютын төрлөөр)**



Эх сурвалж: Монголбанк.

Зээлийн чанарын үзүүлэлтүүд ийнхүү муудахад эдийн засгийн таагүй нөхцөл


байдал болон гадаад валютаар олгосон зээлийн чанар муудсан нь голлон нөлөөлжээ.

2015 оны 7 дугаар сарын байдлаар төгрөгийн чанаргүй зээлийн нийт төгрөгийн зээлд эзлэх хувь 5.5 хувь байхад валютын чанаргүй зээлийн нийт валютын зээлд эзлэх хувь 11.2 хувь байна.

**Өрхийн бодит орлого сүүлийн 6 улирал дараалан буурав.** Улсын хэмжээнд өрхийн сарын дундаж нэрлэсэн орлого 2015 оны 2 дугаар улиралд 5.3 хувиар өссөн нь мөн үеийн инфляцийн түвшин 7.3-аас бага байсан бөгөөд улмаар өрхийн бодит орлого 2.0 хувиар буурлаа.

**Дүрслэл 2.10**

**Өрхийн бодит орлогын өсөлт**




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк.

Бодит орлого буурах нь өрхийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэглээг багасган, амжиргааны түвшинг бууруулах, улмаар зээлийн эргэн төлөлтийн чадавхийг сулруулах нөлөөтэй. 2015 оны 2 дугаар улиралд өрхийн орлого, зарлага өмнөх оны мөн үеэс харгалзан 5.3, 6.1 хувиар өсчээ.

**Дүрслэл 2.11**

**Өрхийн орлого, зарлагын харьцаа**




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо.

**Зээлийн өсөлт саарч байгаатай холбоотойгоор хувийн салбарын болон өрхийн дотоод өрийн дарамт харьцангуй тогтвортой байгаа бол гадаад өрийн дарамт өссөн хэвээр байна.** Нэг өрхөд ногдох иргэдийн зээл 2015 оны 2 дугаар улиралд 6.4 саяд хүрч, сүүлийн 3 улирал дараалан буурав.

**Дүрслэл 2.12**

**Өрхийн өрийн дарамт**



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк.

Тэмдэглэл: \*Нэг өрхөд ногдох иргэдийн зээлийн өрийн үлдэгдэл;

\*\*2009 оноос хойшхи өгөгдөл ашиглав.

\*\*\*Нэг өрхөд ногдох иргэдийн зээлийн өрийн үлдэгдэлийг улсын дундаж өрхийн жилийн орлогод харьцуулж тооцов;

\*\*\*\*Иргэдийн зээлийн өрийн үлдэгдэл ба нэрлэсэн ДНБ-ий харьцаа (жилийн ДНБ). Хамгийн сүүлийн утга нь 2015 оны II улирлын статистик болно.


Нэг өрхөд ногдох иргэдийн зээл ба өрхийн жилийн дундаж орлогын харьцаагаар өрхийн

өрийн дарамтыг төлөөлүүлэн хэмжихэд тайлант улиралд өрхийн өрийн дарамт 50 хувьд хүрч буураад байна. Өрхийн өр төлбөрийг бүтцээр нь авч үзвэл ипотекийн зээлийн өрийн дарамтад эзлэх хувь 31 хувьд хүрсэн байна. Ипотекийн зээл нь өрхийн хуримтлалыг нэмэгдүүлж, хэрэглээг хумьдаг учраас энэ төрлийн өрийн дарамт нь урт хугацаанд макро эдийн засгийн тогтвортой байдалд эерэг нөлөөтэй юм.

Нэгж орлогод ногдох орон сууцны ипотекийн зээлийн төлбөрийн хувь хэмжээ буюу өр/орлогын харьцаа 2013 оны 3 дугаар улирал хүртэл буурсаар 38 хувьд хүрч байсан бол 2015 оны 2 дугаар улиралд 42 хувь болж сүүлийн 3 улиралд харьцангуй тогтвортой байна. Энэхүү харьцаа нь дундаж өрх орлогоороо орон сууцны ипотекийн зээл авсан бол өр, төлбөрийн хувьд ямар дарамттай байхыг илтгэнэ.

**Дүрслэл 2.13**

**Өрхийн өр, орлогын харьцаа\***



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк.


Тэмдэглэл: \*Өрхийн дундаж орлогод эзлэх хувь бөгөөд энэхүү харьцааг тооцохдоо өрхийн орлогыг ҮСХ-ноос тооцон гаргадаг улсын өрхийн дундаж сарын орлогыг авч ашигласан болно. Харин орон сууцны зээлийн сарын төлбөрийг гаргахдаа I зээлдэгчийн орон сууцны дундаж зээлийн хэмжээ, жигнэсэн дундаж хугацаа, хүүг ашигласан болно.

Хувийн салбарын өрийн дарамтыг хэмжихдээ аж ахуйн нэгжийн дотоод зээл ба гадаад өр төлбөрийн ДНБ-д эзлэх хувиар төлөөлүүлэн авч үзэв. 2005 оноос хойш гадаад өрийн

дарамт хурдтай өссөөр байгаа бөгөөд 2015 оны 2 дугаар улиралд хувийн салбарын гадаад өр ДНБ-ий 46 хувьд хүрээд байна. Харин хувийн салбарын дотоод өр ДНБ-ий 28 хувьд хүрч буурав.

**Дүрслэл 2.14**

**Хувийн салбарын өрийн дарамт**




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк.  
 Тэмдэглэл: \*Аж ахуйн нэгжийн зээлийн өрийн үлдэгдэл ба нэрлэсэн ДНБ-ий харьцаа (жилийн ДНБ);  
 \*\*Хувийн салбарын гадаад зах зээлээс зээлдсэн эх үүсвэр (өрийн бичиг, зээл, бусад өглөг) ба нэрлэсэн ДНБ-ий харьцаа (жилийн ДНБ).

**Орон сууцны үнэ буурав.** Орон сууцны үнийн индексийг Үндэсний статистикийн хороо 2007 оноос, Тэнхлэг зууч компани 2013 оноос тус тус тооцож эхэлсэн билээ. 2014 оноос эхлэн орон сууцны үнийн өсөлт саарч эхэлсэн бөгөөд 2015 оны 8 сард жилийн 10.1 хувийн бууралттай гарчээ. Манай улсад зээл үнэлгээний харьцаа (loan to value ratio) 70 хувьтай мөрдөгдөж байна. Өөрөөр хэлбэл зээлдэгч 30 хувийн урьдчилгаа төлж, үлдсэн 70 хувьтай тэнцэх хэмжээний зээлийг банкнаас авах боломжтой юм.

**Дүрслэл 2.15**

**Орон сууцны үнэ, ипотекийн зээлдэгчдийн тооны жилийн өөрчлөлт**




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк.  
 Тэмдэглэл: Хамгийн сүүлийн утга нь 2015 оны 2 дугаар улирлын статистик болно.

**Өөрийн хөрөнгө**

**Банкны салбарын өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт сайжрав.** Банкны системийн эрсдэл даах чадварыг тодорхойлдог өөрийн хөрөнгийн хэмжээ 2015 оны 7 дугаар сарын эцсийн байдлаар 2.5 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 21.6 хувиар буюу 444.2 тэрбум төгрөгөөр, эрсдэлээр жигнэсэн активын хэмжээ 13.9 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 15.5 хувиар буюу 1.9 их наяд төгрөгөөр нэмэгдлээ.

**Дүрслэл 2.16**

**Өөрийн хөрөнгийн үзүүлэлтүүд**



Эх сурвалж: Монголбанк.


Банкны салбарын нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 12.9 хувь, нийт өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 17.5 хувь байгаа нь Монголбанкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтээс харгалзан 3.9 ба 5.5 нэгж хувиар тус тус өндөр байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс харгалзан 0.7, 0.5 нэгж хувиар сайжирсан байна.

**Ашигт ажиллагаа**

**Банкны салбарын ашигт ажиллагаа буурах хандлагатай байна.** Банкуудын зээл олголтын хэмжээ буурч, зээлийн чанар муудаж байгаагаас шалтгаалан зээлийн хүүгийн орлогын өсөлт саарч, зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах сангийн зардал өсч байна.

**Дүрслэл 2.17**

**Банкны актив болон өөрийн хөрөнгийн өгөөж**



Эх сурвалж: Монголбанк.

Зээлийн хүүгийн орлого 2015 оны 7 дугаар сарын эцсийн байдлаар 1.3 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 13.8 хувиар өссөн бол чанаргүй болон хугацаа хэтэрсэн ангилалд шилжсэн зээлүүдэд байгуулсан зээлийн эрсдэлийн сангийн зардал 105.8<sup>29</sup> тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 72.0

<sup>29</sup> Шинээр олгосон зээлүүдэд байгуулсан 1 хувийн ерөнхий эрсдэлийн сангийн зардлыг хасч тооцсон.

хувиар нэмэгдсэн байна. Үүнтэй холбоотойгоор банкны салбарын ашигт ажиллагааны үзүүлэлтүүд болох активын болон өөрийн хөрөнгийн өгөөж өнгөрсөн оны мөн үеэс 0.1, 2.1 нэгж хувиар буурч 1.5, 11.3 хувь болжээ.

**Дүрслэл 2.18**

**Зээлийн эрсдэлийн сангийн өсөлт**



Эх сурвалж: Монголбанк, Арилжааны банкуудын нэгдсэн тайлан.

**Гадаад валютын позиц**

Тайлант улирлын эцсийн байдлаар банкны салбарын гадаад валютын зохистой харьцааны үзүүлэлт нэгж валютын хувьд ч, нийт валютын хувьд ч Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж байна.<sup>30</sup> Нийт гадаад валютын активын хэмжээ 6.0 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 5.5 хувиар буюу 352.3 тэрбум төгрөгөөр буурсан бол, гадаад валютын пассивын хэмжээ 7.3 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 6.3 хувиар буюу 430.4 тэрбум төгрөгөөр нэмэгджээ.


<sup>30</sup> Банкууд гадаад валютын нээлттэй позиц, өөрийн хөрөнгийн харьцааг нэг валютын хувьд +/-15 хувийн дотор, нийт нээлттэй позицийн хувьд +/-40 хувийн дотор барьж байх шаардлагатай.

**Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар**

**Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт харьцангуй тогтворжив.** Нэг талаас банкны салбарын үндсэн эх үүсвэр болох харилцах, хадгаламжийн өсөлт саарахын зэрэгцээ Монголбанкны хөтөлбөрийн зээлүүд эргэн төлөгдөхийн хэрээр төв банкнаас арилжааны банкуудад олгосон зээлийн үлдэгдэл буурч байгаа нь банкны салбарын нийт эх үүсвэр буурахад нөлөөлж байна.

**Дүрслэл 2.19**

**Банкны салбарын актив, пассивт гарсан өөрчлөлт (2014.07-2015.07)**




Эх сурвалж: Монголбанк.

Нөгөө талаас банкууд харьцангуй өндөр хүүтэй засгийн газрын дунд болон урт хугацаатай үнэт цаасанд 1.5 их наяд төгрөг буюу нийт активын 7.1 хувийг байршуулсан (богино хугацаатай үнэт цаасыг оруулан тооцвол 2.3 их наяд төгрөг буюу нийт активын 10.5 хувь) нь хөрвөх чадварын үзүүлэлтүүд буурахад нөлөөлөв.

**Дүрслэл 2.20**

**Банкны салбарын төлбөр түргэн гүйцэтгэх чадвар**




Эх сурвалж: Монголбанк.

Харин 2015 оны 5 дугаар сард төв банкны үнэт цаасны үлдэгдэл өмнөх сараас 854 тэрбум төгрөгөөр буюу 2.7 дахин өссөнөөс шалтгаалан хөрвөх чадварын үзүүлэлтүүд сайжирсан байна. Тухайлбал, банкны системийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 2015 оны 7 дугаар сард 39.3 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 1.0 нэгж хувиар нэмэгджээ.

**Дүрслэл 2.21**

**Хөрвөх чадварын үзүүлэлт**



Эх сурвалж: Монголбанк.

Тэмдэглэл: \* (Банкны нөөц+ТБҮЦ)/(Харилцах+Хадгаламж).  
\*\* (Банкны нөөц+ТБҮЦ+ЗГ-ын богино хугацаатай үнэт цаас)/(Харилцах+Хадгаламж).


Зээл, хадгаламжийн зохистой харьцааны талаарх олон улсын судалгаанаас үзэхэд



энэхүү харьцаа 120 хувиас хэтрэх нь банкны салбар төлбөрийн чадварын эрсдэл дээр анхаарал хандуулах хэрэгтэй болсныг сануулдаг байна.<sup>31</sup> Харин манай орны хувьд уг үзүүлэлт хөтөлбөрийн зээлийг цэвэршүүлж тооцсоноор 107.1 хувьтай байна.

**Дүрслэл 2.22**

**Зээл, хадгаламжийн харьцаа**



Эх сурвалж: Монголбанк.

<sup>31</sup> Jan Willem van den End, “A macroprudential approach to address liquidity risk with the Loan-to-deposit ratio” DNB Working Paper, No. 372, Feb 2013.

## МАКРО ЗОХИСТОЙ БОДЛОГО, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТ

Сүүлийн жилүүдэд санхүүгийн системийн эрсдэлийг бууруулах, эдийн засгийн мөчлөгийн далайцыг багасгах зорилгоор мөчлөг сөрсөн, эрсдэлд суурилсан микро хяналт шалгалт болон макро зохистой бодлогын цогц арга хэрэгслүүдийг нэвтрүүлэн ашиглаж байна. Монголбанкнаас банкны салбарын эрсдэл даах чадварыг сайжруулах хүрээнд 2014 онд дараах бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлээд байна. Үүнд:

- ◆ **Ханшийн эрсдэлтэй зээлдэгчид олгосон валютын зээлийн эрсдэлээр жигнэх хувийг нэмэгдүүлэх:** Өнгөрсөн 3 жилийн зээлийн чанарын үзүүлэлтүүдээс харахад гадаад валютаар олгосон зээлийн эрсдэл эдийн засгийн нөхцөл байдал, ханшийн хэлбэлзэл, гадаад худалдааны орчноос хамааран төгрөгийн зээлийн эрсдэлээс харьцангуй өндөр байсан. Тухайлбал 2014 оны эцсийн байдлаар төгрөгийн чанаргүй зээлийн хувь 2.4 хувь байхад, гадаад валютын чанаргүй зээлийн хувь 6.7 хувьтай байна. Иймд гадаад валютын зээлийн эрсдэлийг бууруулах макро зохистой бодлогын хүрээнд ханшийн эрсдэлээс хамгаалагдаагүй гадаад валютын зээлийн эрсдэлийн жинг өсгөх замаар банкуудын төлбөрийн чадвар, өөрийн хөрөнгийн хүрэлцээг чангатгалаа. Энэ нь зээлийн долларжилтыг саармагжуулах, гадаад валютын зээлийн эрсдэлийг бууруулах, улмаар санхүүгийн тогтвортой байдлыг дунд, урт хугацаанд хангахад чухал алхам болсон.
- ◆ **Хэвийн зээлд 1 хувийн эрсдэлийн сан байгуулах:** Макро зохистой бодлогын үндсэн арга хэрэгслүүдийн нэг болох динамик эрсдэлийн санг нэвтрүүлэх боломжийг судлан шинээр олгосон хэвийн

зээлд нэг хувийн ерөнхий эрсдэлийн сан байгуулах зохицуулалтыг бий болгосон. Динамик буюу мөчлөг сөрсөн эрсдэлийн санг байгуулснаар нийт банкны системийн эрсдэл даах чадвар сайжран, активын чанар алдагдаж, чанаргүй зээлийн хувийн жин нэмэгдэхээс үүсэх алдагдлыг банкны ашигт ажиллагаа, өөрийн хөрөнгийн хүрэлцээ, төлбөрийн чадвар, тайлан тэнцэлд томоохон хэлбэлзэл үүсгэхгүйгээр барагдуулах боломжийг нэмэгдүүлж, санхүүгийн зуучлалыг цаашид хэвийн үргэлжлүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх онцгой ач холбогдолтой. Динамик эрсдэлийн санг анх 2000 онд Испанийн төв банкнаас зээлийн хэт өсөлтийг хязгаарлах, зээлийн өсөлтөд хамаарах эрсдэлийн сан байгуулалтын цаг хугацааны хоцрогдлыг арилгах зорилгоор ашигласан бөгөөд дэлхийн олон орны төв банкууд энэхүү арга хэрэгслийг түгээмэл хэрэглэж байна.

- ◆ **Банкуудын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг нэмэгдүүлэх:** Монголбанкны Ерөнхийлөгчийн 2015 оны 4 дүгээр сарын 1-ний А-58 дугаар тушаалаар банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 50 тэрбум төгрөг байхаар шинэчлэн тогтоолоо. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 1991 онд 50 сая төгрөгөөр анх тогтоож эхэлсэн бол 1995 онд 400 сая төгрөг, 1999 онд 2 тэрбум төгрөг, 2001 онд 4 тэрбум төгрөг, 2006 онд 8 тэрбум төгрөг, 2011 онд 16 тэрбум төгрөгөөр тус тус тогтоож байсан. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн ийнхүү нэмэгдүүлснээр банкны салбарын эрсдэл даах чадвар сайжрахын зэрэгцээ, банкуудын томоохон төслүүдийг бие даан санхүүжүүлэх чадавхийг нэмэгдүүлэх, хувь нийлүүлэгчдийн санхүүгийн

хариуцлагыг дээшлүүлэх, цаашлаад жижиг банкуудын үйл ажиллагааг идэвхжүүлэн банкны салбарт шударга өрсөлдөөнийг бүрэлдүүлэх зэрэг олон давуу талыг бий болгоно.

- ♦ **Банкны салбарын өөрийн хөрөнгийн бүтцийг оновчтой болгох:** Банкны өөрийн хөрөнгийг I болон II зэрэглэлийн өөрийн хөрөнгө гэж ангилдаг. Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгөд хувь нийлүүлсэн хөрөнгө, хуримтлагдсан ашиг, нөөц сан багтах ба эдгээр нь хохирлыг хамгийн түрүүнд барагдуулах шинж чанартай эх үүсвэрээс бүрддэг бол хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийн бүтцэд дахин үнэлгээний нэмэгдэл, давуу эрхтэй хувьцаа, нэмж төлөгдсөн хувьцаа, хоёрдогч өглөг зэрэг хохирлыг барагдуулах чадвар бага эх үүсвэрүүд ордог. Тиймээс банкны системийн өөрийн хөрөнгийн бүтцийг оновчтой болгож, Базел II-ийн хүрээний зөвлөмжид нийцүүлэх зорилгоор өмнө ашиглаж байсан өөрийн хөрөнгөд оруулан тооцох хоёрдогч өглөгийн хэмжээ нь I зэрэглэлийн өөрийн хөрөнгийн 50 хувиас, II зэрэглэлийн өөрийн хөрөнгө нь I зэрэглэлийн өөрийн хөрөнгөөс хэтрэхгүй байх хязгаарлалтуудыг тус тус сэргээсэн. (Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн А-122 дугаар тушаал)

**Цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөж буй бодлогын арга хэмжээ:** Макро зохистой бодлогын хүрээнд дэлхийн улс орнуудад системийн нөлөө бүхий банкуудад зохистой харьцааны нэмэлт шаардлага тавих нь түгээмэл байдаг. Манай орны хувьд системийн нөлөө бүхий банкууд нь нийт өөрийн хөрөнгийн нэмэлт 2 хувийн шаардлагыг мөрддөг боловч нэгдүгээр

зэрэглэлийн өөрийн хөрөнгийн шаардлага нь бусад банкуудтай ижил буюу 9 хувь байдаг. Банкны системд хүндрэл үүссэн тохиолдолд I дүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө нь хохирлыг барагдуулах үндсэн эх үүсвэр болдог тул системийн нөлөө бүхий банкуудад нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн нэмэлт шаардлагыг тавих нь зүйтэй юм. Энэ хүрээнд системийн нөлөө бүхий банкуудын нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн шаардлагыг 1.5 нэгж хувиар нэмэгдүүлэн 10.5 хувь болгохоор төлөвлөн ажиллаж байна.

Түүнчлэн, эрсдэлтэй гэж үзсэн салбаруудын зээлийн эрсдэлээр жигнэх хувийг санхүүгийн салбарын нөхцөл байдалтай уялдуулан нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

2015-2016 онд банк, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангахад активын удирдлагын бүтцийг төрөлжүүлэх, хоёрдогч зах зээлийн хөгжлийг дэмжих арга хэмжээ чухал болж байна. Иймд энэ чиглэлд СТБЗ-ийг бүрдүүлэгч байгууллагууд хамтран ажиллаж, санхүүгийн салбарт учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, санхүүгийн тогтвортой байдлыг үргэлжлүүлэн хангах нь чухал байна.

**Шигтгээ 3: Мөчлөг сөрсөн өөрийн хөрөнгийн нөөц**

Тогтвортой бөгөөд үр ашигтай санхүүгийн систем урт хугацаанд эдийн засгийн өсөлтийг дэмждэг болохыг судалгааны олон үр дүн харуулсан байдаг. Төлбөр тооцоог найдвартай явуулах, санхүүгийн нөөцийг оновчтой хуваарилах, эрсдэлийг тараан байршуулах зэрэг санхүүгийн салбарын үндсэн үүргийг хэрэгжүүлэхэд банкууд чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд банкны салбарт тогтворгүй байдал үүсэх нь нийт эдийн засагт ихээхэн сөрөг нөлөөтэй юм. Банкны хяналт шалгалтын тогтолцооны голлох хэсэг болсон өөрийн хөрөнгийн шаардлага нь санхүүгийн тогтворгүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх, эрсдэл даах чадварыг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой билээ. Анх 1988 онд Базелийн хорооноос өөрийн хөрөнгийн хүрэлцээг<sup>32</sup> тооцох аргачлалыг танилцуулж, улс орнууд банкны хяналт, шалгалтын тогтолцоондоо өргөнөөр ашиглах болсон.<sup>33</sup> Эхэн үедээ улс орнууд статик (цаг хугацаанд өөрчлөгдөхгүй тогтмол) өөрийн хөрөнгийн шаардлагыг ашиглаж байв. Статик өөрийн хөрөнгийн шаардлага нь санхүүгийн системийн тогтмол эрсдэлийг удирдахад тохиромжтой байдаг бол цаг хугацаанд өөрчлөгддөг, санхүүгийн мөчлөгийн дагуу үүсдэг эрсдэлийг удирдахад хангалтгүй юм. Эдийн засгийн нөхцөл байдал сайн байгаа үед банкууд их хэмжээний зээл олгож, улмаар хөрөнгийн үнийн хөөсрөлт үүсдэг ба санхүүгийн системд эрсдэл бага мэт харагддаг. Гэвч үнэндээ энэ үед хамгийн томоохон системийн шинжтэй эрсдэлүүд хуримтлагдах магадлал өндөр байдаг. Эдийн засгийн нөхцөл байдал таагүй болоход санхүүгийн салбарт эрсдэл бодитоор нүүрлэх бөгөөд энэ үед банкууд зээл олголтгоо эрс бууруулдаг. Санхүүгийн зах зээлийн хурдацтай хөгжил, даяарчлалын орчинд бий болж буй хөрөнгийн урсгалын өндөр хэлбэлзлээс шалтгаалан улс орон бүрт санхүүгийн мөчлөгийн далайц нэмэгдээд байна. Өөрөөр хэлбэл мөчлөгийн дагуу үүсдэг эрсдэл өндөр болж ирсэн. Иймээс мөчлөг сөрсөн, динамик өөрийн хөрөнгийн шаардлагын хэрэгцээ өсөн нэмэгдэж байна.

Уламжлалт өөрийн хөрөнгийн шаардлага нь санхүүгийн системийг бүхэлд нь хянахаас илүүтэйгээр банк тус бүрийн эрүүл байдалд анхаардаг бол мөчлөг сөрсөн өөрийн хөрөнгийн шаардлага нь уламжлалт хяналт, шалгалтаар илрэхгүй байгаа системийн эрсдэлийг удирдахад чиглэгддэг. Олон улсын төлбөр, тооцооны банк (ОУТТБ) 2011 онд банкны хяналт, шалгалтын Базел III (2011) олон улсын стандартдаа мөчлөг сөрсөн өөрийн хөрөнгийн нөөц бүрдүүлэх талаар зааварчилгаа оруулсан байдаг. Уг стандартад дурдсанаар, мөчлөг сөрсөн өөрийн хөрөнгийн шаардлага нь зээлийн өсөлт өндөр үед нэмэлт нөөц бүрдүүлэх замаар системд хуримтлагдаж болзошгүй эрсдэлийг хязгаарлах, санхүүгийн мөчлөгийн уналтын үед зээл олголт зогсохоос сэргийлэх, улмаар банкны салбарын тогтвортой байдлыг хадгалах үндсэн зорилготой юм. Мөчлөг сөрсөн өөрийн хөрөнгийн нөөц бүрдүүлэхэд хувийн салбарт олгосон зээл, ДНБ-ий харьцааг удирдлага болгохыг зөвлөсөн байдаг төдийгүй энэ нь санхүүгийн мөчлөг тооцоход чухал үзүүлэлт болдог. Мөчлөг сөрсөн өөрийн хөрөнгийн нөөц байгуулахад дараах алхмын дагуу тооцооллыг хийнэ:

- ◆ **Хувийн салбарт олгосон зээл, ДНБ-ий харьцааг тооцох:** Эдгээр үзүүлэлтүүд нь нэрлэсэн дүнгээр, улирлын давтамжтай байх хэрэгтэй бөгөөд харьцаа нь хувиар илэрхийлэгдсэн байх;
- ◆ **Дээрх харьцааны урт хугацааны трендээсээ зөрөх зөрүүг тооцох:** Hodrick-Prescott

<sup>32</sup> Өөрийн хөрөнгийн харьцаа—Өөрийн хөрөнгө/Эрсдэлээр жигнэсэн актив.

<sup>33</sup> Reserve bank of New Zealand (2007), “Capital adequacy ratios for banks—simplified explanation and example of calculation”


фильтер зэрэг стандарт аргачлалын дагуу зээл, ДНБ-ий харьцааны урт хугацааны трендийг тооцсоны дараа трендээсээ зөрөх зөрүүг олно. Зээл, ДНБ-ий харьцаа урт хугацааны трендээсээ өндөр байх нь зээлийн хэт өсөлт явагдсан байж болзошгүйг илтгэнэ;

- ◆ **Мөчлөг сөрсөн өөрийн хөрөнгийн нэмэлт шаардлагын хэмжээг тодорхойлох:** Зээл, ДНБ-ий зөрүү нь тогтоосон доод хилийн (lower threshold) утгаас бага байх үед өөрийн хөрөнгийн нэмэлт шаардлага тэгтэй тэнцүү байна. Харин дээрх зөрүү доод хилийн утгаас давах үед өөрийн хөрөнгийн нэмэлт шаардлага дагаад өсөх ба дээд хилийн утга (upper threshold) хүртэл өсч болно. Дээд, доод хилийн утга нь улс орнуудын онцлогоос шалтгаалан харилцан адилгүй байх боломжтой ч, ОУТТБ-наас банкны хямралын түүхэн өгөгдөлд үндэслэн судалж, доод хилийн утгыг 2 хувь, дээд хилийн утгыг 10 хувиар авахыг санал болгосон байдаг.

ОУТТБ-наас санал болгосон аргачлалын дагуу мөчлөг сөрсөн өөрийн хөрөнгийн нэмэлт шаардлагыг Монгол Улсын хувьд тооцож, Дүрслэл 2.23-г үзүүлэв. 2007, 2011 онуудад нэг талаас гадаад валютын орох урсгал огцом өсч, банкуудын эх үүсвэр нэмэгдсэн, нөгөө талаас дэлхийн зах зээл дэх Монгол Улсын экспортын гол түүхий эдийн үнийн өсөлтөөр өдөөгдсөн эдийн засгийн идэвхжилийг дагаад зээлийн эрэлт өндөр байсан зэрэгтэй уялдан банкууд зээлийн нөхцөлөө сулруулж, зээл олголтоо тэлж эхэлсэн. Энэ үед санхүүгийн салбарт системийн эрсдэл хуримтлагдсаар байсан. Тухайлбал, 2007 оны эцэст зээл/ДНБ харьцаа оргилдоо хүрч, санхүүгийн зах зээл хөөсрөлтийн нөхцөл байдалд орсон ба нэг жил гаруй хугацааны дараагаар санхүү, эдийн засгийн хямрал бий болсон байдаг. Хэрэв энэ үед (2007Q1-2008Q2) мөчлөг сөрсөн өөрийн хөрөнгийн нөөц бүрдүүлсэн бол нэмэлт 2.5 хувийн өөрийн хөрөнгийн шаардлага банкуудад тавигдах байсан бөгөөд зээлийн хэт өсөлтийг хязгаарлахад тустай байх байжээ.

### Дүрслэл 2.23

**Мөчлөг сөрсөн өөрийн хөрөнгийн нөөц бүрдүүлэх зарчим**



Эх сурвалж: Sveriges Riksbank (2012), "Countercyclical capital buffers as a macroprudential instrument"; Монголбанк.  
Тэмдэглэл: \*Мөчлөг сөрсөн өөрийн хөрөнгийн нэмэлт шаардлага. 2.5 хувийг жишээ болгох үүднээс авсан бөгөөд зээл/ДНБ-ий дээд, доод хилийн утгыг ОУТТБ-ны санал болгосон 2, 10 хувиар тус тус авав.

## 2.2 БАНКНЫ БУС САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ

### БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА, ХАДГАЛАМЖ ЗЭЭЛИЙН ХОРШОО


#### Банк бус санхүүгийн байгууллагын өнөөгийн байдал

##### Ерөнхий төлөв байдал

2015 оны 2 дугаар улирлын байдлаар нийт 423 ББСБ Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхэлж байна.

##### Дүрслэл 2.24

##### Бүртгэлтэй банк бус санхүүгийн байгууллагын тоо



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Банкуудын зээлийн нөхцөл чангарсантай холбоотойгоор иргэд, аж ахуйн нэгжүүд банк бус санхүүгийн байгууллагуудад хандан хурдан шуурхай зээл авах ажиллагаа идэвхжсэн нь банк бус санхүүгийн байгууллагуудын тоог 2015 онд өсгөх үндсэн шалтгаан болов.

2014 болон 2015 оны 2 дугаар улирлын эцсийн байдлаарх ББСБ-уудын статистикийн голлох үзүүлэлтүүдийг Хүснэгт 2.1-т хураангуйлав.

##### Хүснэгт 2.1

##### Банк бус санхүүгийн байгууллагын голлох статистик үзүүлэлтүүд (тэрбум төгрөг)

№	Үндсэн үзүүлэлтүүд	2014	2015Q2
1	ББСБ-ын тоо	378	423
2	Хувьцаа эзэмшигчдийн тоо	868	849
3	Ажиллагсадын тоо	1 678	1 774
4	Салбар нэгжийн тоо	92	99
5	Харилцагчдын тоо	663 098	457 540
6	Нийт актив	508	555
	Банкны салбарт эзлэх хувь	2.3%	2.5%
7	Нийт зээлийн өрийн үлдэгдэл	303	361
	Банкны салбарт эзлэх хувь	2.4%	3.0%
8	Нийт эзэмшигчдийн өмч	332	368
	Банкны салбарт эзлэх хувь	15.6%	14.7%
9	Итгэлцлийн үйлчилгээний өглөг	26	32
10	Банк, банк бус санхүүгийн байгууллагаас татсан зээл	124	124
	Үүнээс:		
	Богино хугацаат зээл	60	66
	Урт хугацаат зээл	63	58
11	Төслийн зээлийн санхүүжилт	13	14
12	Нийт орлого	133	77
13	Нийт зардал	97	56
14	Тайлант үеийн ашиг	36	21

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Нийт ББСБ-ын 83.6 хувь нь зээл, 31.0 хувь нь гадаад валютын арилжаа, 6.1 хувь нь хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх, 1.4 хувь нь цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, 4.0 хувь нь факторингийн үйлчилгээ, 3.1 хувь нь төлбөрийн баталгаа гаргах, 5.9 хувь нь итгэлцлийн үйлчилгээ, 0.5 хувь нь богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх үйлчилгээг тус тус эрхлэн явуулж байна.

### Хүснэгт 2.2

#### Банк бус санхүүгийн байгууллагын эрхэлж буй үйл ажиллагааны төрөл

№	Үйл ажиллагааны нэр төрөл	2014	2015Q2
1	Зээл	323	361
2	Гадаад валютын арилжаа	129	131
	Үүнээс: зөвхөн гадаад валютын арилжааг дагнан эрхэлдэг	53	52
3	Итгэлцлийн үйлчилгээ	24	25
4	Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	29	26
5	Факторингийн үйлчилгээ	16	17
6	Төлбөрийн баталгаа гаргах	11	13
7	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	6	6
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	2	2
9	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	0	0
	Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	0	0


Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

### Нийт актив

2007 хойш нийт актив жил бүр өсөн нэмэгдсээр 2015 оны 2 дугаар улирлын эцэст 554.5 тэрбум төгрөгт хүрэв. Нийт активын 535.5 тэрбум төгрөг нь эргэлтийн хөрөнгө бөгөөд үүний 27.1 хувийг мөнгөн хөрөнгө эзэлжээ.

### Дүрслэл 2.25

#### Банк бус санхүүгийн байгууллагын нийт хөрөнгийн бүтэц (тэрбум төгрөг)




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

### Зээлийн чанар

2015 оны эхний хагас жилийн байдлаар зээлийн багц нийт активын 65.3 хувь буюу 362.3 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс 34.0 хувиар өссөн дүнтэй байна. Энэхүү өсөлтийн 26.4 нэгж хувь нь хэвийн зээлийн өсөлт, 2.8 нэгж хувь нь хугацаа хэтэрсэн зээлийн өсөлт, 4.8 нэгж хувь нь чанаргүй зээлийн өсөлтөөр тайлбарлагдаж байна.

### Дүрслэл 2.26

#### Банк бус санхүүгийн байгууллагын нийт зээл, зээлийн чанар (тэрбум төгрөг)



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

2015 оны 2 дугаар улиралд чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 84.7 хувиар өсч 28.4 тэрбум төгрөгт хүрэв. Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 7.8 хувь байгаа нь банкны салбартай харьцуулахад 1.3 нэгж хувиар өндөр байгаа юм.<sup>34</sup> Чанаргүй зээлийн хэмжээ, түүний дотор муу зээлийн хэмжээ 2 дахин нэмэгдсэнтэй холбогдон зээлийн эрсдэлийн сан өмнөх оны мөн үеэс 10.4 тэрбум төгрөг буюу 97.0 хувиар өсч 21.0 тэрбум төгрөгт хүрсэн байна. Харин эрсдэлийн сангаар цэвэршүүлсэн чанаргүй зээл ба нийт зээлийн харьцаа 2.0 хувь байлаа.


<sup>34</sup> Анод, Зоос, Хадгаламж зэрэг татан буугдсан банкуудын чанаргүй зээлийг оруулж тооцсон чанаргүй зээл нийт зээлийн харьцаа 2015 оны 2 дугаар улирлын эцэст 6.5 хувь байгаа ба харин хасч тооцвол 4.6 хувь байна.

### Зээлийн хүү

2014 онд ББСБ-уудын зээлийн сарын хамгийн дээд хүү 12.0 хувь, хамгийн бага хүү 0.3 хувьтай байсан бол нийт ББСБ-уудын зээлийн сарын дундаж хүү 2.6 хувьтай байлаа.

#### Дүрслэл 2.27

Банк ба ББСБ-ын зээлийн сарын дундаж хүү (%)



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

### Нийт эх үүсвэр ба Эзэмшигчдийн өмчийн бүтэц

2015 оны 2 дугаар улирлын эцэст өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт өр төлбөр 12.5 хувиар, эзэмшигчдийн өмч 31.7 хувиар тус тус өссөн байна. 2014 оны эцсийн байдлаар нийт эх үүсвэрийн 34.6 хувийг өр төлбөр, 65.4 хувийг эзэмшигчийн өмч эзэлж байсан бол 2015 оны 2 дугаар улирлын эцсийн байдлаар нийт өр төлбөр 33.6 хувь, эзэмшигчийн өмч 66.4 хувь болж өөрчлөгдсөн.

ББСБ-ын тоо өсөн нэмэгдэхийн хэрээр хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ өсчээ. Тухайлбал, 2014 онд хувь нийлүүлсэн хөрөнгө 74.5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэний 42.7 тэрбум нь шинээр тусгай зөвшөөрөл авсан 120 ББСБ-ын хувь хөрөнгө байв.

### Хүснэгт 2.3

Банк бус санхүүгийн байгууллагын санхүүгийн голлох үзүүлэлтүүд (тэрбум төгрөг)

Үзүүлэлтүүд	2009	2010	2011	2012	2013	2014	2015Q2
Нийт актив	96.5	128.6	205.4	252.1	381.1	508.0	554.5
Нийт олгосон зээл	55.5	78.1	119.0	157.8	223.7	303.1	362.3
Нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмч	96.5	128.6	205.4	252.1	381.1	508.0	554.5
Нийт өр төлбөр	21.6	36.6	67.2	80.7	146.8	175.9	174.2
Эзэмшигчдийн өмч	74.8	92.0	138.2	171.3	234.3	332.1	368.1
Үүнээс:							
Хувьцаат капитал	66.4	80.0	116.5	137.9	183.7	258.2	285.0
Бусад өмч	0.5	0.5	3.2	7.6	7.2	7.2	8.6
Сангууд	1.1	1.1	1.1	0.1	0.2	0.3	0.3
Хуримтагдсан ашиг/алдагдал	6.1	9.4	14.7	24.2	41.7	64.0	72.4
Хоёрдогч өглөг	0.8	0.9	2.7	1.6	1.6	2.4	1.7
Нийт орлого	26.6	30.1	46.3	70.5	106.6	132.9	77.1
Нийт зарлага	21.7	22.9	34.9	51.9	76.8	96.5	56.2
Татварын дараах цэвэр ашиг	4.9	7.1	11.4	18.6	29.8	36.4	21.0

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

### Орлого, зарлага, ашигт ажиллагаа

2015 оны эхний хагас жилд салбарын хэмжээнд нийт 77.1 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 21.4 хувиар өссөн үзүүлэлт юм. Нийт орлогын 71.8 хувийг хүүгийн орлого, 27.1 хувийг хүүгийн бус орлого тус тус эзэлж байна. Харин ашигт ажиллагааны гол үзүүлэлт болох ROA (активын өгөөж) 2015 оны эхний хагас жилийн байдлаар 3.8 хувь байгаа нь банкны салбарынхтай харьцуулахад өндөр байгаа юм.

### Хүснэгт 2.4

Орлого, зарлага, ашигт ажиллагаа (тэрбум төгрөг)

№	Үзүүлэлтүүд	2015Q2
1	<b>Нийт орлого</b>	<b>77.1</b>
	Хүүгийн орлого	55.4
	Хүүгийн бус орлого	20.9
	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	0.7
	Ердийн бус орлого	0.1
2	<b>Нийт зардал</b>	<b>56.2</b>
	Хүүгийн зардал	7.0
	Хүүгийн бус зардал	38.5
	Болзошгүй эрсдэлийн зардал	7.6
	Үндсэн бус үйл ажиллагааны зардал	0.5
	Ердийн бус зардал	0.1
3	<b>Орлогын татварын зардал</b>	<b>2.7</b>
4	<b>Татварын дараах цэвэр ашиг</b>	<b>21.0</b>

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.



2014 оны эцсийн байдлаар нийт хүүгийн бус орлогын 9.8 хувийг гадаад валютын арилжааны орлого, 68.3 хувийг ханшийн тэгшитгэлийн орлого, 18.4 хувийг бусад санхүүгийн үйлчилгээний орлого эзэлж байсан бол 2015 оны 2 дугаар улирлын байдлаар нийт хүүгийн бус орлогын 9.0 хувийг гадаад валютын арилжааны орлого, 71.1 хувийг ханшийн тэгшитгэлийн орлого, 15.9 хувийг бусад санхүүгийн үйлчилгээний орлого болж өөрчлөгджээ.

### ББСБ-уудын зохистой харьцааны үзүүлэлт

ББСБ-ын санхүүгийн тайлангийн нэгтгэлээр СЗХ-ны 191 дүгээр тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-аар тогтоосон үзүүлэлтүүдийг 2014 оны эцсийн байдлаар системийн түвшинд тооцоход дараах байдалтай байна. Үүнд:

- ◆ 2014 оны эцэст нийт өөрийн хөрөнгө 332.0 тэрбум төгрөг, эрсдэлээр жигнэсэн актив 350.3 тэрбум төгрөг байсан ба өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцааны шалгуур үзүүлэлт нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын хувьд 93.7% хувь, өөрийн хөрөнгийн хувьд 96.7% хувь, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын хувьд 64.4 хувь;
- ◆ Валютын дансны цэвэр зөрүү 12.2 тэрбум төгрөг, тухайн валютаарх өөрийн хөрөнгө 331.6 тэрбум төгрөг байгаагаас нийт гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа 3.7 хувь;
- ◆ Итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн өглөгийн үлдэгдэл 25.7 тэрбум төгрөг, өөрийн хөрөнгө 340.5 тэрбум төгрөг байгаагаас итгэлцлийн

үйлчилгээний өглөг, өөрийн хөрөнгийн харьцаа 7.5 хувь;

- ◆ Түргэн борлогдох актив 122.0 тэрбум төгрөг, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө 123.4 тэрбум төгрөг байгаагаас төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 98.9 хувь;
- ◆ Нийт цэвэршүүлсэн үндсэн хөрөнгө 8.5 тэрбум төгрөг, нийт актив 508.0 тэрбум төгрөг байгаагаас үндсэн хөрөнгө, нийт активын харьцаа 1.7% хувь тус тус байлаа.

### Хүснэгт 2.5

#### ББСБ-уудын зохистой харьцааны үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Зохистой харьцааны шаардлагат түвшин	2014 оны эцэс
<b>1. Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт</b>		
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа	10% <=	93.7%
Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа	20% <=	96.7%
Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	10% <=	64.4%
<b>2. Гадаад валютын эрсдэлийн үзүүлэлт</b>		
Нэгж валютын хувьд	[-40%, 40%]	
Нийт валютын хувьд	[-40%, 40%]	3.7%
<b>3. Итгэлцлийн үйлчилгээний өглөг, хувьцаат капиталын үзүүлэлт</b>		
Итгэлцлийн үйлчилгээний өглөг ба хувьцаат капиталын харьцаа	80% >=	7.5%
<b>4. Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар</b>		
Түргэн борлогдох актив, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн харьцаа	8% <=	98.9%
<b>5. Үндсэн хөрөнгийн үзүүлэлт</b>		
Цэвэршүүлсэн үндсэн хөрөнгийн дүн ба нийт активын харьцаа	15% >=	1.7%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

2014 онд салбарын дүнгээр дээрх байдлаар зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг ханган ажиллаж байгаа боловч үйл ажиллагаа явуулж буй 378 ББСБ-аас 5 ба түүнээс дээш зохистой харьцааг хангаагүй 2 ББСБ, 4 зохистой харьцааг хангаагүй 2 ББСБ, 3 зохистой харьцааг хангаагүй 17 ББСБ, 2 зохистой харьцааг хангаагүй 107 ББСБ, 1 зохистой харьцааг хангаагүй 201 ББСБ байгаа бол 49 ББСБ бүх зохистой харьцааг хангаж ажиллажээ.


**Хадгаламж, зээлийн хоршооны өнөөгийн байдал**

**Ерөнхий төлөв байдал**

2015 оны 2 дугаар улирлын байдлаар 242 Хадгаламж, зээлийн хоршоо СЗХ-ноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна.

**Дүрслэл 2.28**

**Хадгаламж, зээлийн хоршоо болон гишүүдийн тоо**



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Хадгаламж, зээлийн хоршоодын активын хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11.4 хувиар буюу 8.8 тэрбум төгрөгөөр өсч 85.6 тэрбум төгрөгт хүрэв.

**Хүснэгт 2.6**

**Хадгаламж, зээлийн хоршоодын голлох статистик үзүүлэлтүүд (тэрбум төгрөг)**

№	Үндсэн үзүүлэлтүүд	2014Q2	2015Q2	Өсөлт
1	ХЗХ-дын тоо	139	242	74%
2	Гишүүдийн тоо	27 517	35 306	28%
3	Нийт актив	76.8	85.6	11%
	Банкны салбарт эзлэх хувь	0.4%	0.4%	
4	Нийт зээлийн өрийн үлдэгдэл	61.5	70.8	15%
	Банкны салбарт эзлэх хувь	0.5%	0.6%	
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл	1.8	2.2	23%
	Банкны салбарт эзлэх хувь	0.6%	0.4%	
6	Нийт татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдэл	52.6	55.8	6%
	Банкны салбарт эзлэх хувь	1.0%	0.9%	
7	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн үлдэгдэл	10.1	10.4	3%
	Банкны салбарт эзлэх хувь			
8	Нийт хоршоологчдын өмчийн үлдэгдэл	7.1	8.7	23%
9	Банк, ББСБ, төслөөс авсан зээлийн дүн	1.3	5.8	347%
10	Нийт орлого	9.2	10.4	13%
11	Нийт зардал	7.3	9.0	24%
12	Тухайн үеийн ашиг, алдагдал	1.9	1.4	-28%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Энэхүү өсөлтөд эргэлтийн хөрөнгө тэр дундаа нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн


үетэй харьцуулахад 15.0 хувиар буюу 9.2 тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ. 2015 оны 2 дугаар улирлын эцсийн байдлаар нийт активын 16.1 хувь нь бэлэн мөнгө, 80.5 хувь нь зээл, 2.1 хувь нь авлага, 2.3 хувь нь үндсэн хөрөнгө байна.

**Зээлийн чанар**

Тайлант хугацаанд нийт зээлийн багцын 93.5 хувь нь хэвийн зээл, 3.3 хувь нь хугацаа хэтэрсэн зээл, 3.2 хувь нь чанаргүй зээл тус тус эзлэв. Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 2014 оны эцсээс 0.6 нэгж хувиар өсч 3.1 хувьд хүрчээ.

**Дүрслэл 2.29**

**Хадгаламж, зээлийн хоршоодын нийт зээл, зээлийн чанар (тэрбум төгрөг)**




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

**Өр төлбөр ба өөрийн хөрөнгө**

ХЗХ-дын өр төлбөр, өөрийн хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 8.8 тэрбум төгрөгөөр өссөн. Үүнд хадгаламжийн хэмжээ өмнөх оноос 3.2 тэрбум төгрөгөөр буюу 6.2 хувиар, өөрийн хөрөнгө 1.7 тэрбум төгрөгөөр буюу 9.8 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.

### Дүрслэл 2.30

**Хадгаламж, зээлийн хоршоодын өр төлбөр ба өөрийн хөрөнгө (тэрбум төгрөг)**



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Нийт татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ 55.8 тэрбум төгрөг байгаа бөгөөд үүний 97.6 хувь нь 12094 гишүүний хугацаатай хадгаламж байгаа бол 2.4 хувь нь 3736 гишүүний хугацаагүй хадгаламж байна.

### Ашигт ажиллагаа

ХЗХ-дын санхүүгийн үйл ажиллагаа сайжирч нийт орлогын хэмжээ өмнөх оны мөн үеэс 1.2 тэрбум төгрөгөөр буюу 13.2 хувиар өссөн боловч нийт зардлын хэмжээ 1.7 тэрбум төгрөгөөр буюу 23.8 хувиар өсч, 2015 оны 2 дугаар улирлын байдлаар ашиг 1.4 тэрбум төгрөгт хүрэв.

### ХЗХ-дын зохистой харьцааны үзүүлэлтүүд

СЗХ-ны 2014 оны 26 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон дагаж мөрдөх үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-аар тогтоосон үзүүлэлтүүд 2014 оны эцсийн байдлаар дараах байдалтай байв.

### Хүснэгт 2.7

**ХЗХ-дын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд**

Үзүүлэлт	Зохистой харьцааны шаардлагаг түвшин	2014 оны эцэс
1.Чанаргүй зээлийн зохистой харьцаа	<5%	2.5%
2.Нийт хөрөнгөд эзлэх зээлийн зохистой харьцаа	[60%, 85%]	75.0%
3.Гишүүдийн хадгамжийн зохистой харьцаа	[20%, 80%]	68.3%
4.Нэг гишүүний хувь хөрөнгийн зохистой харьцаа	10%>	0.0%
5.Хоршоологчдын өмчийн зохистой харьцаа	5%>	11.4%
6.Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа	5%<	хангасан

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Салбарын хэмжээнд зохистой харьцааны үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан байна.

### Хүснэгт 2.8

**ХЗХ-дын дагаж мөрдөх үзүүлэлтүүд**

Үзүүлэлт	Шаардлага	2014 оны эцэс
1.Нэг гишүүнд олгосон зээлийн зохистой харьцаа	<30%	0.0%
2.Нэгдмэл сонирхолтой этгээдэд олгосон зээлийн зохистой харьцаа	<30%	0.0%
3.Өмчлөх бусад хөрөнгийн зохистой харьцаа	<5%	0.8%
4.Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	<10%	2.9%
5.Бусдаас авсан зээлийн зохистой харьцаа	<20%	2.7%
6.Нөөц сангийн байвал зохих доод хэмжээ/мян.төг/	921 094	2 243 396
7.Хадгаламж хамгаалалтын сангийн байвал зохих доод хэмжээ/мян. төг/	460 547	355 987
8.Тогтворжилтын сангийн байвал зохих доод хэмжээ/мян. төг/	460 547	342 896
9.Үйл ажиллагааны зардлын зохистой харьцаа	<15%	5.2%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Харин дагаж мөрдөх үзүүлэлтүүдээс хадгаламж хамгаалалтын болон тогтворжилтын санг тогтоосон хэмжээгээр байгуулаагүй байна. ХЗХ-ны бүх гишүүдийн хурлын шийдвэрээр жилийн эцсийн цэвэр орлогоос хөрөнгө хуваарилах боломжтой байдаг бөгөөд “Хадгаламж, зээлийн хоршооны тухай” хуульд заасны дагуу ХЗХ-д нь 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор бүх гишүүдийн хурлыг хуралдуулж, 2014 оны жилийн эцсийн цэвэр орлогыг хуваарилах шийдвэр гаргаснаар дээрх дагаж мөрдөх хоёр үзүүлэлтүүдийг салбарын хэмжээгээр хангах боломжтой болох юм.

## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

## Ерөнхий төлөв байдал


Үнэт цаасны зах зээлийн хөгжлийг зах зээлийн үнэлгээ, хөрвөх чадварын түвшин, зах зээлийн үнэлгээг дотоодын нийт бүтээгдэхүүнд харьцуулсан харьцаа, нийт арилжааны хэмжээ зэрэг үзүүлэлтүүдээр голчлон хэмждэг бөгөөд дээрх үзүүлэлтүүдийн ерөнхий төлөв, хандлагаас зах зээлийн бодит нөхцөл, байдлыг тодорхойлох боломжтой байдаг.

## Зах зээлийн үнэлгээ

Үнэт цаасны зах зээлийн эдийн засагт эзлэх хувийг зах зээлийн үнэлгээ (ЗЗҮ)-гээр илэрхийлэх ба 2015 оны 2 дугаар улирлын эцсийн байдлаар ЗЗҮ 1 их наяд 408.5 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 163.8 тэрбум төгрөгөөр буюу 10.4 хувиар буурсан үзүүлэлт боллоо.

## Дүрслэл 2.31

ТОП-20 индекс болон зах зээлийн үнэлгээ



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Зах зээлийн үнэлгээ буурахад эдийн засгийн өсөлт удааширсан, уул уурхайн салбарын компанийн хувьцааны үнэ ханш дотоодын болон олон улсын хөрөнгийн бирж дээр огцом буурсан, гадаадын хөрөнгө оруулагчдын үнэт цаасны зах зээлд хөрөнгө

оруулах сонирхол 2012 оноос хойш эрс буурсан, зах зээлийн дэд бүтэц сул зэрэг нь голчлон нөлөө үзүүлжээ.

Тайлант хугацаанд ТОП-20 индексийн дээд үзүүлэлт 15737.2 нэгж, доод үзүүлэлт 12981.9 нэгж, дундаж үзүүлэлт 14591.2 нэгж байв. ТОП-20 индексийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 665.3 нэгжээр буюу 4.4 хувиар буурсан байна.

## Зах зээлийн хөрвөх чадвар


Зах зээлийн хөрвөх чадвар нь үнэт цаасны зах зээлийн хөрөнгийн эргэц буюу хурдыг илэрхийлэгч суурь үзүүлэлт юм. “МХБ” ХК дээр арилжаалагдсан хувьцааны үнийн дүнг тухайн хугацааны ЗЗҮ-нд харьцуулж, хувиар тооцоход 2015 оны 2 дугаар улирлын байдлаар зах зээлийн хөрвөх чадварын үзүүлэлт 0.21 нэгж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс даруй 0.2 нэгжээр өссөн үзүүлэлттэй байна. Хөгжингүй зах зээлтэй орнуудын хувьд дээрх үзүүлэлт 0.8-0.9 нэгж байдаг ба манай орны хувьд 0.02-0.21 нэгжийн хооронд хэлбэлзэж байгаа нь үнэт цаасны зах зээл эргэц зогсонги байгааг илтгэж байна. Хөрвөх чадварын түвшинг бага байхад голчлон хөрөнгийн биржид бүртгэлттэй хувьцаат компаниудын хяналтын багц цөөн тооны хөрөнгө оруулагчдын гарт төвлөрсөн, нийт бүртгэлтэй компаниудын дийлэнх нь 75 хувиас дээш төвлөрөлтэй, нэмж үнэт цаас гаргах сонирхол бага, гадаад, дотоодын томоохон мэргэжлийн хөрөнгө оруулагч байхгүй, тэдгээрийн эрэлт хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл дутмаг, хөрөнгийн бирж дээр маркет мэйкерийн зуучлалын тогтолцоо хөгжөөгүй нь суурь нөлөө

үзүүлжээ. Мөн мэргэжлийн зуучлагч байгууллагуудын санхүүгийн болон хүний нөөцийн чадавхи сул, маржин арилжаа буюу зээлээр үнэт цаас худалдан авах үйлчилгээний төрөл хөгжөөгүй байгаа, иргэдийн үнэт цаасны зах зээлийн талаарх мэдлэг, мэдээлэл хомсоос шалтгаалан хувьцаа худалдан авахаас илүүтэйгээр банкинд мөнгөө байршуулах сонирхол өндөр, хувьцаат компаниудын засаглалд итгэх итгэл сул байгаа зэрэг нь хөрвөх чадварын түвшинг бага байхад давхар нөлөөлжээ.

26.8 хувийг эзэлжээ. Мөн нэг удаагийн тендер саналын арилжаа явагдаж, 202 ширхэг хувьцааг 711.4 мянган төгрөгөөр арилжсан байна.

### Дүрслэл 2.32

Хөрвөх чадвар, хувьцааны арилжааны үнийн дүн



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

### Үнэт цаасны арилжааны үзүүлэлтүүд

2015 оны эхний хагас жилд хувьцааны анхдагч зах зээл дээр 112 сая төгрөг, хоёрдогч зах зээлд 5.7 тэрбум төгрөг, ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр 283.4 тэрбум төгрөг, хоёрдогч зах зээлд 1.5 тэрбум төгрөгийн арилжаа явагдаж, нийт 290.6 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдсэн. ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжааны 89.1 хувийг 12 долоо хоногтой, 5.6 хувийг 28 долоо хоногтой, 5.3 хувийг 52 долоо хоногтой, 0.01 хувийг 3 болон 5 жилийн урт хугацаатай үнэт цаас тус тус эзлэв. Тус хугацаанд 13 удаагийн багцын арилжаагаар нийт 13 компанийн 11.1 сая ширхэг хувьцааг 1.5 тэрбум төгрөгөөр арилжсан нь нийт арилжааны үнийн дүнгийн

**Үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийн үзүүлэлтүүд**

**Бүртгэлтэй компани**


2015 оны 2 дугаар улирлын эцсийн байдлаар СЗХ-нд 303 компани бүртгэлтэй байгаагаас, төрийн өмчийн оролцоотой 11, төрийн өмчит 32, хувийн өмчит 245, орон нутгийн оролцоотой 15 компани байна.

Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувийн өмчит компаниудын дийлэнх нь өмч хувьчлалаар үүсэн бий болсноос үүдэн компанийн хувьцааны хяналтын багц цөөн тооны нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн гарт төвлөрсөн нь зах зээл дэх нийлүүлэлтэд сөргөөр нөлөөлж ирэв.

Хувьцаат компанийн хяналтын багц цөөн тооны хөрөнгө оруулагчдын гарт төвлөрсөн нь компанийн засаглал сул, дотоод мэдээлэл эзэмшигч этгээд үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулах сонирхлыг бууруулж, зах зээлийн хөрвөх чадварыг бууруулах үндсэн шалтгаан болж байна.

**Дүрслэл 2.33**

**Хувьцаат компанийн төвлөрөл (2014 оны эцсийн байдлаар)**



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.


2014 оны эцсийн байдлаар нийт бүртгэлтэй 303 компанийн 193 нь 75 ба түүнээс дээш

хувийн төвлөрөлтэй байжээ. Төвлөрлийн хэмжээ өндөр байх нь жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг зөрчигдөх, компанийн засаглалыг сул байлгах нөхцөлийг бий болгож байгаа юм.

Олон улсын туршлагаас үзэхэд компанийн засаглалыг хувьцаа эзэмшигчдийн хурлаа хуралдуулсан, хараат бус төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээ сонгосон болон санхүүгийн тайлангаа төрийн эрх бүхий байгууллага, олон нийтэд мэдээлсэн байдал, ногдол ашиг тараалт, нийгмийн хариуцлага гэсэн үзүүлэлтүүдээр голчлон авч үздэг.

**Дүрслэл 2.34**

**Бүртгэлтэй хувьцаат компанийн тоо, тэдгээрийн хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилт**



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Тэмдэглэл: \*2015 оны 2 дугаар улирлын байдлаар.

2010 онд Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбоотойгоор СЗХ-ны зүгээс компанийн засаглалыг сайжруулах чиглэлээр тодорхой зохицуулалтын эрх зүйн орчинг бүрдүүлж байгаа хэдий ч, хувийн өмчит хувьцаат компанийн дийлэнх хувь нь 75 буюу түүнээс дээш хувийн төвлөрөлтэй, хяналтын багц цөөн тооны нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн гарт төвлөрсөн байгаа өнөөгийн нөхцөлд хувьцаа эзэмшигчдийн

хурал нэр төдий хуралдах, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг зөрчигдөх, ТУЗ-ийн хараат бус гишүүнийг нэр төдий сонгох, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийж компанийн өмч хөрөнгийг үрэгдүүлэх явдал хэвээр байна.

**Зах зээлийн дэд бүтэц**

2015 оны 2 дугаар улирлын эцсийн байдлаар Хорооноос олгосон тусгай зөвшөөрөл бүхий үйл ажиллагаа явуулж буй арилжаа эрхлэх 1, төлбөр, тооцоо, хадгаламжийн 1, брокер 61,

дилерийн 59 компани, Засгийн газрын үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлд харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар хөрөнгө оруулалтын ажил үйлчилгээ эрхлэх 10, мөнгөн хөрөнгийн төлбөр гүйцэтгэх 5, хөрөнгө оруулалтын менежментийн 3 компани, давхардсан тоогоор андеррайтерийн тусгай зөвшөөрөлтэй 25, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх 16, кастодиан үйлчилгээ үзүүлэх арилжааны 3 банк байна.

**Үнэт цаасны зах зээлийн төлбөр, тооцооны үзүүлэлтүүд**

2015 оны 2 дугаар улирлын байдлаар төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн дансаар 389 харилцагчийн 1666 удаагийн нийт 1.4 их наяд төгрөгийн орлого, 2369 харилцагчийн 4304 удаагийн нийт 2.9 их наяд төгрөгийн зарлагын гүйлгээ хийгджээ.

Тайлант хугацаанд “ҮЦТТХТ” ХХК-иар дамжин төлбөр тооцоо гүйцэтгэгч арилжааны 4 банк хооронд нийт 3.0 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдсэнээс “Голомт банк” 1.1 тэрбум, “Худалдаа хөгжлийн банк” 0.7 тэрбум, “Хас банк” 1.1 тэрбум, “ХААН банк” 0.05 тэрбум төгрөгийн гүйлгээг тус тус хийжээ.

**Дүрслэл 2.35**

**Арилжааны төлбөр тооцоо**



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Тус хугацаанд төвлөрсөн хадгаламжид шинээр нийт 6842 данс нээгдсэнээс, дотоодын иргэн 6803, гадаадын иргэн 22, дотоодын аж ахуй нэгж 16, гадаадын аж ахуйн нэгжүүд 1 данс нээлгэсэн байна. 2012 оноос үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид нээгдсэн дансны тоо эрс өссөн нь төрөөс “Эрдэнэс таван толгой” ХК-ийн 1072 ширхэг хувьцааг үнэ төлбөргүйгээр эзэмшүүлэх шийдвэр голлон нөлөөлсөн.

**Хүснэгт 2.9**

**Хөрөнгө оруулагчдын арилжаанд эзлэх хувь**

Он	Нийт хувьцааны гүйлгээний дүн (тэрбум төгрөг)	Нийт арилжаанд эзлэх хувь	
		Гадаад	Дотоод
2006	18.0	27%	73%
2007	102.5	38%	63%
2008	62.3	24%	76%
2009	23.2	32%	68%
2010	92.8	62%	38%
2011	109.1	24%	76%
2012	144.7	92%	8%
2013	97.6	12%	88%
2014	60.4	9%	91%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

2014 онд арилжааны үнийн дүнд гадаадын иргэд, аж ахуйн нэгжийн эзлэх хувь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад буурсан

бөгөөд дараах хүчин зүйлс нөлөөлсөн гэж үзэж байна. Үүнд:

- ◆ Эдийн засгийн нөхцөл байдал тааруу, гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин тодорхойгүйгээс гадаадын болон дотоодын биржид бүртгэлтэй уул уурхайн компаниудын хувьцааны үнэ, ханш унасан;
- ◆ Шинэ системтэй уялдан арилжааны банкинд үнэт цаасны мөнгөн төлбөр тооцооны данс нээх, түүний гүйцэтгэлийн ажилбаруудыг гүйцэтгэхэд аль аль талдаа чирэгдэл үүссэн;

- ◆ Гадаадын хөрөнгө оруулагчдын хэрэгцээ, шаардлагад нийцсэн, тэдгээрийн өмчлөх эрхийг нь баталгаажуулах, эрхээ хэрэгжүүлэх үндсэн хэрэгсэл болох кастодиан банкны үйлчилгээ зах зээлд хараахан нэвтрээгүй, хөрөнгө оруулалтын сангууд үүсэн бий болоогүй;
- ◆ Зах зээлд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлүүлэлт дутмаг, хөрвөх чадварын түвшин доогуур байгаа зэрэг нь нөлөө үзүүлж байна.

## ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГА

### Даатгалын салбарын ерөнхий мэдээлэл

#### Ерөнхий төлөв байдал

2015 оны 2 дугаар улирлын эцсийн байдлаар даатгалын зах зээл дээр 15 ердийн болон 1 урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг компани, 3210 даатгалын төлөөлөгч, 33 даатгалын зуучлагч компани, 21 даатгалын хохирол үнэлэгч компани, 15 актуарч, нийт 3296 тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчид үйл ажиллагаа явуулж байна.

#### Хүснэгт 2.10

Даатгалын салбарын тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн тоо

Үзүүлэлт	2012	2013	2014	2015H1
Даатгагч	18	17	17	16
Даатгалын төлөөлөгч	2 357	3 178	3 260	3 210
Даатгалын зуучлагч	17	20	30	33
Даатгалын хохирол үнэлэгч	9	14	20	21
Актуарч	18	15	15	15
<b>Дүн</b>	<b>2 419</b>	<b>3 244</b>	<b>3 342</b>	<b>3 296</b>


Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

#### Даатгагчийн хөрөнгө

2015 оны 2 дугаар улирлын байдлаар даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй даатгалын компанийн нийт хөрөнгийн хэмжээ 170.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 33.9 тэрбум төгрөгөөр буюу 24.8 хувиар өссөн.

#### Дүрслэл 2.36

Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ



Үзүүлэлтүүд	2013		2014		Өсөлт/бууралт	
	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
Эргэлтийн хөрөнгө	109.6	83%	125.7	82%	16.1	14.7%
Эргэлтийн бус хөрөнгө	16.8	17%	26.8	18%	10.0	59.5%
<b>Нийт хөрөнгө</b>	<b>126.4</b>	<b>100%</b>	<b>152.5</b>	<b>100%</b>	<b>26.1</b>	<b>20.6%</b>

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Сүүлийн 5 жилд даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй нийт компаниудын хөрөнгийн хэмжээ 2.7 дахин нэмэгдсэн бол урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхэлж буй цор ганц компани болох “Нэйшнл лайф даатгал” ХХК-ны хөрөнгийн хэмжээ 5.7 дахин тус тус нэмэгдсэн дүнтэй байна. 2014 оны 4 дүгээр улиралд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан ердийн болон урт хугацааны даатгалын



компаниудыг нийт хөрөнгийн хэмжээгээр нь жагсаахад эхний нэг компани 21.4 хувийн, эхний гурван компани 37.2 хувийн тус тус төвлөрөлтэй байв.

### Хүснэгт 2.11

Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ (2014 оны IV улирлын байдлаар, тэрбум төгрөг)

№	Даатгалын компаниуд	Нийт хөрөнгийн хэмжээ	Эзлэх хувь
1	Монгол даатгал ХХК	32.7	21.4%
2	Бодь даатгал ХХК	12.7	8.4%
3	Тэнгэр даатгал ХХК	11.3	7.4%
4	Миг даатгал ХХК	10.3	6.8%
5	Мандал женерал даатгал ХХК	9.4	6.1%
6	Соёмбо даатгал ХХК	9.0	5.9%
7	Ард даатгал ХХК	8.7	5.7%
8	Практикал даатгал ХХК	8.3	5.4%
9	Номин даатгал ХХК	7.6	5.0%
10	Нэйшнл лайф даатгал ХХК	6.5	4.3%
11	Хаан даатгал ХХК	6.4	4.2%
12	Монре даатгал ХХК	5.6	3.7%
13	Моннис даатгал ХХК	5.5	3.6%
14	УБ хотын даатгал ХХК	5.2	3.4%
15	Ган зам даатгал ХХК	5.1	3.3%
16	Мөнх даатгал ХХК	4.3	2.8%
17	Гэр даатгал ХХК	3.9	2.6%
Дүн		152.5	100.0%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

2014 оны 4 дүгээр улирлын байдлаар даатгалын компаниудын эргэлтийн хөрөнгийг бүтцээр нь авч үзвэл мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн хэмжээ 75.5 тэрбум төгрөг ба нийт эргэлтийн хөрөнгийн 60.1 хувь, богино хугацаат хөрөнгө оруулалт 26.1 тэрбум төгрөг буюу нийт эргэлтийн хөрөнгийн 20.8 хувь, дансны авлага 20.8 тэрбум төгрөг буюу нийт эргэлтийн хөрөнгийн 16.6 хувийг, бусад эргэлтийн хөрөнгө 3.2 тэрбум буюу нийт эргэлтийн хөрөнгийн 2.6 хувийг тус тус эзэлж байна. Өмнөх оны мөн үеэс богино хугацаат хөрөнгө оруулалт 10.9 тэрбум төгрөгөөр буюу 72 хувиар өссөн нь эргэлтийн хөрөнгийн хэмжээ 15 хувиар өсөхөд голлон тайлбарлаж байна.

### Хүснэгт 2.12

Даатгалын компаниудын эргэлтийн хөрөнгө (тэрбум төгрөг)

Үзүүлэлтүүд	2013		2014		Өөрчлөлт	
	дүн	хувь	дүн	хувь	дүн	хувь
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	74.8	68%	75.5	60%	0.7	1%
Богино хугацаат хөрөнгө оруулалт	15.2	14%	26.1	21%	10.9	72%
Дансны авлага	16.6	15%	20.8	17%	4.2	26%
Бусад эргэлтийн хөрөнгө	3.0	3%	3.2	3%	0.2	8%
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>109.6</b>	<b>100%</b>	<b>125.7</b>	<b>100%</b>	<b>16.1</b>	<b>15%</b>


Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

### Даатгагчийн өр төлбөр ба эзэмшигчдийн өмч

Даатгалын нөөц сан нийт өр төлбөр эзэмшигчдийн өмчид 2012 оны 4 дүгээр улиралд 44.8 хувь, 2013 оны 4 дүгээр улиралд 46.5 хувь, 2014 оны мөн үед 43.3 хувь байгаа нь даатгалын компаниудын нөөц сан буурах хандлагатай байгааг харуулж байна.

### Дүрслэл 2.37

Даатгалын компаниудын өр төлбөр, эзэмшигчдийн өмч



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Эзэмшигчдийн өмчийн дүн сүүлийн 5 жилд тогтвортой өсч, 2014 оны эцэст өнгөрсөн оны мөн үеийнхээс 13.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь даатгалын компаниудын цэвэр ашгийн өсөлттэй холбоотой байлаа.

### Даатгалын хураамжийн орлого

Даатгалын салбарын нийт хураамжийн орлогын хэмжээ 2015 оны 2 дугаар улирлын байдлаар 65.9 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 1.2 дахин өслөө.

2014 онд ердийн даатгалын компаниуд 107.3 тэрбум төгрөгийн, урт хугацааны даатгалын компани 1.4 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлого тус тус төвлөрүүлсэн байна.

### Хүснэгт 2.13

#### Даатгалын хураамжийн орлого, бүтээгдэхүүнээр (сая төгрөг)

№	Даатгалын хэлбэр	2013	2014	Өөрчлөлт (хувиар)
		Даатгалын хураамжийн орлого		
1	Хөрөнгийн даатгал	26	32	26%
2	Авто тээвэр хэрэгслийн даатгал	16	18	12%
3	Ачааны даатгал	2	3	76%
4	Мал амьтдын даатгал	1	1	16%
5	Агаарын хөлгийн даатгал	7	6	-8%
6	Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	9	10	11%
7	Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	3	0	-87%
8	Хариуцлагын даатгал	7	6	-16%
9	Санхүүгийн даатгал	3	3	27%
10	Барилга угсралтын даатгал	4	1	-65%
11	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	12	20	64%
12	Хугацаат амьдралын даатгал	0	0	-29%
13	Эрүүл мэндийн даатгал	0	1	108%
14	Хуримтлалын даатгал	0	0	-2%
15	Итгэлцлийн даатгал	0	0	-
16	Тэтгэврийн даатгал	0	0	7%
17	Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	1	2	221%
18	Зээлийн даатгал	2	3	24%
	<b>Дүн</b>	<b>94</b>	<b>109</b>	<b>16%</b>

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

2005 оноос 2014 он хүртэлх хугацаанд нийт хураамжийн орлого 99.2 тэрбум төгрөгөөр ялангуяа 2012 оноос эхлэн огцом өссөн байна. Үүнд 2012 онд “Жолоочийн даатгалын тухай хууль” батлагдаж, хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор албан журмаар даатгуулах даатгуулагчдын тоо нэмэгдэж, мөн түүнчлэн албан журмын даатгалын өсөлтийг дагаж авто тээврийн хэрэгслийн даатгал өндөр өсөлттэй гарсан нь голлон нөлөөлжээ.

### Даатгалын нөхөн төлбөр

2014 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт 31.5 тэрбум төгрөгийн даатгалын нөхөн төлбөр олгосон.

### Хүснэгт 2.14

#### Даатгалын нөхөн төлбөр (сая төгрөг)

№	Даатгалын хэлбэр	2013	2014	Өөрчлөлт (хувиар)
		Даатгалын нийт нөхөн төлбөр		
1	Хөрөнгийн даатгал	2	2	-10%
2	Авто тээвэр хэрэгслийн даатгал	7	8	8%
3	Ачааны даатгал	0	0	-32%
4	Мал амьтдын даатгал	0	0	-
5	Агаарын хөлгийн даатгал	0	0	-
6	Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	2	3	50%
7	Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	2	0	-93%
8	Хариуцлагын даатгал	0	1	91%
9	Санхүүгийн даатгал	1	1	-29%
10	Барилга угсралтын даатгал	0	0	-22%
11	Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал	8	12	47%
12	Хугацаат амьдралын даатгал	0	0	38%
13	Эрүүл мэндийн даатгал	0	0	238%
14	Хуримтлалын даатгал	0	0	26%
15	Тэтгэврийн даатгал	0	0	-
16	Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал		0	-
17	Зээлийн даатгал	2	3	75%
	<b>Дүн</b>	<b>26</b>	<b>31</b>	<b>19%</b>

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Гадаадын болон хамтарсан хөрөнгө оруулалттай компанийн олгосон даатгалын нөхөн төлбөр нийт нөхөн төлбөрийн 39.2 хувийг эзэлж байна. 2014 оны эцэст даатгалын нөхөн төлбөрийг авч үзэхэд өмнөх оны мөн үеэс гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал 1.5 дахин, хөрөнгийн даатгал 1.3 дахин, автотээврийн хэрэгслийн даатгал 1.1 дахин, агаарын хөлгийн даатгал 12.3 дахин, хариуцлагын даатгал 1.9 дахин, жолоочийн хариуцлагын албан журмын даатгал 2.2 дахин, зээлийн даатгал 1.8 дахин, хугацаат амьдралын даатгал 1.3 дахин, хуримтлалын даатгал 5.7 дахин, тэтгэврийн даатгал 3.38 дахин тус тус өсч, бусад хэлбэрийн даатгалын хувьд нөхөн төлбөр буурчээ.


2014 онд итгэлцлийн даатгал, төмөр зам болон усан замын тээврийн хэрэгслийн даатгалын хэлбэрээр нөхөн төлбөр олгогдоогүй байна.

### Даатгалын хохирлын харьцаа

2014 оны 4 дүгээр улирлын байдлаар даатгалын хохирлын харьцаа салбарын дүнгээр 43.0 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 1.0 нэгж хувиар нэмэгдэв.

#### Дүрслэл 2.38

Даатгалын компаниудын хохирлын харьцаа ба ашигт ажиллагаа



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Даатгалын компаниудын хохирлын харьцааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10 компанийн үзүүлэлт өсч, 6 компанийн үзүүлэлт буурчээ. Хамгийн өндөр хохирлын харьцаатай буюу “Практикал даатгал” ХХК, “Миг даатгал” ХХК, “Монре даатгал” ХХК, “Номин даатгал” ХХК-иуд тус тус 50-60 хувийн үзүүлэлттэй байв. Харин “Моннис даатгал” ХХК, “Ган зам даатгал” ХХК, “Хаан даатгал” ХХК-иудын хохирлын харьцаа 20.0 хувь хүрэхгүй түвшинд байна.

2014 оны 4 дүгээр улирлын байдлаар даатгалын компаниуд салбарын хэмжээнд 2.0 тэрбум төгрөгийн ашигтай ажиллав. Тус хугацаанд “Мандал генерал даатгал” ХХК 242.7 сая төгрөг, “Монгол даатгал” ХХК 1244.8 сая төгрөг, “Номин даатгал” ХХК


235.8 сая төгрөгийн тус тус алдагдалтай ажилласан нь нийт даатгалын салбарын хуримтлагдсан ашиг бууруулахад нөлөөлөв.

### Давхар даатгал

2014 оны 4 дүгээр улирлын байдлаар 31.6 тэрбум төгрөгийн давхар даатгалын хураамжийг гадаадын давхар даатгалын компанид шилжүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.6 тэрбум төгрөгөөр өссөн дүнтэй байлаа.

#### Дүрслэл 2.39

Давхар даатгалын хураамж (тэрбум төгрөг)



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Давхар даатгалын хураамжийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.2 дахин нэмэгдсэн байна. Давхар даатгалын хураамж сүүлийн дөрвөн жилд өсөх хандлагатай байна.

“Монгол даатгал” ХХК, “Бодь даатгал” ХХК, “Практикал даатгал” ХХК, “Монре даатгал” ХХК, “Монгол даатгал” ХХК, “Номин даатгал” ХХК-иудын давхар даатгалын хураамж өмнөх оны мөн үеэс өсч, бусад даатгагчийн хувьд буурчээ.

**Хүснэгт 2.15****Давхар даатгалын хураамж (сая төгрөг)**

№	Компанийн нэр	2013	2014	Өөрчлөлт (хувиар)
1	Ард даатгал ХХК	4 234	1 816	-57%
2	Бодь даатгал ХХК	3 309	9 437	185%
3	Тэнгэр даатгал ХХК	3 100	1 048	-66%
4	Практикал даатгал ХХК	170	209	23%
5	Миг даатгал ХХК	3 162	2 046	-35%
6	Монгол даатгал ХХК	6 388	10 583	66%
7	Номин даатгал ХХК	129	271	110%
8	Нэйшнл лайф даатгал ХХК	65	22	-67%
9	Мандал генерал даатгал ХХК	3 740	4 421	18%
10	Соёмбо даатгал ХХК	316		
11	Моннис даатгал ХХК	1 248	997	-20%
12	Хаан даатгал ХХК	-	129	-
13	Монре даатгал ХХК	120	210	74%
<b>Дүн</b>		<b>25 980</b>	<b>31 578</b>	<b>22%</b>

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

**Албан журмын даатгал**

Монгол Улсад албан журмын даатгалын үйл ажиллагааг нийслэлд даатгалын 16 компани, орон нутагт даатгалын компанийн 213 салбар, даатгалын 2357 төлөөлөгч эрхлэн явуулж байна.

**Хураамж ба нөхөн төлбөр**

Монгол улсад авто тээврийн хэрэгсэл болон жолоочийн тоо жилээс жилд өсч, замын хөдөлгөөний нягтрал, тээврийн ослын тоо, иргэдэд учрах хохирлын хэмжээ нэмэгдсээр байна. Хариуцлагын даатгалын суурь амжилттай тавигдсанаар тээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигч нь даатгалтай эсэхээс үл хамааран зам, тээврийн осолд өртсөн гуравдагч этгээд буюу амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирсон иргэд, байгууллагуудад нөхөн төлбөр олгож, хохирлыг барагдуулахын зэрэгцээ иргэдийн даатгалын талаарх мэдлэгийг дээшлүүлэхэд үр дүнтэй нөлөөлж байна.

2014 оны 4 дүгээр улирлын байдлаар жолоочийн даатгалаар нийт 20.1 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлого төвлөрч, 2013 оны мөн үеэс 4.9 тэрбум төгрөгөөр өсчээ.

2014 онд жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын 418.9 мянган гэрээ байгуулагдсан ба албан журмын даатгалын нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо 28.0 мянгад хүрсэн.

**Хүснэгт 2.16****Жолоочийн даатгалын хураамж, нөхөн төлбөрийн хэмжээ (сая төгрөг)**

№	Даатгалын компаниуд	Даатгалын гэрээний тоо	Жолоочийн даатгалын хураамж	Олгосон нөхөн олговор	Нөхөн төлбөр авсан тоо
1	Ард даатгал ХХК	47 064	2 049	1 305	3 178
2	Бодь даатгал ХХК	88 959	3 414	2 166	4 239
3	Ган зам даатгал ХХК	832	35	27	
4	Гэр даатгал ХХК	646	32	50	123
5	Мандал генерал даатгал ХХК	13 622	593	426	923
6	МИГ даатгал ХХК	73 665	2 937	1 300	4 025
7	Монгол даатгал ХХК	67 226	3 659	2 328	5 398
8	Моннис даатгал ХХК	400	32	2	5
9	Монре даатгал ХХК	30 721	1 301	750	1 503
10	Мөнх даатгал ХХК	2 243	77	132	340
11	Номин даатгал ХХК	71	1 663	1 328	2 939
13	Практикал даатгал ХХК	36 577	1 371	1 095	2 050
14	Соёмбо даатгал ХХК	9 764	1 058	542	1 231
15	Тэнгэр даатгал ХХК	33 768	1 419	786	1 746
16	УБ хотын даатгал ХХК	162	27	2	8
17	Хаан даатгал ХХК	13 101	423	136	297
<b>Нийт</b>		<b>418 861</b>	<b>20 089</b>	<b>12 373</b>	<b>28 034</b>

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

### Даатгалын мэргэжлийн оролцогч

#### Даатгалын зуучлагч

2014 оны 4 дүгээр улиралд нийт 32 даатгалын зуучлагч компани үйл ажиллагаа явуулж, тайлангаа ирүүлжээ.

Мөн үед даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд нийт 3202.2 сая төгрөгийн даатгалын зуучлалын үйл ажиллагааны орлого төвлөрүүлсэн бөгөөд өмнөх оны мөн үеэс 2.3 дахин өссөн.

#### Хүснэгт 2.17

##### Компаниудын үйл ажиллагааны орлого (сая төгрөг)

№	Компанийн нэр	2013	2014	Өөрчлөлт (хувиар)
1	"Асимон брокерс" ХХК	141.0	130.0	-8%
2	"Аме" ХХК	213.1	68.1	-68%
3	"Ачит ундарга" ХХК	43.0	118.5	176%
4	"Ариг банк" ХХК		12.3	-
5	"Ваясню Соллошн" ХХК		13.0	-
6	"Гэрэлт буян ундрах" ХХК	61.2	47.9	-22%
7	"Дэвжих дэлгэрэх холдинг" ХХК		1.3	-
8	"Капитал банк" ХХК		17.0	-
9	"Лояли соллошн" ХХК	48.8	263.4	440%
10	"Нэйшнл эженси" ХХК	32.8	37.5	14%
11	"Пийс оф лайф" ХХК	0.3	0.0	-100%
12	"Ренессанс групп" ХХК	66.4	51.3	-23%
13	"Си эн эн икс" ХХК	201.2	195.4	-3%
14	"Соёмбо Ай Би" ХХК		4.9	-
15	"Сүрэг хараацай" ХХК		108.2	-
16	"Төрийн банк" ХХК		180.2	-
17	"Хаан банк" ХХК	93.0	662.2	612%
18	"Хас банк" ХХК	19.4	70.7	264%
19	"Худалдаа хөгжлийн банк" ХХК		52.1	-
20	"Хүннү сизл" ХХК		16.7	-
21	"Эй эс ай би" ХХК		0.4	-
22	"Эрсдийн шийдэл" ХХК	487.9	1151.3	136%
23	"Эс ай би эс" ХХК		0.1	-
	<b>Дүн</b>	<b>1408.1</b>	<b>3202.5</b>	<b>127%</b>

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

#### Даатгалын хохирол үнэлэгч

2014 онд даатгалын хохирол үнэлэгч компаниудын хохирол үнэлгээний орлого 637.7 сая төгрөг болжээ. 2014 оны 4 дүгээр улирлын байдлаар даатгалын хохирол үнэлгээний орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад “Арга билэг эстимэйт” ХХК

11.8 дахин, “Ашид билгүүн” ХХК 2.8 дахин, “Файн эстимэйт” ХХК 1.5 дахин, “Вендо” ХХК 1.2 тус тус нэмэгджээ.

#### Хүснэгт 2.18

##### Компаниудын хохирол үнэлгээний орлого (сая төгрөг)

№	Компанийн нэр	2013	2014	Өөрчлөлт (хувиар)
1	"Арвижих эстимэйт" ХХК	39.3	35.05	-11%
2	"Арга билэг эстимэйт" ХХК	0.1	1.18	1080%
3	"Ашид билгүүн" ХХК	79.2	223.36	182%
4	"Бэст эстимэйт" ХХК	35.3	15.86	-55%
5	"Вендо" ХХК	100.5	116.45	16%
6	"Гэрэг эстимэйт" ХХК	101.7	86.32	-15%
7	"Жи ай си си" ХХК	37	15.31	-59%
8	"Игэлт эстимэйт" ХХК	53.3	54.04	1%
9	"Капитал" ХХК		0.1	-
10	"Лэндс" ХХК		13.53	-
11	"Мастер үнэлгээ" ХХК		9.57	-
12	"Мега марз" ХХК	10.2	10.39	2%
13	"Сэлэнгэ эстимэйт" ХХК		21.7	-
14	"Тэгш сонголт" эстимэйт ХХК	0	1.46	-
15	"Ухаашүрт консалтинг" ХХК		7.43	-
16	"Файн эстимэйт" ХХК	3.4	5.23	54%
17	"Фэйр валлошн" ХХК		13.86	-
18	"Хос стандарт" ХХК		6	-
19	"Хөрөнгийн үнэлгээний төв" ХХК	1	0.92	-8%
20	"Юу энд Эн" ХХК	0.5	0	-100%
	<b>Дүн</b>	<b>461.5</b>	<b>637.8</b>	<b>38%</b>

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

## ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА


Зээлийн батлан даалтын сан нь эргэлтийн хөрөнгийн, хөрөнгө оруулалтын, бичил зээлийн гэсэн 3 төрлөөр батлан даалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд нэг удаа гаргах батлан даалтын дээд хэмжээ нь 250.0 сая төгрөг байна. 2015 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 364 аж ахуй нэгж байгууллага, иргэдийн 59.6 тэрбум төгрөгийн зээлэнд 24.4 тэрбум төгрөгийн батлан даалтыг гаргах шийдвэр гаргасан байна. Сангаас гаргасан батлан даалтын дээд хэмжээ 250 сая төгрөг, доод хэмжээ 600 мянган төгрөг байв.

Зээлийн батлан даалтын сан нь 10 банк, 6 банк бус санхүүгийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байгаагаас 8 банкаар дамжуулан батлан даалтын үйлчилгээг хүргэсэн. Нийт гаргасан батлан даалтын 25.5 хувийг Голомт банк, 21.2 хувийг Хас банк, 13.2 хувийг Хаан банкны зээлэнд тус тус гаргасан бөгөөд банкнаас олгосон дундаж зээлийн хэмжээ 164 сая төгрөг бол дунджаар зээлийн дүнгийн 48 хувьд нь батлан даалт гаргасан.

Тус сан нь цаашид харилцагч банк, санхүүгийн байгууллагуудын тоог нэмэгдүүлэх, бусад төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах зэргээр зээлийн батлан даалтын үйлчилгээг илүү өргөн хүрээнд үзүүлэх, ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг гадаад улсын байгууллагуудын туршлагыг судалж Монгол Улсын зээлийн батлан даалтын тогтолцоог олон улсын жишигт ойртуулах чиглэлээр ажиллаж байна.

## Дүрслэл 2.40

Батлан даалт гаргасан байдал болон гаргуулсан ААН, иргэдийн үйл ажиллагааны чиглэл (сая төгрөг)



■ Батлан даалтын хэмжээ

№	Үйл ажиллагааны төрөл	Батлан даалтын тоо	Зээлийн хэмжээ	Батлан даалтын хэмжээ
1	ХАА-н үйлдвэрлэл	41	5112	2487
2	Үйлчилгээ	36	4144	1665
3	Үйлдвэрлэл	140	24501	10401
4	Худалдаа	54	9208	3880
	<b>Нийт</b>	<b>271</b>	<b>42964</b>	<b>18434</b>

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

**ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ БА ТҮҮХИЙ ЭДИЙН АРИЛЖАА**

Хөдөө аж ахуйн бирж ТӨХХК нь 2013 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр анхны арилжаагаа эхлүүлснээс хойш 2015 оны эхний хагас жилийн эцсийн байдлаар өссөн дүнгээр нийт 1.2 их наяд төгрөгийн арилжааг хийгээд байна.

**Хүснэгт 2.19**

**Хөдөө аж ахуйн бирж дээрх түүхий эдийн арилжааны үнийн дүн**

Барааны нэр	2014		2015Н1	
	Барааны хэмжээ/тонн/	Арилжааны дүн/тэрбум төгрөг/	Барааны хэмжээ/тонн/	Арилжааны дүн/тэрбум төгрөг/
Ямааны ноолуур	6 123.7	488.2	4 755	271.3
Хонины ноос	8 659.2	18.6	4 236	6.7
Тосны ургамал	12 535.0	10.0		
Ямааны завод ноос	1 546.2	36.1	914	18.9
Мал	12.0	0.0		
Завод ноос/тэмээ, хонины/	902.3	1.1	469.0	0.6
Хүнсний буудай			554.0	0.3
Тэмээний ноос			53.0	0.0
<b>Дүн</b>	<b>29 778</b>	<b>554</b>	<b>10 981</b>	<b>298</b>

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо.

Тус бирж нь 2015 оны 2 дугаар улирлын эцсийн байдлаар нийт 94 удаагийн арилжаа зохион байгуулж 4755 тонн ноолуур, 53 тонн тэмээний ноос, 4236 тонн хонины ноос, 914 тонн ямааны завод ноос, 469 тонн завод ноос /хонь тэмээний/, 554 тонн хүнсний буудай тус тус арилжиж нийт 298.1 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн.

**Активын бүтэц**

ХААБ-ийн нийт хөрөнгө 2014 оны жилийн эцсийн байдлаар 8.0 тэрбум төгрөгт хүрсэн ба үүний 95 хувийг эргэлтийн хөрөнгө, 5 хувийг эргэлтийн бус хөрөнгө тус тус эзэлжээ. Харин мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө 4.0 тэрбум төгрөг, дансны авлага 3.0 тэрбум төгрөг, бусад эргэлтийн хөрөнгө 0.9 тэрбум төгрөг тус тус байгаа нь нийт хөрөнгийн харгалзан 51 хувь, 37 хувь, 0.1 хувийг тус тус эзэлж байгаа юм.

**Пассивын бүтэц**

2014 оны эцсийн байдлаар нийт пассивт эзлэх богино хугацаат өр төлбөр 0.3 тэрбум төгрөг буюу 5 хувь, эзэмшигчдийн өмч 95 хувь байгаа бөгөөд үүнээс хувь нийлүүлсэн хөрөнгө 7.4 тэрбум төгрөг буюу 92 хувь, хуримтлагдсан ашиг 0.1 тэрбум төгрөг буюу 1 хувийг тус тус эзэлжээ.

Уг бирж дээр шууд арилжих /spot/ гэрээгээр бараа, түүхий эдийн арилжааг явуулдаг ба 2015-2016 онуудад бараа, түүхий эдэд суурилсан нэг загварын гэрээ /фьючерс/-ний арилжааг эхлүүлэхээр бэлтгэл ажлуудыг хангаж байна.

#### Шигтгээ 4: Санхүүгийн салбарын хөгжил

Санхүүгийн зах зээлд мэдээлэл тэгш бус байдаг учраас оновчтой хөрөнгө оруулалт хийхийн тулд шаардлагатай мэдээллийг олж авах, боловсруулах нь тодорхой зардалтай байдаг билээ. Мэдээллийн тэгш бус байдал гэдэг нь арилжаанд оролцож буй хоёр тал мэдээллээр харилцан адилгүй байхыг хэлнэ. Тухайлбал, менежер пүүсийн үйл ажиллагааг хэр ашигтай, зохистой явж буй талаар хувьцаа эзэмшигчдээс илүү сайн мэднэ. Мэдээллийн тэгш бус байдал нь муу сонголт (adverse selection), ёс зүйн гажуудал (moral hazard) зэрэг асуудлыг үүсгэдэг. Муу сонголт бол хэлцэл явагдахаас өмнөх мэдээллийн тэгш бус байдалтай холбоотойгоор үүсдэг асуудал юм. Тухайлбал, зээл олгогч муу зээлдэгчдийг сайн зээлдэгчдээс бүрэн ялгаж, таних нь төвөгтэй ба муу сонголт ихсэхийн хэрээр муу зээл нэмэгддэг учраас зээл олгогчид зах зээлд сайн зээлдэгчид байгаа хэдий ч олгох зээлээ багасгаж, эрсдэлээс болгоомжилдог. Түүнчлэн хөрөнгийн зах зээлд муу сонголтын асуудал түгээмэл тохиолдоно. Хөрөнгө оруулагч хувьцаа худалдаж авахын өмнө хувьцаа гаргагч компанийг сайн, муу эсэхийг төдийлөн сайн мэдэхгүй бөгөөд дампуурах гэж буй компанид хөрөнгө оруулах эрсдэлтэй. Харин ёс зүйн гажуудал нь хэлцлийн дараа үүсдэг байна. Зээлдүүлэгч олгосон зээлийнхээ зарцуулалтанд бүрэн хяналт тавьж чаддаггүй ба зээлдэгч гэрээнд зааснаас бусад зориулалтаар зарцуулах магадлалтай. Ёс зүйн гажуудал нь зээлийн эргэн төлөлтийн магадлалыг бууруулдаг тул шинээр зээл олгох сонирхлыг сулруулдаг. Товчхондоо, муу сонголт ба ёс зүйн гажуудал нэмэгдэхэд зээл олгогчийн зээлдүүлэх сонирхол буурна.<sup>35</sup> Мэдээллийн тэгш бус байдлаас үүсч буй эдгээр шинжүүд нь эдийн засгийн харилцаанд нэмэлт зардлыг бий болгож, улмаар эдийн засагт сөргөөр нөлөөлдөг байна.

Чөлөөт зах зээлийн үндсэн таамаглалуудын нэг болох мэдээллийн тэгш байдал хангагдаагүйгээс шалтгаалсан эдгээр зардлууд нь санхүүгийн гэрээ хэлцлүүд, санхүүгийн зах зээл болон санхүүгийн зуучлалын үйл ажиллагааг шинээр бий болгох хэрэгцээ шаардлагыг үүсгэсэн. Зах зээлд учирдаг эдгээр зардлуудыг бууруулах нь санхүүгийн бүтээгдэхүүнүүдийг шинээр санаачлан гаргах, цаашлаад санхүүгийн байгууллагуудыг үүсгэн бий болгох анхдагч шаардлага байв. Түүнчлэн төрөөс дээрх зардлуудыг бууруулах, нөөцийн хуваарилалтын үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор тодорхой эрх зүйн зохицуулалтуудыг бий болгон, дэмжин ажилладаг. Улс орнуудын санхүүгийн салбарын хөгжил, эдийн засгийн харилцаан дахь хэлцлийн зардлыг бууруулсан байдал нь харилцан адилгүй юм.

Санхүүгийн салбарын хөгжлийг сонгодог утгаар нь санхүүгийн хэрэгслүүд, зах зээл, зуучлагчид нь мэдээллийн тэгш бус байдлаас үүсэх сөрөг нөлөөлөл болон хэлцлийн зардлыг бууруулж байгаа байдлаар авч үзэх нь түгээмэл суурь ойлголт юм.<sup>36</sup> Тухайлбал, зээлийн мэдээллийн сан зээлдэгчдийн дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулж, боломжит зээлдэгчдийг тодорхойлоход чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд энэ нь эдийн засагт нөөцийг оновчтой хуваарилах үндэс болж, эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлдэг. Түүнчлэн хууль, эрх зүйн зохицуулалт үр ашигтай байснаар хөрөнгө оруулагчдын үнэт цаас эзэмших итгэлийг нэмэгдүүлж, хөрөнгө оруулалтыг дэмжинэ.

Гэсэн хэдий ч санхүүгийн салбарын хөгжлийг “...санхүүгийн салбарын мэдээллийн тэгш бус байдлын нөлөөллийг бууруулах...” хэмээн тодорхойлох нь хэт онолын тодорхойлолт байж болно.

<sup>35</sup> Mishkin (2004), “Economics of money, banking, and financial markets”, 7<sup>th</sup> edition, Addison Wesley.

<sup>36</sup> World Bank (2012), “Benchmarking Financial Systems around the World”, Policy Research Working Paper, WPS6175.



Иймд Дэлхийн банкнаас санхүүгийн салбарын хөгжлийг хэмжих, улс орнуудын үзүүлэлтүүдийг хооронд нь харьцуулах зорилгоор “4x2” аргачлалыг боловсруулсан бөгөөд үүнд үндэслэн холбогдох үзүүлэлтүүдийн өгөгдлийг жилийн давтамжтайгаар шинэчлэн гаргадаг “The Global Financial Database” нэртэй өгөгдлийн сан бүрдүүлсэн. Тэд санхүүгийн салбарын хөгжлийг илэрхийлэх 4 гол шалгуур үзүүлэлтийг санал болгосон. Үүнд: (а) санхүүгийн гүнзгийрэлт (depth), (б) үйлчилгээний хүртээмжтэй байдал (access), (в) үр ашиг (efficiency), (г) тогтвортой байдал (stability).

**Хүснэгт 2.20**

**Санхүүгийн салбарын хөгжлийг хэмжих 4x2 матриц**

	Санхүүгийн байгууллагууд	Санхүүгийн зах зээл
Санхүүгийн гүнзгийрэлт	Хувийн салбарт олгосон зээл, ДНБ-ий харьцаа Санхүүгийн байгууллагуудын нийт актив, ДНБ-ий харьцаа M2, ДНБ-ий харьцаа Хадгаламж, ДНБ-ий харьцаа	Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ (market capitalization) ба дотоодын зах зээлд гаргасан хувийн салбарын бондын үлдэгдлийн ДНБ-д харьцуулсан харьцаа Хувийн салбарын гаргасан бондын ДНБ-д харьцуулсан харьцаа Засгийн газраас гаргасан бондын ДНБ-д харьцуулсан харьцаа Олон улсын зах зээлд гаргасан бондын ДНБ-д харьцуулсан харьцаа Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ, ДНБ-ий харьцаа Арилжаалагдсан үнэт цаасны үнийн дүн, ДНБ-ий харьцаа
Үйлчилгээний хүртээмж	Арилжааны банкинд данстай хүний тоо (насанд хүрсэн 1000 хүн тутамд) Арилжааны банкны салбар, тооцооны төвийн тоо (насанд хүрсэн 100000 хүн тутамд) Арилжааны банкинд данстай хүмүүсийн нийт хүн амд эзлэх хувь Зээл олгогч байгууллагуудад зээлийн түүхтэй компаниудын нийт дүнд эзлэх хувь (бүх компаниудын хувьд) Зээл олгогч байгууллагуудад зээлийн түүхтэй компаниудын нийт дүнд эзлэх хувь (жижиг, дунд хэмжээтэй компаниудын хувьд)	Топ 10 ХХК-аас бусад компаниудын зах зээлийн үнэлгээний нийт дүнд эзлэх хувь Топ 10 ХХК-аас бусад компаниудын арилжаалагдсан үнэт цаасны үнэлгээний нийт дүнд эзлэх хувь Хувийн салбарын гаргасан бондыг дотоодын зах зээлд гаргасан нийт бондын үлдэгдэлд харьцуулсан харьцаа Хувийн салбарын шинээр гаргасан бонд, ДНБ-ий харьцаа
Үр ашиг	Хүүгийн цэвэр маржин Хадгаламж зээлийн хүүгийн зөрүү Хүүгийн бус орлогын нийт орлогод эзлэх хувь Үйл ажиллагааны зардал, нийт активын харьцаа Ашигт ажиллагаа (ROA, ROE) Өрсөлдөөнийг хэмжих индексүүд	Хөрөнгийн зах зээлийн эргэлтийн харьцаа (тухайн хугацаанд арилжаалагдсан хувьцааны үнэ цэнэ, зах зээлийн үнэлгээний харьцаа) Хувьцааны өгөөжийн хамтын хөдөлгөөн Арилжаанд нийтэд гараагүй нууц мэдээлэл ашиглагдах байдал
Тогтвортой байдал	Z оноо* Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт Чанаргүй зээл, нийт зээлийн харьцаа Хөрвөх чадварын харьцаа Бусад	Үнэт цаасны үнийн индексийн хэлбэлзэл Хувьцааны үнийн индексийн тархалтын тэгш хэмийн түвшин (skewness) Бусад

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар, Монголбанк, Үндэсний статистикийн хороо, Сангийн яам.

Тэмдэглэл: \* Z оноо нь санхүүгийн байгууллагын дампуурах магадлалыг үзүүлдэг бөгөөд 1968 онд Edward I. Altman боловсруулжээ.

Эдгээр шалгуур үзүүлэлтүүд нь санхүүгийн салбараас олгож буй үйлчилгээний чанарыг төлөөлнө. Тухайлбал, санхүүгийн гүнзгийрэлт нь санхүүгийн салбараас олгож буй үйлчилгээний хэмжээг ерөнхийд нь харуулна. Харин үйлчилгээний хүртээмжтэй байдал нь иргэд, аж ахуйн нэгжийн санхүүгийн байгууллагууд болон санхүүгийн хэрэгслээр үйлчлүүлэх цар хүрээг илэрхийлэх болно. Улс орнуудын санхүүгийн салбарын хөгжлийн дүр зургийг өргөн хүрээнд харахын тулд Хүснэгт

2.20-д дурдагдсан 4 шалгуур үзүүлэлтүүдийг санхүүгийн институциуд болон хөрөнгийн зах зээлийн хувьд тооцож, харьцуулахыг санал болгосон байдаг.

Дээрх аргачлалын дагуу Монгол Улсын санхүүгийн салбарын үзүүлэлтүүдийг тооцож, олон улсын түвшинтэй харьцуулсанг Хүснэгт 2.21-д үзүүлэв. Тухайлбал, банкны салбарын гүнзгийрэлт, үр ашиг, тогтвортой байдал зэрэг үзүүлэлтээрээ манай улс бага-дунд орлоготой орнуудын дундаж түвшинд, санхүүгийн үйлчилгээний хүртээмжтэй байдлын үзүүлэлтээр дунджаас дээгүүр түвшинд байна. Харин банкнаас бусад санхүүгийн байгууллага болон санхүүгийн зах зээлийн хөгжил ижил орлогын түвшинтэй орнуудын дунджаас нилээд доогуур түвшинд байгаа дүр зураг гарч байна.

### Хүснэгт 2.21

**Монгол Улсын санхүүгийн салбарын хөгжлийн түвшин /Бага-дунд орлоготой орнуудын дундажтай харьцуулахад/**

Санхүүгийн салбарын хөгжлийг хэмжих шалгуур үзүүлэлтүүд:		Харьцуулалт
Санхүүгийн гүнзгийрэлт	А. Санхүүгийн байгууллагууд	Ойролцоо
	-Банк	Ойролцоо
	-Банкнаас бусад санхүүгийн байгууллагууд	Доогуур
	Б. Санхүүгийн зах зээл	Доогуур
Үйлчилгээний хүртээмж	А. Банк	Өндөр
	Б. Санхүүгийн зах зээл	п.а
Үр ашиг	А. Банк	Ойролцоо
	Б. Санхүүгийн зах зээл	Доогуур
Тогтвортой байдал	А. Банк	Ойролцоо
	Б. Санхүүгийн зах зээл	Доогуур

Эх сурвалж: The Global Financial Database, Монголбанк.

Тэмдэглэл: п.а-тоон мэдээлэл олдоцгүй байв.

## САНХҮҮГИЙН САЛБАРЫН ДЭД БҮТЭЦ, ТҮҮНИЙ ИНСТИТУЦИ

### 3.1 ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИНД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ

Санхүүгийн тогтвортой байдлын тайлангийн 4 дэх дугаар гарснаас хойш Монгол Улсын санхүүгийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах чиглэлээр холбогдох хууль, журмуудад хэд хэдэн өөрчлөлт гарлаа.

#### Банкны тухай хууль:

- ◆ Төв банк /Монголбанк/-ны тухай хууль 17 дугаар зүйл /Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүрэг гүйцэтгэх/-д "17.5. Өрийн удирдлагын тухай хуулийн 11.1-д заасан үйл ажиллагаа" гэсэн заалтыг нэмж оруулав.
- ◆ Банкны тухай хуулийн 7 дугаар зүйл /Банк, түүний хараат болон охин компанид хориглох үйл ажиллагаа/-д "7.2.7. Эд хөрөнгийн тухай мэдүүлэг өгөхөөс зайлсхийсэн төлбөр төлөгчийн дансны мэдээлэл авахаар шийдвэр гүйцэтгэгчийн гаргасан хүсэлтийг шийдвэр гүйцэтгэх албаны дарга зөвшөөрсөн" гэж нэмж оруулснаар мэдээлэл авах эрх бүхий этгээдэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх албыг хамааруулжээ.
- ◆ Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай Монгол Банкны Ерөнхийлөгчийн А-58 дугаар тушаалын дагуу Банкны тухай хуулийн холбогдох заалт, Монгол Улсын Их Хурлын 69 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан Төрөөс мөнгөний бодлогын талаар 2015 онд баримтлах үндсэн чиглэлийн 2.1 дэх хэсгийг үндэслэн банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 50.0 (тавин) тэрбум төгрөг болгохоор хугацаат үүргийг үйл ажиллагаа эрхэлж буй банкуудад бий болгон батлав.
- ◆ Монгол Банкны Ерөнхийлөгчийн А-76 дугаар тушаалын дагуу Төлбөрийн систем, түүний оролцогчийн үйл ажиллагаанд газар дээр нь шалгалт хийх журам: Төв банкны тухай хууль, Банкны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль болон МБЕ-ийн тушаалаар батлагдсан төлбөрийн системд хамаарах бодлогын баримт бичиг, журам, заавар, холбогдох шаардлагыг төлбөрийн систем, түүний оролцогч хэрхэн хэрэгжүүлж байгааг газар дээр нь шалгаж, дүгнэлт өгөх, илэрсэн зөрчилд арга хэмжээ авахтай холбогдсон харилцааг зохицуулав.
- ◆ Монгол Банкны Ерөнхийлөгчийн 03/А-80 дугаар тушаалын дагуу Хөрөнгийн хэмжээг тогтоох тухай: ХАХНХамгааллын Сайд бөгөөд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга, Монголбанкны Ерөнхийлөгчийн хамтарсан шийдвэрээр Нийгмийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийг үндэслэн Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдэл хуримтлалын сангаас 2015 онд арилжааны банкинд харилцах, хадгаламж хэлбэрээр байршуулах хөрөнгийн хэмжээг 640.0 (зургаан зуун дөчин тэрбум) төгрөг байхаар тогтоов.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль:**

- ◆ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 40 дүгээр зүйл /Эд хөрөнгийн тухай мэдүүлэг/-д дараах хэсгийг нэмж оруулав: “40.4. Шийдвэр гүйцэтгэгч нь эд хөрөнгийн тухай мэдүүлэг өгөхөөс зайлсхийсэн төлбөр төлөгчийн мөнгөн хадгаламжийн болон харилцах дансны мэдээллийг авах саналыг шийдвэр гүйцэтгэх албаны даргад гаргах бөгөөд шийдвэр гүйцэтгэх албаны дарга уг саналын үндэслэлийг хянана”. Мөн энэхүү хуулийн дараах хэсгийг өөрчлөн найруулав: “40.1. Шийдвэр гүйцэтгэгч шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үүсгэсний дараа төлбөр авагчийн хүсэлтийг үндэслэн төлбөр төлөгчөөс доор дурдсан эд хөрөнгийн тухай мэдүүлгийг авна: 40.1.1. Төлбөр төлөгчийн өмчлөлийн эд хөрөнгө, банкин дахь мөнгөн хөрөнгийн тухай”. Шүүхийн шийдвэр гүйцэтгэгчээс шүүхийн шийдвэр гүйцэтгэхтэй холбогдуулан төлбөр төлөгчийн банк, банк бус санхүүгийн байгууллага дахь хадгаламжийн болон харилцах дансанд байгаа мөнгөн хөрөнгө, үнэт цаасны тухай мэдээллийг гаргуулан авах эрхтэй бөгөөд хэрэв төлбөр төлөгч хадгаламжийн болон харилцах дансны мэдээллийг гаргаж өгөхөөс зайлсхийсэн нөхцөлд тус мэдээллийг банк, банк бус санхүүгийн байгууллагаас авах саналыг шийдвэр гүйцэтгэх албаны даргад гаргаж, тус саналыг үндэслэлтэй гэж үзвэл холбогдох байгууллагад хуульд зааснаар хандаж болохоор зохицуулжээ.

**Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль:**

- ◆ Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйл /Албан татварын хувь хэмжээ/-д “17.2.10.

Монгол Улсын арилжааны банкны гадаад, дотоодын хөрөнгийн биржид гаргасан бондыг худалдан авсан Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн бондын хүүгийн орлогод 10 хувиар” гэсэн заалтыг нэмж оруулав. Банк гадаад зах зээлээс зээлийн эх үүсвэр татахад хөрөнгө оруулагч талаас хүүгийн орлогоосоо аливаа татварыг Монгол Улсад суутгуулахгүй байхыг шаарддагаас үүдэн банк хуулийн дагуу татварыг улсын төсөвт төлж, улмаар эх үүсвэрийн өртөг нэмэгддэг. Татвараас бий болсон эх үүсвэрийн нэмэгдсэн өртгийг зээл авч буй бизнес эрхлэгчдийн зээлийн хүүд тодорхой хувиар шингээн тогтоож, бизнес эрхлэгчдэд дарамт болж байв. Энэхүү хуульд дээрх нэмэлт, өөрчлөлтийг оруулснаар банкны зээлийн өртөг буурч, бизнес эрхлэгчдэд ирэх хүүгийн дарамт бууран, улмаар гадаад зах зээлээс хямд эх үүсвэр татах сонирхол нэмэгдэн, гадаад валютын урсгал нэмэгдэх боломжтой болсон. Энэхүү хуулийн заалт 2015 оны 1 дүгээр сарны 1-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж байна.

- ◆ Банкны тухай хуулийн 11 дүгээр зүйл /Төлбөр тооцооны үйлчилгээ/-д “11.6.Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын орлогыг олгох үйлчилгээнд төлбөр тооцооны үйлчилгээний хөлс тооцохгүй.” гэж нэмж оруулснаар НӨАТ-ын урамшууллын орлогыг олгох үйлчилгээнд банк үйлчилгээний хөлс тооцож авахгүй болов.
- ◆ Банкны тухай хуулийн 37 дугаар зүйл /Төлбөр тооцооны үйлчилгээ/-д “37.1.Банкны санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан бүрэлдэхүүнтэй байна.” гэж өөрчлөн найруулсанаар санхүүгийн тайлан нь

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан бүрэлдэхүүнтэй байхаар зохицуулсан.

**Үнэт цаасны зах зээл:**

- ◆ Гадаадын үнэт цаасыг Монголын үнэт цаасны зах зээлд арилжаалах нөхцлийг бүрдүүлэх зорилтын хүрээнд “Үнэт цаасны бүртгэлийн журам”, “Хадгаламжийн бичгийг бүртгэх, нийтэд санал болгон арилжих тухай журам”-ыг тус тус баталсан. Цаашид уг үнэт цаасыг хөрөнгийн бирж дээр бүртгүүлэн арилжаалах, түүний хадгалалт, төлбөр тооцооны тогтолцоог бүрдүүлэхээр ажиллаж байна. Төрийн зохицуулалтын зарим чиг үүргийг шилжүүлэх зорилгоор “Өөрийгөө зохицуулах байгууллагын журам”, мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг бий болгож, улмаар зах зээлийг дэмжих зорилгоор “Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам”, “Хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журам”, “Хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгүүлэх тухай журам” Хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны тухай журам”, Хувийн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны тухай журам”-уудыг тус тус батлан гаргаад байна.

**Даатгалын зах зээл:**

- ◆ Албан журмын даатгалын шинэ хэлбэрүүдийг бий болгох зорилгоор зохих судалгаа хийсний үндсэн дээр даатгалын зарим хууль тогтоомжийг шинээр боловсруулж, даатгалын багц дүрмэнд

орсон журам, шаардлагуудад нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулжээ.

- ◆ Төр хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх зорилгоор даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг даатгалын мэргэжлийн холбоонд шилжүүлэх судалгааны ажлыг гүйцэтгэж Зөвшөөрлийн хуулийн төсөлд Эмнэлгийн мэргэжилтний хариуцлагын даатгалын тухай хуулийн төсөлд даатгалын чиглэлээр тодорхой зохицуулалтуудыг тус тус тусгажээ.
- ◆ Даатгалын багц дүрэмд нийт 11 нэмэлт өөрчлөлт оруулав. Үүнд: “Даатгалын компани болон даатгалын мэргэжлийн оролцогчдоос төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох журам”, “Даатгалын бүтээгдэхүүний зохицуулалтыг сайжруулах, хүртээмжтэй даатгалтай холбоотой зохицуулалтын тухай журам”, ”Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын цэвэр хураамжийн хувь хэмжээг шинэчлэн тогтоосон журам”-уудыг шинээр буюу шинэчлэн тогтоож, Давхар даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журам”-ыг шинээр баталсан.
- ◆ Даатгалын компанийн засаглалыг сайжруулах чиглэлээр “Даатгагчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам”, Хадгаламж, зээлийн хоршоог даатгалын төлөөлөгчөөр ажиллах зохицуулалтыг тусган “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-д тус тус нэмэлт оруулан баталж мөрдүүлжээ.

**Бичил санхүү:**

- ◆ Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийг шинэчлэн найруулах хуулийн төсөл дээр дахин ажиллаж Засгийн газрын 2014 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцүүлсэн. Хуралдаанаас санхүүгийн түрээс, ломбард, валютын арилжааны талаарх олон улсын судалгааг ирүүлэхийг үүрэг болгосны дагуу холбогдох судалгааг хийж хүргүүлсэн бөгөөд Улсын Их Хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх зорилт тавин ажиллаж байна.
- ◆ “Хадгаламж зээлийн хоршооны зохицуулалтын журам”-д өөрчлөлт оруулан хадгаламж зээлийн хоршоонд санхүүгийн бусад ажил, үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг нэмж олгоход тавигдах шаардлагатай холбогдсон заалтуудыг хүчингүй болголоо. Түүнчлэн “Хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон дагаж мөрдөх үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-ыг шинэчлэн батлаж, мөрдүүлээд байна.
- ◆ Санхүүгийн зах зээлд оролцогчдын чадавхийг бэхжүүлэх зорилгоор “Зээлийн хүү буурах зах зээлийн орчинг бүрдүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд Банк бус санхүүгийн байгууллага, Хадгаламж зээлийн хоршоодыг Зээлийн мэдээллийн санд хамруулан зээлийн мэдээллийн санд

өгөгдөл дамжуулах “Microfinance” программыг үнэ төлбөргүйгээр суулган ашиглахыг зөвлөн ажиллажээ. Үүний үр дүнд 2014 оны жилийн эцсийн байдлаар 52 хадгаламж зээлийн хоршоо, 322 банк бус санхүүгийн байгууллага Монголбанктай гэрээ байгуулж, зээлийн мэдээллийн сантай холбогдоод байна. Мөн Хадгаламжийн даатгалын тогтолцоог нэвтрүүлэн хадгаламж зээлийн хоршоодыг хадгаламжийн даатгалд хамрагдан хоршоо бүр хадгаламж хамгааллын санг байгуулж ажиллах шаардлагыг "Хадгаламж зээлийн хоршооны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон дагаж мөрдөх үзүүлэлтийг тооцож хяналт тавих журам"-аар зохицуулав.

- ◆ Банк бус санхүүгийн байгууллагуудыг Монголбанкны гадаад валютын дуудлага худалдаа болон своп, форвард хэлцэлд оролцуулах асуудлыг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр шийдвэрлэсэн. Үүний үр дүнд Худалдаа Хөгжлийн Банк, Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо болон валютын арилжааны эрхтэй банк бус санхүүгийн байгууллагууд хамтран “Хамтын ажиллагааны гурван талт гэрээ” байгуулсан бөгөөд банк бус санхүүгийн байгууллагууд Монголбанкны гадаад валютын дуудлага худалдаанд 2014 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн оролцох боломж нээгдээд байна.

**3.2 ТӨЛБӨР ТООЦОО, ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛИЙН СИСТЕМ****Их дүнтэй төлбөр тооцооны систем**

Төлбөрийн системийн оролцогч хоорондын их дүнтэй төлбөр тооцоог Монголбанкны Банкслэжээ системээр бодит цагийн

горимоор гүйцэтгэж байгаа нь төлбөр тооцооны системийн эрсдэлийг бууруулах, мөнгөн урсгалыг бодит цагаар хянах,

мөнгөний бодлогын хэрэгжилтийг сайжруулах, заавал байлгах нөөцийг хангуулах боломжийг бүрдүүлдэг.


Их дүнтэй төлбөр тооцооны системээр банк хоорондын төлбөр тооцоо, Сангийн яамны Төрийн сангийн газрын төлбөр тооцоо, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвийн төлбөр тооцоог нэг бүрчлэн бодит цагаар гүйцэтгэж, үр дүнг тооцож байна. Түүнчлэн бага дүнтэй төлбөр тооцооны системийн үр дүнгийн тооцооллыг хааж, оролцогчийн Монголбанкн дахь харилцах дансанд тусгадаг.

Сүүлийн дөрвөн жилийн байдлаар төлбөрийн системийн нийт гүйлгээний дүнгийн 98 хувь, гүйлгээний тооны 6-18 орчим хувийг их дүнтэй төлбөр тооцооны системээр дамжуулж байгаагаас үзэхэд энэхүү систем нь банк, санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн

тогтвортой байдлыг хангахад нэн чухал ач холбогдолтой болохыг харуулж байна.

### Дүрслэл 3.1

Их дүнтэй төлбөр тооцооны системийн нэг өдрийн дундаж үзүүлэлт



Эх сурвалж: Монголбанк


### Бага дүнтэй төлбөр тооцооны систем

Үндэсний цахим гүйлгээний төв нь банк хоорондын бага дүнтэй гүйлгээ, Сангийн яамны Төрийн сангийн газрын бага дүнтэй гүйлгээ, банк хоорондын төлбөрийн картын гүйлгээг бодит цагийн горимоор дамжуулж, үр дүнгийн тооцооллыг цэвэршүүлж, Банксүлжээ системээр дамжуулан банкны харилцах дансанд тусгадаг.

Сүүлийн дөрвөн жилийн байдлаар бага дүнтэй төлбөр тооцоо нь төлбөрийн системийн нийт гүйлгээний дүнгийн 2 орчим хувийг, харин гүйлгээний тооны 82-94 хувийг тус тус эзэлж байна. Олон тооны хэрэглэгчийн төлбөр тооцоог хамарч байдаг энэхүү системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хангах нь харилцагчийн банкинд итгэх итгэлийг хадгалах, ингэснээр санхүүгийн системийн тогтвортой байдалд нөлөө үзүүлэх ач холбогдолтой юм.

### Дүрслэл 3.2

Бага дүнтэй төлбөр тооцооны системийн нэг өдрийн дундаж үзүүлэлт



Эх сурвалж: Монголбанк

### Төлбөрийн систем

Монгол Улсын төлбөрийн системийн найдвартай, тасралтгүй, үр ашигтай ажиллагааг хангаж, олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх чиг үүргийн дагуу Монголбанкнаас бэлэн бус төлбөр тооцоог дэмжих, шинэ дэвшилтэт төлбөрийн хэрэгслийг нэвтрүүлэх, эрх зүйн орчныг бүрдүүлэх бодлого баримтлан ажиллаж байна.

Төлбөрийн системийн оролцогчдын хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, системийн үр ашигтай байдлыг дээшлүүлэх зорилготой Төлбөр тооцооны үндэсний зөвлөлийн ээлжит XV хуралдааныг зохион байгуулж, Үндэсний цахим гүйлгээний төвөөс хийгдэж буй ажлуудыг танилцууллаа. Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс “Хөрөнгө оруулалтын сангийн тухай журам”-ыг хурлаар хэлэлцүүлэн, санал солилцсон.

Монгол Улсын үндэсний төлбөрийн системийг 2015-2020 онд хөгжүүлэх стратеги, төлөвлөгөөг батлуулах, төлбөрийн системийн хууль, эрх зүйн орчныг сайжруулах, хяналтын чадавхийг бэхжүүлэх зорилго

бүхий техник туслалцааны төслийг Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Үүний дагуу Монгол Улсын төлбөрийн системийн өнөөгийн байдалтай танилцаж, үнэлгээ өгөх зорилгоор Дэлхийн банкны ажлын хэсэг 2015 оны 3 дугаар сард хүрэлцэн ирж ажилласан. Ажлын хэсгийн зүгээс төлбөрийн системийн оролцогч болох Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, банкууд болон ҮЦТТХТ-тэй уулзаж, төлбөрийн системийн өнөөгийн байдал, ойрын ирээдүйд авч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээний талаар санал солилцсон.

УИХ-ын 2015 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн нэгдсэн чуулганаар Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан “Төлбөрийн системийн шинэчлэл төсөл”-ийн зээлийн хэлэлцээрийг соёрхон баталсан. Төслийн хүрээнд төлбөр тооцооны системүүдийг шинэчлэн сайжруулахын зэрэгцээ банк хоорондын цахим нэхэмжлэлийн системийг агуулсан АСН (Automated Clearing House)-г нэвтрүүлэхээр тусгасан болно.

### Төлбөрийн системийн хяналт

Төв банк нь төлбөр тооцооны системд хяналт тавих, үнэлгээ хийх, шаардлагатай үед өөрчлөлт оруулах замаар үндэсний төлбөрийн системийн найдвартай, үр ашигтай ажиллагаанд дэмжлэг үзүүлж байдаг. Төлбөрийн системийн найдвартай ажиллагааг хангах, харилцагчдын эрх ашгийг хамгаалах ажлын хүрээнд техник, технологийн хөгжилтэй зэрэгцэн төлбөр тооцоонд шинээр нэвтэрч буй төлбөрийн хэрэгсэл, үйлчилгээг судлан, системийн оролцогчдод холбогдох зөвшөөрлийг олгож,

хяналт тавин ажиллаж байна. Зах зээлд шинээр мобайл ПОС-ын үйлчилгээ нэвтрүүлж буй банкуудын техник, тоног төхөөрөмж, програм хангамж зэрэг нь олон улсын стандарт, шаардлага хангаж буй эсэхийг судалж, холбогдох дүгнэлтийг хүргүүлэн, гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч байна.

Олон улсын төлбөр тооцооны банк болон Үнэт цаасны хороодын олон улсын байгууллагаас гаргасан “Санхүүгийн зах



зээлийн дэд бүтцийн зарчим”-ын хэрэгжилт төлбөр тооцооны системүүдийн хэмжээнд хангагдаж байгаа эсэхийг тодорхойлох, хэрэгжилтийн түвшинг ахиулах, тогтмол хангуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор “Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийг үнэлэх аргачлал” баримт бичгийг боловсруулан гаргалаа.

Төлбөрийн системийн оролцогч нь төлбөрийн системд хамаарах бодлогын баримт бичиг, журам, заавар, холбогдох шаардлагыг хэрхэн хэрэгжүүлж байгааг газар дээр нь шалгаж, дүгнэлт өгөх, илэрсэн зөрчилд арга хэмжээ авахтай холбогдсон үйл ажиллагааг зохицуулсан “Төлбөрийн систем, түүний оролцогчдод газар дээрх шалгалт хийх журам”-ыг боловсруулан батлуулж, мөрдөн ажиллаж байна. Тайлант хугацаанд төлөвлөгөөний дагуу Их дүнтэй төлбөр тооцооны Банксүлжээ систем, Бага дүнтэй төлбөр тооцооны систем, оролцогчдын их, бага дүнтэй төлбөр тооцооны систем, Свифт

сүлжээний үйл ажиллагаа, Засгийн газартай хамтран ажиллах ажлын хүрээнд Үндэсний цахим гүйлгээний төвөөр дамжин хийгдэж буй Хүний хөгжил сангаас хүүхдэд олгох мөнгөн урамшууллын олголтын ажиллагаа болон үндэсний боловсруулах үйлдвэрт ноос, арьс, шир бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд олгох мөнгөн урамшууллын үйл ажиллагааг тус тус шалгалаа. Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах талаар хугацаатай үүрэг өгч, холбогдох арга хэмжээг авч ажилласан.

Төлбөрийн системийн тасралтгүй ажиллагааг хангуулах ажлын хүрээнд “Банксүлжээ” систем, Свифт сүлжээний тасралтгүй ажиллагааны тайланг 14 хоногийн давтамжтайгаар, төлбөрийн картын нэгдсэн сүлжээ болон бага дүнтэй төлбөр тооцооны системийн тасралтгүй ажиллагааны тайланг 7 хоногийн давтамжтайгаар гарган, хяналт тавин ажиллаж байна.

### 3.3 САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Төвбанкны тухай хууль болон Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (Зөвлөл)-ийн ажиллах дүрэмд заасны дагуу Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь түүний ээлжит болон ээлжит бус хуралдаан юм. Ээлжит хуралдааныг улирал бүр урьдчилан тогтсон товын дагуу хуралдуулдаг бол ээлжит бус хуралдааны хувьд цаг үеийн шинжтэй асуудлыг хэлэлцэх зорилгоор, аль нэг талын санаачлагаар тухай бүр зохион байгуулдаг болно.

Санхүүгийн тогтвортой байдлын тайлангийн өмнөх дугаар хэвлэгдэж олон нийтийн хүртээл болсноос хойшхи хугацаанд Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл нь урьдчилан тогтсон товын дагуу 2015 оны 1

дүгээр сарын 13, 2015 оны 3 дугаар сарын 13-нд тус тус ээлжит хуралдаанаа хийлээ.

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2015 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаар: (i) “ТУЗ-ийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”-д өөрчлөлт оруулах тухай; (ii) Хэвийн зээлийн эрсдэлийн сантай холбогдох татварын эрх зүйн зохицуулалт; (iii) Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албаны 2014 оны үйл ажиллагааны тайлан; (iv) Монгол Улсын 2015 оны эдийн засгийн төлөв байдал; (v) Монгол Улсын 2015 оны төсвийн тодотголын төслийн тухай; (vi) Засгийн газрын үнэт цаасны арилжааны тухай; (vii) Төрийн сангийн нэгдсэн дансны

тухай; (viii) Ханшийн өөрчлөлтөөс үүдэн улсын төсөвт үүсч буй алдагдлыг багасгах, хэджинг хийх тухай; (ix) Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2015 оны ээлжит хуралдааны товыг тогтоох тухай зэрэг асуудлыг авч хэлэлцсэн. Харин 2015 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаар: (i) Иргэдийн эзэмшиж буй 1072 хувьцааны бүртгэлийн тухай; (ii) Үнэт цаасны арилжааны төлбөр, тооцооны үйл ажиллагааны тухай; (iii) Үнэ тогтворжуулах хөтөлбөрийг Засгийн газарт шилжүүлэх төлөвлөгөө; (iv) Дэлхийн банкны хөгжлийн бодлогын зээлийг авах нөхцөл, авах арга хэмжээ; (v) Хөгжлийн банкны зарцуулалт, засаглалыг боловсронгуй болгох тухай; (vi) Төрийн өмчийн активын удирдлагын нэгж байгуулах тухай; (vii) Гадаад валютын дотоод захын тойм; (viii) Инфляцийн төлөв байдлын тайлан зэрэг асуудлуудыг авч хэлэлцсэн. Хуралдаанаас гарсан шийдвэрийн дагуу Зөвлөлийн гишүүд хариуцсан чиглэлээр тодорхой үүрэг даалгавар өгч, холбогдох газруудад санал, зөвлөмж хүргэн ажиллаж байна.

Санхүүгийн системийн эрсдэлийн үнэлгээ хийх, макро бодлогуудын харилцан уялдааг хангах, макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд санал боловсруулах, Монгол Улсын Санхүүгийн тогтвортой байдлын тайланг хагас жил тутам бэлтгэн, олон нийтэд хүргэх үүрэгтэй, байнгын үйл ажиллагаатай нэгж бий болгохоор шийдвэрлэсний дагуу Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн Ажлын алба (СТБЗАА)-ыг Монголбанкинд төвлөрүүлж, 5 хүний орон тоотойгоор ажиллуулж байна.

СТБЗАА нь Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох газруудтай хамтран ажиллаж, тайлан мэдээлэл хүлээн авч, “Монгол Улсын

Санхүүгийн тогтвортой байдлын тайлан”-гийн эхний дөрвөн дугаарыг нэгтгэн боловсруулж, хэвлүүлэн, Монголбанкны цахим хуудаст байршуулан, олон нийтийн хүртээл болгосон бөгөөд ийнхүү тав дахь дугаарыг та бүхэнд хүргэж байна.